

Ч.Оюунбилэг, Х.Ариунаа, Ш.Ариунчимэг
Ж.Ууганцэцэг

ХӨГЖИМ

VI-VII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
6-7 дугаар ангийн суралчилсан бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

ДАА-373
ННА-74.2
Х-545

Хөгжим VI-VII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 6-7 дугаар ангийн сурах бичиг. (Оюунбилэг Ч., ба бусад; Ред. Бүдхүү Х. -УБ. 2017. - 136х)

“Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99978-61-18-4

ГАРЧИГ

ЗУРГААДУГААР АНГИ. УРЛАГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УРЛАГИЙН ТӨРЛҮҮД

1.1	УРЛАГИЙН ТӨРЛҮҮД.....	6-7
1.2	ДҮРСЛЭХ УРЛАГ БА ХӨГЖИМ.....	8-11
1.3	УРАН ЗОХИОЛ БА ХӨГЖИМ.....	12-19
1.4	ТЕАТР БА ХӨГЖИМ.....	20-22
1.5	БУЖИГ БА ХӨГЖИМ.....	23-26
1.6	КИНО БА ХӨГЖИМ.....	27-32

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨГЖМИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ

2.1	ДУУЛААЧИЙН ХӨГЖИМ.....	33-42
2.2	ДАН ХӨГЖИМ.....	43-54
2.3	ДУУЛЬЯ.....	55-60
2.4	ХӨГЖИМДЬЕ.....	61-70

ДОЛООДУГААР АНГИ. МОНГОЛ АРДЫН ДУУ ХӨГЖИМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ АРДЫН ДУУ ХӨГЖМИЙН ТӨРЛҮҮД


1.1	ӨГҮҮЛЭХ ЭРХТЭНТЭЙ ШҮТЭЛЦЭХ УРЛАГ.....	74-77
1.2	ХӨГЖИМТ АМАН ЗОХИОЛЫН ТӨРӨЛ.....	78-80
1.3	МОНГОЛ АРДЫН ДУУЛАХ УРЛАГ.....	81-87
1.4	МОНГОЛ АРДЫН ХӨГЖИМДӨХ УРЛАГ.....	88-101
1.5	МОНГОЛ АРДЫН БУЖИГЛЭХ УРЛАГ.....	102-113

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ ХӨГЖМИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

2.1	МОНГОЛ АРДЫН ДУУ ХӨГЖМИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ.....	114-124
2.2	ДУУЛЬЯ.....	125-131
2.3	ХӨГЖИМДЬЕ.....	132-136

ЗУРГААДУГААР АНГИ. УРЛАГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ

БИД ЮУ СУДЛАХ ВЭ?



ТАНИХ ТЭМДЭГ



Дуулах



Дасгал ажил,
даалгавар



Хөгжим сонсох



Ажиглах, унших,
ярилцах



Хөгжимдөх

Ая. Ц.Намсрайжав

Үг. Ж.Бадраа

ХАЛУУН ЭЛГЭН НУТАГ
(Түмний нэг киноны дуу)

Удаавтар

5

Э - лэг зурх - нээс у - я - тай Энх-рий Мон - гол ну - таг -
минь Э-цэг э - хээс за - я - тай Эрдэ-нийн ал - тан өл - гий минь Цэц-гийн

Цэцгийн шимийг тэтгэсэн
Цэнгэлийн хавар айлчлахад
Мөрөн голууд дуугаа дуулж
Мөнх сарьдаг нь мишээдэг

Сэргүүн салхи сэвшүүлэн
Хацаар нүүрийг илбэн байж
Сэтгэл дотрыг ариулсан
Халуун элгэн нутаг минь

Кинонд зориулагдан бүтээгдэж ард түмний сэтгэлд хоногшсон уран бүтээл олон бий. Кино найруулагч Д.Жигжиийн “Түмний нэг” кинооос монгол хүн бүрийн сайн мэдэх, дуулах дуртай “Халуун элгэн нутаг” дуу төрсөн юм. “Эх орны тухай сайхан дуу хэрэгтэй байна” гэсэн найруулагчийн хүсэлтээр хөгжмийн зохиолч Ц.Намсрайжав, урлаг судлаач Ж.Бадраа нарын “Халуун элгэн нутаг” хэмээх дуу зохиогдсон түүхтэй. Кинооос төрөн гарсан энэ дуу “ХХ зууны манлай дуу” болон мөнхөрсөн билээ.



“Халуун элгэн нутаг” дууны хөшөө 2002 он

Хүмүүсийг яруу сайханд хөтлөхөд урлагийн зорилго оршино.
Ж.Энеску

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

1.1. УРЛАГИЙН ТӨРЛҮҮД

Д.Нацагдорж

Би монгол хүн

Аргалын утаяа боргилсон
Малчны гэрт төрсөн би
Амар хээр нутгаа
Өлгий минь гэж боддог...

Бертэ хамтлаг
“Говь” зохиомж

Хүн, байгаль
нийгмийн амьдрал

Д.Нацагдорж
“Ламбагуайн нулимс”



Б. Цогоо “Малчин охин”

Уран сайхны арга,
хэрэглүүр

Хүний сэтгэлгээний
бүтээл туурвил



М.Мөнгөнцэцэгийн
дэглэлт
“Сугсраан донж”



Б. Балжинням
“Мөнх тэнгэрийн
хүчин дор”



- “Урлагийн бүтээл” сэдвээр хэлэлцүүлэг хийцгээе. Дараах асуултын дагуу ярилцаарай.
- Дээрх бүтээлүүд юун тухай өгүүлж, юуг тусган илэрхийлж байна вэ?
- Бүтээлийг хэн чухам юугаар, хэрхэн яаж бүтээсэн бэ?
- Эдгээр бүтээлүүд хэнд, юунд зориулагдсан гэж бодож байна вэ?
- Хүмүүст чухам ямар хэрэгцээтэй вэ?
- Та нарын бодлоор урлаг гэж юу вэ?
- Бүтээлүүдийг ажиглаж үзвэл, урлагийн ямар төрлүүд байна вэ?



Д

- Сонирхдог урлагийн төрлөө сонгож, тухайн төрлөөр туурвигдсан бүтээл цуглуулан, багшийн зөвлөгөөөр үзэсгэлэн гаргаарай.
- Бүтээлийн талаар мэдээлэл цуглуулаарай.
- Мэдээллээ дараах байдлаар боловсруулж, өөрийн үгээр ярьж тайлбарлаарай.

Урлагийн бүтээл					
Уран бүтээлч	Д.Нацагдорж	Б.Шарав	Ц.Амгалан	Ж.Чулуун	О.Эрдэнэ Д.Золбаяр Б.Чинбат
Бүтээлийн нэр	Миний нутаг	Сэтгэлийн эгшиг	Ээжээ сайн байна уу?	Уран хас	Аравт
Урлагийн ямар төрөлд хамаарах	Уран зохиол - Шүлэг	Хөгжмийн урлаг - Дан хөгжим	Дүрслэх урлаг - Уран зураг	Бүжгийн урлаг - Бүжгэн жүжиг	Кино урлаг - Уран сайхны кино
Илэрхийллийн арга	Уран үг	Аялгуу, хэмнэл	Өнгө, будаг, дүрсийн нийлэмж	Уян налархай хөдөлгөөн	Гэрэл сүүдэр, дүрс
Бүтээлийн санаа	Эх орныхоо байгаль, түүх, соёл, зан заншил, ард түмний амьдрал, бүтээн байгуулалт, хүсэл тэмүүллийг магтан дуулж, эх орноо хайрлах, бахархах, сэтгэлийн илрэл.	Хүний сэтгэлийн гүн дэх хайр, бодол ухаарал, тайтгарал, хүн хүнээ хайрлан энэрэх сэтгэл.	Амьдралыг тэтгэх нарны илч гэрэл шиг эх хүний сэтгэл орчлонгийн хамгийн ариуухан гэгээхэн нь юм. Ертэнцийн наран мөнхөд мандан байдгийн адил ээж болгон үр хүүхдэдээ наран юм.	Хүн бүр хүсэл мөрөөдлөө цуцашгүй хөдөлмөр, гайхамшигт авьяас, уран ухаанаараа амьдруулж, амилуулж чадна.	Нэгэн санаа, нэгдмэл хүч, эв ээийг хичээн түмэн бэрхшээл, мянган зовлонг туулж, баходал, харууслыг хуваалцах үнэнч нөхөрлөл.



1.2. ДҮРСЛЭХ УРЛАГ БА ХӨГЖИМ

Дүрслэх урлаг нь амьдралын тодорхой агшинг нэгэн орон зай, цаг хугацаанд байгаагаар нь биетээр дуурайлгадаг урлагийн төрөл юм. Энэ төрөл нь тухайн үзэгчийн харах мэдрэхүйгээр дамжин сэтгэлийг хөглөж, гоо сайхны мэдрэмж төрүүлдэг. Дүрслэх урлаг тухайлбал уран зургийн бүтээлүүд хөгжмийн зохиолчдын онгодыг хөглөх эх булаг болж улмаар олон бүтээл хөгжмийн зохиол болон амилсан байдаг.



- Хөгжмийн ямар зохиол дүрслэх урлагийн бүтээлүүдийн нөлөөн дор төрснийг харцгаая.

Дүрслэх урлагийн бүтээлээс төрсөн хөгжмийн зохиол

A. Гартман “Хоёр еврей”, “Хуучин цайз”, “Одой хүн” уран зургууд	Оросын хөгжмийн зохиолч М.П.Мусоргский “Үзэсгэлэнгийн зургууд” төгөлдөр хуурын цуврал аяз
B. Верещагин “Мартагдсан хүн” уран зураг	М.П.Мусоргский “Мартагдсан хүн” роман
И.Е.Репин “Запорожийнхан” уран зураг	А.Морозов “Запорож нутгийнхан” марш
А.Микеланджело “Сэтгэгч” уран баримал	Ф.Лист “Сэтгэгч” төгөлдөр хуурын бүтээл
А.Бёклин “Үхэгсдийн арал” уран зураг	С.Рахманинов “Үхэгсдийн арал” симфони найраглал
Ц.Очирбал “Алтан дуулга” уран зураг	Т.Сэр-Од “Алтан дуулга” симфони зураглал
Д.Булгантуяа “Хүслэн” цуврал зургууд	С.Соронзонболд Төгөлдөр хуурын цуврал аяз



Төрийн соёрхолт ардын зураач Ц.Амгалангийн “Ээжээ сайн байна уу?” зургийг хөгжмөөр илэрхийлбэл аялгууны шинж төрх, өнгө аяс, хурд, эгшиглэх хүч нь ямар байхыг төсөөлж бичнэ үү? Энэ дүр зургийг ямар хөгжмийн зэмсгээр илэрхийлбэл тохиромжтой вэ?




М.П.Мусоргский
(1839-1881)

М.П.Мусоргский ХОЁР ЕВРЕЙ

Оросын суут хөгжмийн зохиолч. Түүний бүтээлүүдэд оросын түүх, ахуй соёл, орос ардын дууны утга, уянга гүнзгий шингэсэн байдаг. Энэрэнгүй үнэнийг дуулагч хэмээгддэг тэрээр 5 дуурь, төгөлдөр хуурт зориулсан цуврал аязууд, дуулаачид зориулсан дуу, роман, найрал дуу, найрал хөгжимд зориулсан алдарт бүтээлүүдээрээ нэрээ мөнхөлжээ.



- Оросын зураач А.Гартман, хөгжмийн зохиолч М.П.Мусоргский нарны нэг сэдвээр туурвисан “Хоёр еврей” хэмээх бүтээлийг харьцуульяа.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Ижил сэдвийг урлагийн хоёр өөр төрөл хэрхэн илэрхийлснийг ярилцаарай.

Хөгжим	Баян	Ядуу
Аялгуу ямар регистрт эгшиглэж байна вэ?		
Дүрүүдийг ямар ямар хөгжмийн зэмсгээр илэрхийлсэн бэ?		
Зургийн гол санааг хөгжмөөр хэрхэн илэрхийлсэн бэ?		
Аялгууны шинж төрх ямар байна вэ?		

А.Гартман, М.П.Мусоргский нарны “Хоёр еврей” хэмээх энэхүү сэдвээр өнөөг хүртэл зураачид уран бүтээлээ туурвисаар байна.



Наташа Туровская
“Хоёр еврей” 2005 он

С.Соронзонболд

ГЭГЭЭН ХҮСЛЭН

Дүрслэх урлаг, хөгжим аль аль нь хүний сэтгэл, амьдралыг, бодол хүслийг өөрийн гэсэн аргаар илэрхийлдэг. Гагцүү үзэгч сонсогчид түүнийг өөрийнхөөрөө тайлна.


Зураач Д.Булгантуяа “Хүслэн” хэмээх сэдвээр 20 орчим цуврал зураг бүтээжээ. Тэдгээрээс “Гэгээн хүслэн” бүтээлийнхээ тухай: “Тодорхойгүй бодит бус дүрслэл, зураас, дүрс, хөдөлгөөн, дагнасан, дарагдсан, нэвчиж харагдах өнгө, эрс тэс ялгарамж. Энэ бүхэн хүний төгсгөл үгүй мөнхийн хүслийг илтгэнэ. Хүн өөрийнхөө хүслийг олж мэдэх, харах, ухаарах боломж” хэмээн ярилаа.

Түүний цуврал зургаас төрсөн мэдрэмжээ илэрхийлж хөгжмийн зохиолч С.Соронзонболд “Төгөлдөр хуурын цуврал аязууд” бичсэн байна.


Тэрээр: “Зураачийн бүтээлийг хараад хөгжмийн зохиолчийн сэтгэлд ямар нэгэн төсөөлөл хэм хэмнэл, хөг эгшиг, ая аялгуу буух нь гарцаагүй. Тэрхэн агшинд төрсөн аялгууг эгшиг тэмдэглэгээнд оруулсан. Тодорхой дүрслэлгүй зургаас ямар нэгэн сэжүүр хайлгуй амьдралын олон өнгө будгийг барьж төгөлдөр хуурын эгшгээр гаргахыг хичээсэн” гэжээ.



- “Гэгээн хүслэн” зохиолын гол сэдэв аялгууны ноотыг ажиглаад хөгжмөө сонсоорой.
- Зураачийн гэгээн хүсэл мөрөөдөл чухам юу вэ? Хөгжмийн зохиолч түүнийг өөрийнхөөрөө хэрхэн тайлсан бэ? Ярилцаарай.
- Сонсох үйл, ноотонд хийсэн ажиглалтад тулгуурлан доорх үгийн сүлжээг бөглөөрэй.



Д.Булгантуяа “Гэгээн хүслэн” 2017 он



Босоогоор:

1. Ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсөн байна вэ?
4. Зохиолд ямар хэмжээтэй ноот хамгийн өргөн хэрэглэгдэж байна вэ?
5. Сэдэв аялгууны хамгийн оргил нь ямар эгшиг байна вэ?
7. Ноотны ард тавигдсан цэг ямар үүрэгтэй вэ?
9. Зохиолын хурдыг тодорхойлсон *Allegro* хэмээх үг ямар утгатай вэ?

Хөндлөнгөөр:

2. ♫ Энэ ямар хэмжээтэй ноотны зогсоц вэ?
3. *f* тэмдэглэгээний утга юу вэ?
6. Сэдэв аялгуунд хамгийн холын үсрэлт хэдэн өргийн зйттай байна вэ?
8. Энэхүү аязыг хөгжмийн зохиолч зургийн утга санаа, өнгө будагтай зохицуулж ямар цомнол, дэвсгэр хөгд бичсэн байна вэ?
10. Зохиолын дунд хэсэгт хөгжмийн зохиолч Rit. буюу ритенуто гэсэн тэмдэглэгээ тавьсан байдаг. Энэ юу гэсэн утгыг илтгэх вэ?

Д.Шостакович

VII СИМФОНИ

(Ленинградын)



Д.Шостакович
(1906-1975)

XX зууны оросын суут хөгжмийн зохиолч, төгөлдөр хуурч, нийгмийн зүтгэлтэн, багш. Дмитрий Шостакович нийгмийн түүхэн чухал үйл явдлуудыг хөгжмөөр илэрхийлж, хөгжмийн урлагт гарч байсан шинэ, шинэлэг арга барилуудыг уран бүтээлдээ ашиглаж байв. Тэрбээр 15 симфони, 6 концерт, 3 дуурь, 3 бүжгэн жүжиг, цөөхүүл хөгжим, тайз дэлгээцийн олон арван бүтээл туурвижээ.



- Оросын хөгжмийн зохиолч Д.Шостаковичийн “Ленинградын” хэмээх VII симфонийн зохиолын I ангийн дунд хэсгээс сонсоцгооё.
- Сэдэв аялгууг ямар хөгжмийн зэмсгүүдээр хөгжимдөж байна вэ?
- Хэмнэлээр хөгжимдөрэй. Давталттай хэсэг байна уу?
- Хэмнэл, аялгууны шинж төрх юу илэрхийлж байна вэ?
- “Довтолгоон” гэж нэрлэгдсэн энэ сэдэв аялгууны ноотыг ажиглаад, ижил төстэй хэсгүүд байгаа эсэхийг тодорхойлоорой.

Энэ хөгжим нь цасан нуранги мэт ойртоож буй дайсны давшилтыг илэрхийлнэ.

Allegretto

The musical score consists of two staves. The top staff is in G major (indicated by a C-clef) and 4/4 time. It contains a single melodic line with quarter notes and rests. The bottom staff is in A major (indicated by a F-sharp-clef) and 4/4 time. It features a rhythmic pattern of eighth-note pairs repeated across the measures.



Уран зохиол, хөгжим, уран зураг сонирхох чадвараа алдана гэдэг аз жаргалаа алдсантай адил. Ч.Дарвин

1.3. УРАН ЗОХИОЛ БА ХӨГЖИМ

Уран зохиолыг урлагийн хамгийн эртний төрөл гэж үздэг. Эрт үеэс хүмүүс ан гөрөөнд явахдаа тэнгэр газар, уул усандаа мөргөн залбирч, хишиг буяныг нь гүйхдаа уран холбоо үгсийг айзам хэмнэлтэй хослуулан хэрэглэж байжээ. Ийнхүү амьдралын хэрэгцээ, бодит шаардлагаар үүссэн урлагийн нэг төрөл нь уран зохиол юм.

Уран зохиол нь хүн, юмс үзэгдэл, үйл явдлыг яруу сайхан үг хэллэгээр илэрхийлдэг онцлогтой, үгийн урлаг юм.

Хөгжмийн зохиолчид урлагийн бусад төрлөөс санаа авч бүтээлээ туурвидгийг бид “Дүрслэх урлаг ба хөгжим” сэдвээс мэдэж авсан. Харин уран зохиолын баатруудыг хөгжмийн хэлээр амилуулж, хүний зүрх сэтгэлд хүргэсэн олон арван бүтээл бий.

Уран зохиолын төрлүүд хөгжимд





- Их зохиолч Д.Нацагдоржийн ямар зохиолууд хөгжмийн бүтээл болсон бэ?
- Д.Нацагдоржийн уран бүтээлээс сэдэвлэж хөгжмийн бүтээл туурвисан ямар зохиолчдыг мэдэх вэ?
- Хөгжмийн бүтээл болон амилсан Д.Нацагдоржийн уран бүтээлийн тухай мэдээлэл цуглуулаарай. www.google.mn

Д.НАЦАГДОРЖ БА МОНГОЛЫН ХӨГЖИМ



Д.Нацагдорж
(1906-1937)

Монголын орчин цагийн уран зохиолыг үндэслэгч, зохиолч, яруу найрагч, соён гэгээрүүлэгч Дашдоржийн Нацагдорж. Түүний “Ушаандар”, “Сандо амбаны харгис явдал”, “Учиртай гурван толгой” жүжиг, “Миний нутаг”, “Од” зэрэг олон арван шүлэг, “Хуучин хүү”, “Цагаан сар ба хар нулимс” өгүүллэг зэрэг сор болсон олон бүтээлүүд нь хойч үедээ өвлөгдөн үлдсэн билээ.



- | | | |
|---|---|--|
| <ul style="list-style-type: none"> - “Ламбагуайн нулимс” өгүүллэг - “Учиртай гурван толгой” жүжгийн зохиол - “Миний нутаг” шүлэг |  | <ul style="list-style-type: none"> - Х.Билэгжаргал “Ламбагуайн нулимс” дуурь - Б.Дамдинсүрэн “Учиртай гурван толгой” дуурь - Ч.Сангидорж “Миний нутаг” магтуу |
|---|---|--|



Б.Дамдинсүрэн Түүхтэй.

Д.Нацагдорж монгол ардын харилцаа дууг ихэд сонирхон жүжгийн зохиолдоо ашиглаж байжээ. XIX зууны үед монгол газар ихэд дэлгэрсэн Да Вангийн Юндэн Гөөгөө гэдэг ардын харилцаа дуунаас санаа авч “Учиртай гурван толгой” зохиолоо бичжээ. Энэ бүтээлээр төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Б.Дамдинсүрэн 1942 онд “Учиртай гурван толгой” хэмээх дуурь бичсэнээр монголд дуурийн урлаг үүсч хөгжсөн түүхтэй.

Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Х.Билэгжаргал 1985 онд их зохиолч Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” өгүүллэгээр дуурь бичжээ. Энэхүү өгүүллэг нь хөгжмийн томоохон хэмжээний бүтээл болон амилсан нь Д.Нацагдоржийн зохиолын агуулгын баялаг цар хүрээг илтгэж байгаа юм.



Х.Билэгжаргал



Ч.Сангидорж

Байгаль, эх орондоо хандах хүний яруу сайхан хандлагыг илтгэсэн зохиол бол Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг юм. Энэ шүлэгт Алтай, Хангайн нуруудаас Хэнтий, Хянганы уулс, Орхон Сэлэнгийн бэлчрээс Мэнэн Шаргын говийг хүртэлх уудам дэлгэр нутгаа бахархан дүрсэлсэн байдаг. Энэхүү шүлэг хөгжмийн зохиолч урлагийн гавьяат зүтгэлтэн Ч.Сангидоржийн уран бүтээлд “Миний нутаг” магтуу болон цуурайтсан.



МОРИН ХУУР, НАЙРАЛ ХӨГЖМИЙН КОНЦЕРТ ("Хүрэн морь" найраглалаас сэдэвлэв)

Хөгжмийн зохиолчид яруу найраг, шүлгийн санаанд тулгуурлан зохиолоо түүрвидаг. Уран зохиолын нөлөөгөөр хөгжмийн алдартай олон зохиолууд төрсөн байдаг. Жишээ нь: Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Т.Сэр-Од, Төрийн соёрхолт, найрагч Ч.Лхамсүрэнгийн "Хүрэн морь" найраглалаас сэдэвлэн морин хуур найрал хөгжмийн концертоо бичжээ.



- Хүрэн морь найраглалыг хөгжмийн хэлээр хэрхэн илэрхийлснийг ярилцаарай.
- Хөгжмөө сонсоод, сэдэв аяыг ноотоор аялаарай.

Оршил

A



Өнгө бүрийн тогтороос
Өөрийн зорилгоор салсан сан.
Өвч тураг бие минь
Өстөн хортонд бариулах нь уу?
Өлөн чононд хөөгдсөн ч
Өлгий нутагтгаа дөхье
Өлслгелөн махчинд ээрэгдсэн ч
Өнөр ижилдээ ойртъё.
Хурдан сайн удамтай билээ
Хурц дөрвөн тууртайтай билээ
Хуй шиг хийсээд гаръя
Хулан шиг дайраад үзье.

B



Өрөвдэж хайрладаг эзнээс салж
Өхөдгүй хүний хөл болоод
Төрсөн нутгаас холдох
Түмний газар чиглэхдээ
Хань ижилдээ тэмүүлж
Халамжит эээндээ хоргодоод
Ханаарн эргэн хөндөлдөвч
Хазаар дараан булаалдавч
Хатан темрийн хүчинд
Халуун амаа мэдүүлсээр
Хатуу модон ташуурт
Хаа, гуяа мэдүүлсээр
Жороо хүрэн морь
Жолоо цулбууртаа хумигдav
Жолоо цулбуур хоёр нь
Зодоч ламд хумигдav.

C



Тормогор хар нүдний нь
Тодхон соргог хараанд
Хурдан жороо морь нь
Хуй тоос босгоод
Хангинатал чанга унгалдаж
Хатиран айсүй харагдav.
Баярын халуун амьсгал
Байж тогтон үймэх шиг
Бат цагаан цээжнээс
Багтаж ядан гараад
Үйлж хавдсан нүдий нь
Угааж өгөх гэсэн шиг
Уярлын зөөлөн нулиms
Улам улам асгараад
Итгэлт морь минь ирлээ! гэж
Эзжийгээ дуудах шахлаа.

Каденц¹

B1



¹ Каденц - XVI зуунаас дуучин, хөгжимчний ур чадварыг харуулах хэсгийг (өөрөө шууд зохиомжилсон, эсвэл хөгжмийн зохиолч бичсэн) ийнхүү нэрлэх болжээ. Н.Жанцанноров "Хөгжмийн онолын нэр томьёоны хураангуй тайлбар толь" 38-р тал.





Чөлөөтэй

6



Цоглог, хурдан



Тайван, чөлөөтэй



3



- Ч.Лхамсүрэн “Хүрэн морь” найраглалыг уншаарай.
- Ноот бичлэгийг ажиглан, хөгжмийн зохиолч хэсэг тус бүрд хүрэн моринд тохиолдож буй үйл явдлыг ямар арга хэрэглүүрээр илэрхийлснийг дэвтэртээ бичээрэй.

Арга Хэсэг	Хурд	Хэмнэл	Хөгжимдөх арга
A			
B			
C			

Ш.Өлзийбаяр

286 ДУГААР ГАЛТ ТЭРЭГ



Хөгжмийн зохиолч, багш. Тэрээр 200 гаруй бүтээл туурвисан. “Дөрөө” модерн бүжгэн жүжиг, “Ээрэн хүрээ” дуулалт бүжгэн жүжиг, “Хөмөргэн гурвалжин”, “Тамганы бүжигчин” бүжгэн жүжгүүд, морин хуурын концерттууд, төгөлдөр хуур найрал хөгжмийн “Вариац токката”, “Монгол түмний хийморь” магтуу, чавхдаст хөгжмийн дөрвөл, “Би Монгол”, “Дорнын говиос Монгол эхэлдэг”, “Талын хөх чоно”, “Нүүдэлчдийн нутаг” дуунууд.

Шатарын Өлзийбаяр




Хөгжмийн зохиолч бүтээлийнхээ тухай

Оюутан болсон цагаасаа Улаанбаатар-Сайншандын чиглэлд 286 дугаар галт тэргээр зорчсоор галт тэрэгний жигд хэмнэл, дуут дохио чихэнд минь хоногшсон юм. Энэ зохиолыг бичих санаа нутгийн яруу найрагч А.Эрдэнэ-Очирын “Дорнговь руу галт тэрэг хөдлөхөд” шүлгээс анх төрсөн.

Хурдаа авсан галт тэрэгний жигд хэмнэл болон дуут дохиог дүрсэлсэн аялгуугаар зохиол эхэлнэ. Гол сэдэв аялгууг хоёр давтсаны дараа бүтээн байгуулалтыг санагдуулам туслах аялгуу эгшиглэнэ. Зохиол цааш өрнөн олон янзын аялга, хэмнэлээр баяжихдаа төмөр замчдын сүлд дуу болох Л.Мөрдоржийн “Ган зам” дууны аялгуугаар өрнөнө. Зам нийлэх, салах үед галт тэрэгний жигд хэмнэл үе үе догоолдог. Үүнийг тэгш бус 5/8 хэмээр илэрхийлсэн. Харин цэлгэр уудам талаар өдөржин давхих галт тэрэгний хурд төдийлөн өөрчлөгдөхгүй. Энэхүү симфони зураглал их бүтээн байгуулалт, өрнүүн үе, эрчимт хөдөлмөрийг санагдуулна.



- Зураглалын дагуу хөгжмөө сонсоорой.
- Галт тэрэгний дуут дохиог ноот бичлэгийн дагуу сонсоорой.
- Жижиг бөмбөрийн хэмнэлээр галт тэрэгний урагшлах хөдөлгөөнийг хэрхэн дүрсэлснийг анхаарч сонсоно уу?
- Хэмнэлээр хөгжимдөөрэй.



- Зохиолын хурд, айзам хэмнэл, хүчдэлийн талаар ярилцаарай.
- Зохиолоос Л.Мөрдоржийн “Ган зам” дууны аялгууны хэсгийг сонсож тодорхойлоорой.




Д

- Ч.Лодойдамбын “Шаргачин” өгүүллэгийн хэсгээс уншаад дүрүүдийг тодорхойлоорой.
- Доорх хэсэг тус бүрт нэр өгөөрэй.
- Хөгжмөө анхааралтай сонсоод, аль хэсгийг дүрсэлснийг тодорхойлоорой.
- Хөгжмийн зохиолч тухайн дүрийн онцлогийг хөгжмийн ямар арга хэрэглүүрээр илэрхийлсэн бэ?


Ч.Лодойдамбын “Шаргачин” өгүүллэгээс сэдэвлэн хөгжмийн зохиолч Б.Мөнхжаргал “Шаргачин” хэмээх симфонио бичжээ.

Б.Мөнхжаргал


“ШАРГАЧИН” СИМФОНИ

Хаврын хурц нар нэлээд дээр мандаад ойр орчмыг хөхөмдөг манан бүрхэж, өргөн талд байгаа юмс цөм зэрэглэн жирвэлзэж байлаа. Цайдам хөндийн зүүн зах нь болсон хэсэг дээрс рүү эхээс гарад хэдхэн хоносон цайвар цагаан янзагаа дагуулсан шаргачин орж ирлээ. Янзага нь тонгочин тоглож орчин тойронд өөрөөс нь өөр юмгүй мэт бүхнийг мартан явахад нь эх нь тал бүр сэргэлзэн өчүүхэн чимээг ч сэргэмжлэн чагнаж нүдэнд нь торсон бүхнийг «Юу вэ?, Яах гэж байна?» гэсэн бололтой нарийвчлан ажиглаж явлаа.

Уураг нь дуусаагүй өөг сүүндээ гэдээс нь цадсанаас ч юм уу нялх бие нь тоглоомдоо ядарснаас ч юм уу? Аль зуун жилээр үргэлжилсэн хатуу амьдралын сургаал ч юм уу? Бүү мэд. Юу ч гэсэн дээрсэнд орсны дараа удалгүй янзага нь нуугдан унтав.



Цонхоор нь буунууд шоролзон гарсан машин, зээрийн хойноос байдаг хурдаар довтлон ирлээ. Хурдан хөлдөө гүн итгэсэн шаргачин дүүлж дөрвөн хөл нь газар хүрч байгаа эсэх нь үл мэдэгдэн хурдлав.




Гүйцэгдэхгүй, оногдохгүй байх чинь яагаав? гэж нэг нь хэлээд нөгөө нэг нь шаргачны дэргэд ташаагаа тулж ханхалзан зогсоход тэрийн хэвтэж бүх бие нь үхлийн өмнөх чичрэлтээр татганаж байгаа шаргачин эцсийн хүчээ дайчлан янзагаа нуусан зүг рүү амьдралын оч орхин хаяж байгаа нүдээр харлаа....

Янзага

Musical notation for the 'Yanzaga' section of the symphony, in 2/4 time, major key, dynamic *mf*.

Шаргачин

Moderato



Үрээ
гэх эхийн
хайр энэрэл

Сувдаг шунахай,
харгис хэрцгий үйл

Эх үрийн
хагацал гуниг,
сүйрэл, мөхөл

Байгаль эх дэлхийдээ зүй бусаар хандахын хор уршгийг сануулж, хайрлах сэтгэлийг биднээс нэхнэ.



Н.А.Римский-Корсаков
(1844-1908)

Оросын суут хөгжмийн зохиолч, удирдаач, шүүмжлэгч, сурган хүмүүжүүлэгч Николай Андреевич Римский-Корсаков 15 дуурын, 10 симфони, 3 магтуу, романс, цөөхүүл хөгжмийн бүтээлүүд туурвижээ. Түүний бүтээлд үлгэр домог, байгалийн сэдэв голчилдог.

Н.А.Римский-Корсаков

“ШЕХЕРАЗАДА” СИМФОНИ ЧУУЛБАР

“Шехеразада” бол Оросын сонгодог хөгжмийн гайхамшигт бүтээлийн нэг. Хөгжмийн зохиолч Н.А.Римский Корсаков “Шехеразада” симфони чуулбараа дорно дахины араб ардын “Мянга нэгэн шөнийн үлгэр”-ээс сэдэвлэн 1888 онд бичжээ. Энэхүү симфони чуулбар (сюит) 4 ангитай, анги тус бүр нь нэртэй, хөтөлбөрт зохиол юм.

1-р анги нь
“Синдбад
далайчин”

2-р анги нь
“Хан хүү
Календерийн
яриа”

3-р анги нь
“Хаан хатан
хоёр”

4-р анги нь
“Багдад хотын
баяр”

Чуулбар (сюит) нь бие даасан аязуудын дарааллаас бүрддэг.



Зохиолын гол баатар нь Шахриар хаан болон Шехеразада бүсгүй. Эмэгтэйчүүдийг үнэнч биш, туйлбаргүй зантай хэмээн итгэсэн Шахриар хаан өөрийн эхнэрүүдийг цаазлахыг тушаал болгоно. Гэвч түүний хатан Шехеразада бүсгүй олон шөнийн турш сонирхолтой үлгэр ярьж өгч, хааны харгис хэрцгийн зан араншинг өөрийн оюун ухаанаараа ялан дийлнэ.

Зохиолын эхний хэсэгт Шахриар хаан, Шехеразада бүсгүй хоёрын дүрийг танилцуулдаг.




- Ноот бичлэгийг ажиглаад, гол сэдэв аялгууг сонсоорой.
- Гол дүрүүдийг илэрхийлсэн сэдэв аялгууны шинж төрхийг тодорхойлж, харьцуулан ярилцаарай.
- Зохиолын гол дүрийн зан төрхийг тодорхойлоход хөгжмийн зэмсүүд ямар үүрэгтэй байна вэ?
- Шахриар хааны дүрийг илэрхийлэхэд эгшиглэлтийн ямар хүчийг ашигласан бэ?
- Шехеразадын дүрийг ямар учраас тайван, намуун зөвлөн, хүүрнэлт шинжтэй аялгуугаар илэрхийлсэн бэ?

Шахриар хааны сэдэв аялгуу. Чавхдаст хөгжим, гуулин үлээврийн дунд доод регистр (нам дор бүдүүн дугаралттай өнгө) дэх нүсэр, хүчирхэг дуурьсал, доошлон давтагдах аялгуу, эрчимтэй, хурц хэмнэл, хааны омог бардам дүр төрхийг илтгэнэ.



Music score for brass instruments (French horn, Trombone, Trumpet, Tuba) in C major, 2/4 time. The score consists of two measures. Measure 1: French horn (F), Trombone (D), Trumpet (C), Tuba (B). Measure 2: Trombone (D), Trumpet (C), Tuba (B).



Босоо ятгын хамсраатай хийл хөгжмийн гоцлолд оноосон Шехеразадын уянгалаг, намуун хүүрнэлт аялгуу нь дорно дахинь хөгжмийн яруу сайхныг маш тод илтгэдэг.



Music score for violin and harp in C major, 2/4 time. The score consists of five measures. Measures 1-4: Violin (F#) and Harp (F#). Measure 5: Violin (F#).



Жакомо Пуччини: “Театрт хүмүүний сонирхлыг татах, бишрэлийг нь төрүүлэх, сэтгэлийг нь уяраах гэсэн гурван хууль үйлчилдэг”.

1.4. ТЕАТР БА ХӨГЖИМ



- Эхийг уншаад театрын тухай сэдвээр асуулт зохиож ярилцаарай.
- Хүмүүс яагаад театрт очих хэрэгтэй вэ? Театрын урлагийн үнэ цэнийг юу гэж бодож байна вэ? Энэ асуултын дагуу хэлэлцүүлэг хийгээрэй.
- Италийн суут хөгжмийн зохиолч дуурийн урлагийн нэрт мастер Жакомо Пуччинийн хэлсэн үгийг тайлбарлан ярилцаарай.



1. Жүжигчдийн тогтолтоор амьдралын үзэгдлүүдийг уран сайхнаар дүрслэн үзүүлэх онцлог бүхий урлагийн төрөл бол театрны урлаг. Театрын урлагт тайзны үйл хөдлөл чухал. Театрын урлагт өгүүлэх, дүрслэх, гүйцэтгэх урлагууд нэгддэг. Өгүүлэх - жүжиг, Дүрслэх-тайзны чимэглэл, Гүйцэтгэгч - жүжигчин нийлж нэгэн цогц бүтээл тэрне.

2. Өгүүлэх арга, хэрэгслээс үндэслэн театрyg:
 - Драмын (үндэс нь жүжгийн зохиол)
 - Хөгжмийн (гол хэрэгсэл нь хөгжим)
 - Пантомимын (гол хэрэгсэл нь уран хөдөлгөөн) театр гэж төрөлжүүлдэг. Түүний хамт тайзны засал, нүүр будаг, хөгжим, дуу авиааны чимэглэл чухал үүрэгтэй.

3. Театрын урлаг бол хамтын бүтээл билээ. Театрын уран бүтээлийг туурвиход зохиолч, найруулагч, жүжигчин, зураач, хөгжмийн зохиолч, мөн гэрэл техник, тайз, хувцас, нүүр будгийн гээд төрөл бурийн мэргэжлийн хүмүүс, урлагийн бүх төрөл нэгдэж бүтээл амилна. Иймээс театр нь үзэгчдийн сэтгэлийг өөрийн эрхгүй эзэмддэг.

Зохиолын агуулга дүрийг жүжигчдийн тоглолт, тайзны үйл хөдлөлөөр үзэгчдэд хүргэдэг хөгжмийн төрлүүдийг хүснэгтээс харцгаая.

Тайзны хөгжмийн төрлүүд

Дуурь

Бүжгэн жүжиг

Дуулалт жүжиг

Мюзикл



МЮЗИКЛ

Мюзикл - дуурь, бүжгэн жүжиг, эстрадын элементүүдийг ашиглаж бүтээсэн гол төлөв хошин шинжтэй хөгжимт жүжгийн бүтээл юм. Иймээс тайзны үйл хөдлөл голлоно. Мюзикл нь урлагийн бүх төрлүүд нэгдсэн нийлмэл төрөл юм. Энэ төрөл нь XX зууны эхээр бий болжээ.

Урлагийн төрөл	Уран зохиол	Дүрслэх урлаг	Хөгжмийн урлаг	Театрын урлаг	Бүжгийн урлаг
Мюзиклд гүйцэтгэж байгаа үүрэг	Зохиолын ерөнхий утга санаа, үйл явдлын өрнөл хөгжил, тайллыг гаргах үүрэгтэй.	Тайз засал, хувцас, нүүр будалтыг гүйцэтгэнэ.	Дуулаач, дан хөгжмийн төрлүүдээр утга санааг илэрхийлнэ.	Зохиолын үйл явдлыг дуу хөгжмөөс гадна тайзны үйл хөдлөлөөр илэрхийлнэ.	Зохиолын үйл явдал болон гол дүрүүдийн харилцааг илэрхийлсэн бүжгүүд мюзиклийг баялаг өрнүүн болгоно.



- Үйл хөдлөлөөр илэрхийлэгдэх урлагийн төрөл бол театрин урлаг. Тэгвэл дууг театртай холбосноор дуулаачийн хөгжмийн ямар төрөл бий болох вэ? Ярилцаарай.


Гоцлол, цөөхүүл,
найрал дуу



Тайзны үйл
хөдлөл



- Дараах зургийг ажиглаад, театруудыг нэрлээрэй. Эдгээр театр урлагийн ямар төрөлд хамаарах бүтээлүүд тавигддаг тухай ярилцаарай.



Д

- Дараах мэдээллийг уншаарай. Бүтээлүүдийн гол санаа юунд чиглэж байна вэ?
- Хөгжмийн театрын хүүхдэд зориулсан бүтээлийн талаар нэмэлт мэдээлэл цуглуулаарай.
- Хүмүүс яагаад театрт очих хэрэгтэй вэ? Энэ асуултын дагуу хэлэлцүүлэг хийгээрэй.

Хүүхдэд зориулсан хөгжмийн театрын бүтээлүүд

№	Хөгжмийн зохиолч	Бүтээлийн нэр	Бүтээлийн төрөл	Бүтээлийн санаа
1.	П.И.Чайковский	Цөмөөхэй	Бүжгэн жүжиг	Сайхан сэтгэл муу муухай бүхнийг ялан дийлнэ.
2.	Э.Чойдог Б.Жамъяндагва	Мөнгөн залаа	Бүжгэн жүжиг	Бамбар, тугал хоёрын үнэнч нөхөрлөл, өнө урт энх тайван, эв найрамдлын тухай мөрөөднө.
3.	Э.Чойдог	Хөгжмийн эгшиг	Бүжгэн жүжиг	Бүжигчид хөгжимчин болж хувираад, сонгодог бүжгийн уран хөдөлгөөнөөр тухайн зэмсгүүдийн онцлог, мөн чанарыг илэрхийлнэ.
4.	Г.Пүрэвдорж Ж.Дашдондог	Дэлхий ээжийн төрсөн өдөр	Дуурь	Дэлхийгээ дайн дажингүй амар амгалан байлгая гэвэл эвийн хүчээ нэгтгэн нэгэн зорилготой тэмцвэл ямар ч дайсныг ялж, аюулыг зайлуулж чадна.
5.	Морис Равель Сидони Габриель Колетт	Хүүхэд ба ид шид	Дуурь - бүжгэн жүжиг	Ээжийнхээ үгийг үл хайрхах дүрсгүй хүүгийн зүргүйтэл эргэн тойрондоо ямар нөлөөтэй, эцэстээ юунд хүргэдгийг сургамжилсан.
6.	Н.А.Римский-Корсаков В.Бельский	Салтан хааны үлгэр	Дуурь	А.С.Пушкиний үлгэрээс сэдэвлэсэн. Атаархал гэдэг сайн сайхан, аз жаргалд хэзээ ч хүргэхгүй. Харин хуурамч зүйл, гэмт үйлдэлд түлхэхийг ухааруулж, шударга ёс, сайхан сэтгэл, үнэн ялна гэдгийг өгүүлнэ.
7.	Б.Мөнхжаргал О.Найманжаргал	Сэтгэлийн домог	Мюзикл	Гоо үзэсгэлэн, тансаг амьдрал, ихэмсэг бардам зан бус харин сайхан сэтгэл, хөдөлмөрч, тусч чанар аз жаргалд хүргэнэ.
8.	Алан Менкен Тим Райс	Үзэсгэлэн ба араатан	Мюзикл	Гаднаасаа хэрхэн харагдах нь гол биш, харин сэтгэл дотроо сайхан байх хэрэгтэй. Хайр бүхнийг ялан дийлнэ.



Бүжгэн жүжиг бол амилсан баримал. В.Г.Белинский

1.5. БҮЖИГ БА ХӨГЖИМ

Бүжиг бол хүний биеийн хөдөлгөөний урлаг юм. Бүжгийн урлагийн гол онцлог нь хөгжмийн аялгуу, айзам хэмнэлд тулгуурлан, хүний биеийн уян налархай хөдөлгөөнөөр утга агуулгаа илэрхийлдэг. Урлагийн энэ төрөл айзам хэмнэлтэйгээрээ хөгжим, шүлэг яруу найрагтай төсөөтэй.



Энэ төрөл нь яриан жүжиг шиг үгээр, дуурь шиг ая дуугаар илэрдэггүй, харин бүжигчний ур чадварт тулгуурлан хөгжим, бүжиг, жүжиглэлийг хослуулдаг.

Хөгжимтэй холбоотой уран зураг, яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиол, театрын жүүхийн жишээг бид олныг нэрлэж чадна. Тэдгээр нь хөгжимгүйгээр биеэ даасан урлаг байж чаддаг. Харин хөгжимгүйгээр оршиж чадахгүй цорын ганц урлаг бол бүжиг юм. Ингэхлээр хөгжмийг бүжгийн урлагийн амин сүнс гэж үзэж болно.



- Бүжгийн урлагийг хөгжимгүйгээр дотроо төсөөлөн хараад ярилцаарай. Хөгжимгүй бүжиг ямар байх бол? Бүжигт хөгжмийн гүйцэтгэх үүргийг дүгнээрэй.
- Зургийг ажиглаад, бүжгийн төрлүүдийг нэрлэж онцлогийг ярилцаарай.



Ш.Өлзийбаяр

ДӨРӨӨ

(модерн бүжгэн жүжиг)



Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн “Тогорууны хараал” зохиолоос сэдэвлэн найруулагч Д.Энхбаяр “Дөрөө” хэмээх бүжгэн жүжгийн цомнолыг бичжээ. Бүжиг дэглээч М.Мөнгөнцэцэг, хөгжмийн зохиолч Ш.Өлзийбаяр нар уг цомнолоор шинэлэг өнгө аястай хөгжим, бүжгийн өвөрмөц хөдөлгөөн бүхий модерн (франц хэлэнд- орчин үеийн) бүжгэн жүжиг туурвисан юм. Энэхүү бүтээлд дэлхий өртөнц хүн байгаль хоёрын шүтэлцээнд оршдог гэсэн санааг өгүүлнэ.

Тогоруу үрдээ харам бөгөөд өндгийг нь хагалахад төмөр дөрөөний сэнжийг тасартал хараадаг гэх монголчуудын эртний үгээс эшлэн энэхүү бүтээлийг туурвижээ. Хүн төрөлхтөн байгаль дэлхийтэй балмад хэрцгий харьцсанаас үүдэн өөрсдөө асар их хилэгнэлийг хүртдэг гэсэн утгыг илэрхийлдэг.

Бүжиг дэглээч монголын агуй, хадны сүг зургаас гаргалгаа хийж, олон арван хөдөлгөөний хувилбарыг сэдэн боловсруулж, монголын уламжлалт биелгээ, бүжгийн хөдөлгөөнүүдийг баяжуулан модерн бүжгийн урсгалтай хослуулсан байна.

Энэ бүтээл үзэгчдэд хүрээлэн буй орчиндоо ээлтэй, зүй зохистой хандах үзэл, байгаль эх дэлхийгээ хайрлан дээдлэх сэтгэлийг шивнэнэ.

1. Тогорууны бүжиг. Тогоруунууд удахгүй гарах ангаахайнуудаа хүлээн хөөрөн баясаж бүжнэ.



2. Ан ав. Хүннүгийн үеийн цэргүүд ан хийж яваад тогорууны өндгийг гишгүүлчихжээ.




3. Тогорууны гуниг шаналал. Өндгөө хагалуулан уй гашууд автсан тогоруунууд газар нэвсийн унаж, өндөгнүүдээ даран энэлэн шаналж,

тэнгэр өөд цоролзох нь хагацаалгүй амар амгалан амьдралыг гүйх мэт.



4. Ялагдал. Цэргүүд “дайснаас хүч дутан ялагдав” хэмээн төсөөлөвч шалтгаан нь тогорууны өндгийг хагалснаас үүдсэн аж.



Тогоруу үрдээ харам бөгөөд өндгийг нь хагалбал төмөр дөрөөний сэнжийг тасартал хараадаг гэдэг.




- Бүжгэн жүжгийн хэсгээс сонсоорой.
- Сэдэв аялгууг сонсоод, ноотоор дагаад аялаарай.

Adagio

Үгийн сүлжээ

Асуултыг уншаад, хариултыг олж, сүлжээг бөглөөрэй. Тодруулсан хэсэгт нуугдсан үгнээс та нар энэхүү бүжгэн жүжигт зохиолч, найруулагчдын хэрэглэсэн өвөрмөц шийдэл, урлагийн нэгэн төрлийг олж мэдэх болно.



1. Монголчууд ямар шувууг хараад “Тоодог муухай, хөөрхөн, цам харай, цам харай” гэж хэлдэг вэ? 2. Бүжгэн жүжгийн нэр. 3. Сэдэв аялгуун дах хамгийн доод эгшиг. 4. Монголчууд шувуудын юунд сүүдрээ ч тусгахаас цээрлэдэг вэ? 5. Аялгуу ямар цомнол, хөгд бичигдсэн байна вэ? 6. Цэгтэй дөрөвт хэдэн наймттай тэнцэх вэ? 7. Энэхүү бүжгэн жүжигт монгол ардын бүжгийн ямар төрлийг орчин үеийн бүжигтэй хослуулсан байдаг вэ? 8. Adagio (Адажио) хэмээх уг нь ямар хурдыг тэмдэглэх вэ? 9. “Орчин үеийн” хэмээх франц гаралтай уг. 10. Аялгуу хэдэн хувьт хэмд бичигдсэн байна вэ? 11. 1-7 хүртэлх зайцаас (интервалаас) аялгуунд хэдэн өргийн зайцыг хэрэглээгүй байна вэ? 12. Сэдэв аялгуунд ямар хэмжээтэй ноот хамгийн цөөн хэрэглэгдсэн бэ?

Нуугдсан уг:





- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Дараах бүжгийн хөгжмүүдийг сонсоод, айзам хэмнэлийг тодорхойлоорой.
- Бүжгийн аль төрөлд хамаарах вэ?

- | | |
|-------------------------------------|------------|
| 1. Чагатай | 5. Вальс |
| 2. Агсал | 6. Брейк |
| 3. Ёхор | 7. Биелгээ |
| 4. Хунт нуур “Бяцхан хунгийн бүжиг” | 8. Уелзүүр |

Хөгжмийн зохиолчдын бүтээлд олон янзын бүжгийн аялгуу тааралддаг. И.С.Бах, В.А.Моцарт, Ф.Шопен, М.И.Глинка, А.Хачатурян, С.Гончигсумлаа, Э.Чойдог гээд олон орны хөгжмийн зохиолчид бүжгийн хөгжим бичсэн байдаг.



- Дараах бүжгүүд аль улс үндэстнээс гаралтай болохыг судалж мэдээрэй.
- Хөгжмийг сонсоод айзам хэмжээ, шинж төрхийг тодорхойлоорой.

- | | | |
|-----------|-------------|------------|
| 1. Полька | 4. Чардаш | 7. Биелгээ |
| 2. Менуэт | 5. Лезгинка | 8. Агсал |
| 3. Вальс | 6. Полонез | 9. Ёхор |



- Лезгинка бүжгийн ноот бичлэгийг ажиглаарай.
- Давталттай хэсэг байна уу? Өөрчлөлт байна уу? Чухам яаж өөрчлөгдсөн бэ?

Лезгинка нь грузины ардын бүжиг, гялалзсан өнгөлөг, хурц эрэмгий шинж төрхтэй. Энэ бүжгийн аялгуу гурван айзмаар зохион байгуулагдсан, дараагийн гурван айзамд аялгуу өөр өндөрлөгт дахин давтагджээ. Үүнийг ноот бичлэгээс ажиглаж, мөн сонсож таниарай.



- Эдгээр бүжгэн жүжгийг бүтээсэн хөгжмийн зохиолчдыг судалж мэдээрэй.
- | | | |
|---------------------|----------------|---------------------------|
| 1. “Бөртэ чоно” | 4. “Гүюг хаан” | 7. “Үйлийн гурван толгой” |
| 2. “Эрдэнэсийн уул” | 5. “Дөрөө” | 8. “Тамганы бүжигчин” |
| 3. “Нарны домог” | 6. “Уран хас” | |



1.6. КИНО БА ХӨГЖИМ

Утга зохиол, дүрслэх урлаг бол маш эртний төрөл. Харин кино урлаг техникийн ололт дээр тулгуурлан нэлээд хожуу 1895 оноос асар хурдтайгаар хөгжсөн юм.	Киног “Дэлгэцээр сүүдэр зураг үзүүлэх уран сайхны бүтээл” хэмээн Монгол хэлний тайлбар тольд бичсэн байdag.	Кинонд утга зохиол дүрслэх урлаг, хөгжим, жүжиг зэрэг урлагийн бүх төрлүүд нэгддэг тул нийлмэл төрөл юм.	Зохиолч, найруулагч, жүжигчин, зураглаач, хөгжмийн зохиолч, техникийн ажилтнууд гээд олон хүний хамтын хөдөлмөрөөр кино бүтдэг.
Монголын кино урлаг 1936 онд “Майн 47 жилийн ой” дуугүй баримтат кино, “Монгол хүү” богино хэмжээний дуутай киноор анхны алхмаа хийсэн.	Кино анх ээлжлэн солигдох зургаар утга санаагаа илэрхийлж байсан бол эдүгээ жүжигчдийн тоглолт, техникийн дэвшилд тулгуурлах болжээ.	Киноны утга санаа, уйл явдал, гол баатрын бодол санааг үзэгчдэд хүргэхэд хөгжим гол үүрэгтэй. Үгээр илэрхийлэх боломжгүй зүйлийг хөгжмөөр дамжуулдаг.	- Баримтат кино - Шинжлэх ухаан, танин мэдэхүйн кино - Уран сайхны кино - Хүүхэлдэйн кино гэх мэт төрлүүд бий.



Шилдэг кинонууд ихэвчлэн бидний оюун ухаан, зүрх сэтгэлд нөлөөлөх тийм л хөгжмийн бүтээлийг агуулж байдаг. Энэ чиглэлээр хөгжим бичдэг алдарт хөгжмийн зохиолчдоос дурдвал: Ханс Циммер “Гладиатор”, “Карибын тэнгисийн дээрэмчид”, Дэнни Элфман “Хар хувцастай хүмүүс”, “Хүн аалз”, “Халк”, Джон Уильямс “Гэртээ ганцаараа”, “Харри Поттер” цуврал киноны хөгжим, Нино Рота “Загалмайлсан эцэг”, “Ромео ба Джульетта”.

Киноны хөгжим бие даасан уран бүтээл болж сонсогчдод хүрэх нь илүү байдаг. Монголын хөгжмийн зохиолчдоос Л.Мөрдоржийн “Алтан өргөө”, Э.Чойдогийн “Монголын сайхан орон”, Н.Жанцанноровын “Мандухай сэцэн хатан”, “Мөнх тэнгэрийн хүчин дор”, З.Хангалын “Хатанбаатар”, “Тань руу нүүж явна” зэрэг киноны хөгжмүүд хүн бүрийн сонсох дуртай, сэтгэлд хоногшсон аялгуу болсон юм.



Түүхэн кино



АРАВТ

“Монголфильм групп”, ӨМӨЗО-ны “Нүүдэл соёл” кино компанитай хамтран дижитал технологийг ашиглан Аравт киног бүтээжээ. Киноны уур амьсгалыг хөгжим илүү хүчирхэг болгосноор бидний мэдрэмж эрчимжиж, киноны баатруудтай адил сэтгэлийн хөдлөлд автдаг. Үзэгчдэд хүргэх гэсэн киноны

агуулга санаа авьяаслаг хөгжмийн зохиолч, хөгжимчийн гайхалтай бүтээлээр дамжин бидний зүрх сэтгэл, оюун санааг эзэмддэг.

Энэхүү киноны үйл явдал нь тэртээ XIII зуунд өрнөдөг. Чингис хааны эзэмшил нутагт дэгдсэн тахал өвчнийг эмчлэх зорилгоор уулын алслагдсан нутгаас оточ залан авчрах эзэн хааны зарлигийг гүйцэлдүүлэхээр эрэлхэг 10 дайчин замд гарна. Энэ л “Аравт” нэгэн санаа, нэгдмэл хүчээр бартаа саад, цус асгаруулсан хүнд тулааныг туулж, баходал, харууслыг хуваалцан нөхөрлөж амь биээ үл хайрлан тэмцэж явсныг кинонд өгүүлдэг.

Хөгжмийн зохиолч, төгөлдөр хуурч Б.Чинбатын “Аравт” киноны хөгжмийг сонсоцгоё.



- Энэхүү хөгжим киноны үйл явдлыг даган өрнүүлэх, үйл явдалд хүч оруулах, баатруудын сэтгэлийн шаналал, зориг хүчийг илэрхийлэхдээ хэрхэн хувьсан өөрчлөгдөж байна вэ?
- Гол аялгууны илэрхийлэл төгсгөл хэсэгтээ хэрхэн өөрчлөгдөж байна вэ? Энд юу нөлөөлсөн бэ?
- Аялгуу ямар хурд, хүчдэлд эгшиглэж буйг тодорхойлоорой.
- Гол аялгууг ноотоор дагаад аялаарай.
- Кинонд хөгжмийн гүйцэтгэх үүргийн талаар ярилцаарай.





**Зундуйн Хангал
(1948-1996)**


ТАНЬ РУУ НҮҮЖ ЯВНА (киноны хөгжим)

Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч. Тэрээр “Эрдэнэсийн уул” бүжгэн жүжиг, “Салхит шувуун” симфони найраглал, “Чаевхаст хөгжмийн дөрвөл”, төгөлдөр хуур, хийл, морин хуурын концертүүд, “Хатанбаатар”, “Тань руу нүүж явна”, “Гэрлэж амжаагүй явна”, “Суварган цэнхэр уулс”, “Дэгдээхий нас” киноны хөгжим, “Зурсгийн хичээл”, “Нарны бүжиг” хүүхдийн дуунууд, “Эхийн сэтгэл” хүүхдэд зориулсан бүжгэн жүжиг зэрэг олон бүтээлээрээ алдаршижээ.



- “Тань руу нүүж явна” киноны хөгжмийн сэдэв аялгууг ноотоор дуулаарай.
- Хөгжмийн дүрслэл, илэрхийлэл чамд ямар мэдрэмж төрүүлж байна вэ?
- Энэхүү аялгууны уянга, дууллын өнгө аясыг илэрхийллийн ямар хэрэглүүрүүд онцлон тодорхойлж байна вэ?
- Хөгжмийн зэмсгийн тембр, цомнолын өнгө эгшиглэгээ хөгжмийн илэрхийлэлд хэрхэн нөлөөлж байна вэ?
- Энэ зохиолд хөгжүүлгийн ямар арга, хэлбэрийг (давталт, ялгарамж, хувилбар) хэрэглэж байна вэ?


Andante



Д

- Энэхүү хөгжмийн дүр дүрслэлийг тодорхойлж, чадах үгсийг сонгоорой.

Анир чимээгүй, амар амгалан, гуниг, бодрол, бясалгал, хүсэл, тэмүүлэл, аз жаргал, баяр баясал, энхрийлэл, хайр, уйтгар, догдол, эмгэнэл, дурсамж, түгшүүр, эрч хүч, тайвшрал.



Алдартай зохиол бүтээлүүд уран бүтээлчдийн найруулга, илэрхийлэл, бүтээлч шийдлээр дахин төрж, шинэ аялга, хэмнэл, хөгжүүлгийн арга барил, өнгө аясаар баяжих байдаг. “Тань руу нүүж явна” киноны хөгжмийг гоцлол, цөөхүүл, найрал хөгжмөөр хөгжимдсөн олон хувилбар бий.



Д

- Та нар хувилбаруудыг харьцуулан сонсож, хүснэгтийг нөхөөрэй.

Харьцуулах чиглэл	“Тань руу нүүж явна” киноны хөгжим	
	Хувилбар 1	Хувилбар 2
Хөгжмийн бүрэлдэхүүн		
Хөгжмийн зэмсгүүд		
Адил талууд		
Ялгаатай зүйл		



- Киноны дуу дуулцгаая.

Ая. Ц.Нацагдорж

Үг. Б.Чимэддорж

БАЛЧИР НАСНЫ НӨХӨР
(“Гийнгоо” киноны дуу)

Хөгжилтэй, хурдан

Ши - рээ тал - даа шан-дас со - рих - доо Шин-жээч у - яа - чийн
 эр-дэмд ху - ви - раад Бяц-хан эз - дийн - хээ бод - лыг гүй - цээж

Ба - риа-ны га - зар тод-рон ир - дэг Хүл-гийн у - дам

хөөр-хөн даага - нууд минь Хүү - хэд бид - ний дот - ны нө - хөр дөө

Толгодын оройн сүүдэр тоолон
 Тоосон дундаас сугаран нааддаг
 Сайн малчны алдрыг өргөж
 Салхин хурдаар холыг туулдаг
 Хүлгийн удам хөөрхөн дааганууд минь
 Хүүхэд бидний дотны нөхөрдөө
 Наран ургах өглөөг зарлан
 Ногоон хөндийг сэрээж янцгаадаг
 Наадамч олны хайрыг булааж
 Насан багын түшиг болдог





- Ноотыг ажиглаад айзам хэмжээг тодорхойлоорой. Ямар өөрчлөлт гарсан бэ?
- Хэмжээний өөрчлөлтийг хөгжимд юу гэж нэрлэдгийг олж мэдээрэй. Зөв илэрхийлж дуулахын тулд удирдаачийн дохиог анхаараарай.

Ая. Г.Бирваа

Үг. С.Дашдооров

ЭХ НУТГИЙН ДУУ
(Хөдөөгийн баясгалан киноны дуу)

1.2.

Жихүүн өвлүүн жавар ширүүн
Жирийн олны зүтгэл шидрүүн
Саруул нутгийн буурал хөндийд
Сааршгүй үйлсийн ундраа дэлгэр

Нарлаг зуны цэцэг нь өнгөлөг
Найрсаг олны сэтгэл тунгалиг
Өлгий нутгийн цэлгэр хөндийд
Өрнүүн ажлын амжилт арвин

Урьхан хаврын салхи нь хонгор
Улс орны амьдрал ханагар
Унаган нутгийн цэлгэр хөндийд
Уянга дууны эгшиг цээлхэн

!

тай-ван нам - рын өнгө нь ха -



- Хөгжмөө сонсоод киноны ямар төрөлд багтахыг тодорхойлж бүлэглээрэй. “Алтан өргөө”, “Бушхүүгийн үлгэр”, “Мандухай сэцэн хатан”, “Ингэн эгшиг”, “Эрх цагаан ишиг”, “Чамайг даа”
- Өөрийн мэдэх киноны хөгжмүүдээр баяжуулаарай.

Киноны хөгжим		Зохиолын нэрс	Хөгжмийн зохиолч
Уран сайхны кино	Түүхэн сэдэв Үлгэрийн сэдэв		
Хүүхэлдэйн кино			
Баримтат кино			




БҮЛЭГ I

Д

- Урлагийн төрлүүд сэдвийн хүрээнд ямар мэдлэг эзэмшсэн бэ?

МЭДЛЭГЭЭ СОРЬЁ



Уран бүтээлч хүн өөрийн бодол санаа, мэдрэмжээ урлагаар дамжуулан илэрхийлэхийг эрмэлздэг юм. Ингэхдээ, өөртөө аль болох ойр, мэдрэмжээ илэрхийлж чадах аргыг сонгож бүтээлээ туурвидаг.



Уран яруу үг



Өнгө, зураас, дүрсийн нийлэмж



Хөдөлгөөн



Аялгуу, хэмнэл

Урлагийн төрлүүд
амьдралыг өөр өөрийн
өөрөмөц аргаар
илэрхийлдэг.



Үйл хөдлөл

Д

- “Эх орон”, “Байгаль”, “Би” гэх мэтээр дурын сэдэв сонгон өөрсдийн бодол санаа мэдрэмжээ уран сайхны аргаар илэрхийлээрэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨГЖМИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ


Хөгжим бол урлагийн өвөрмөц төрөл бөгөөд уран сайхны дүрийг дуу авиаагаар дүрслэн илэрхийлдэг. Хөгжмийн урлагийг ерөнхийд нь дуулахад зориулсан дуулаачийн хөгжим мөн зөвхөн хөгжимдөхөд зориулсан дан хөгжим гэж хоёр төрөлд хувааж болно. Бас цааш нь бүжгийн хөгжим, тайз дэлгэцийн хөгжим гэж үздэг тал ч бий.



2.1. ДУУЛААЧИЙН ХӨГЖИМ

Бидний өдөр тутам дуулдаг дуунаас гадна зөвхөн мэргэжлийн дуучид концертын тайзнаа дуулахад зориулагдсан романс, дууль, магтуу, оратори зэрэг төрлүүд бий. Бид мөн яриан жүжиг, хөгжим хоёрын хослогоос бүтэх дуурийг театрын тайзнаас үзэж сонсдог. Дуулаачийн урлагийн энэ бүх төрөл өөр өөрийн өвөрмөц онцлогтой.

Дуулаачийн хөгжмийн зарим төрлүүдтэй танилцъя.




ДУУ


Дуулахад зориулан зохиосон хамгийн энгийн төрөл бол дуу юм. Дуу нь эрт дээр цагаас хүмүүсийн ахуй амьдрал, ажил хөдөлмөртэй нягт холбоотой үүсч хөгжсөн.

Дуу бол юуны өмнө шүлэг, хөгжмийн аялгуу хоёрын дундаас төрдөг. Дууны аялгуу нь шүлгийн ерөнхий санааг илэрхийлдэг. Дууны шүлэг нь яруу найргийн өвөрмөц төрөл. Шүлгийн бадаг бүр нэг ижил аялгуугаар дуулагддаг. Дуу нь бадаг, дахилт гэсэн хэсэгтэй.

Дууг сэдэв агуулга, дуулах хэв маягаар нь дараах байдлаар ангилаа.



Дуулаачийн хөгжмийн өөр нэг төрөл бол Испаниас гаралтай романс юм. Романсын онцлог гэвэл аялгуу нь жирийн дуу шиг тогтмол давталттай биш, шүлгийн утгыг дагаж аялгуу нь хувьсан өөрчлөгдж байдаг.



Романсын төрлөөр туурвигч алдарт хөгжмийн зохиолчдоос дурдвал Ф.Шуберт, Р.Шуман, М.И.Глинка, П.И.Чайковский, С.Рахманинов, монголын нээрт хөгжмийн зохиолч Н.Жанцанноров, Б.Шарав гэх мэт.

Дан хөгжмийн дуулалт шинжтэй уянгын зохиолыг мөн романс хэмээн нэрлэсэн байдаг. Л.В.Бетховены хийлийн романс, Ф.Шопенны төгөлдөр хуурын романс гэх мэт.



С.В.Рахманинов

С.В.Рахманинов
(1873-1943)

Сергей Васильевич Рахманинов оросын агуу хөгжмийн зохиолч, удирдаач, төгөлдөр хуурч. Тэрээр “Алеко”, “Франческа да Римины”, “Харамч хөлөг баатар” дууриуд, 3 симфони, найрал хөгжимд зориулсан “Хонхнууд” найраглал, “Хадан хавцал” уран сэтгэмж, төгөлдөр хуурын сонат, концерттууд, дуулаачид зориулсан дуу, романсын, “Хавар” магтуу зэрэг олон алдартай бүтээл туурвисан юм.

Хөгжмийн зохиолчид аливаа дүрслэлийг үзэгч сонсогчдод хүргэхийн тулд хөгжмийн илэрхийллийн янз бүрийн аргуудыг ашигладаг. Эдгээрээс хамгийн чухал арга хэрэглүүр нь аялгуу билээ.

Аялгууг авиа эгшгээр илэрхийлэгдэх бодол санаа хэмээдэг. Бид бодол хүслээ үгээр илэрхийлдэг. Хөгжмийн бүтээлд нэр, шүлэг байгаа тохиолдолд ойлгоход хялбар байдаг. Харин дуу шүлэггүй байвал яах вэ?

Гол зүйл болох аялгуу л үлдэнэ. Энэ л аялгууг дуулж эсвэл ямар нэгэн хөгжмийн зэмсгээр хөгжимдэж болно. Ингэж л хөгжимд илэрхийлэн дүрслэх аялгуу зонхилсон үггүй дуунууд бий болжээ. Эдгээрийн нэг нь вокализ юм. Энэ нь тасралтгүй үргэлжлэх эгшиг үсгээр (ихэвчлэн “а” үсгээр), хөгжмийн зэмсгийн хамсраатай дуулагддаг.

011

- Ноот бичлэгийг ажиглаарай.
- Хөгжмөө сонсохдоо сэдэв аялгууг дагаж аялаарай.

Удаан, дуулалтай



4



БАЛЛАДА (дууль)

Баллада буюу дууль гэдэг төрөл уран зохиолд их тааралддаг. Мөн кино урлагт ч энэ төрлийг хэрэглэх нь цөөнгүй. Дууль бол үлгэр, домог, ахуй амьдрал, түүхэн үйл явдлаас сэдэвлэн бичсэн богино хэмжээний зохиол юм. Дуульд голдуу сэтгэл догдлом үйл явдал, баатарлаг содон хүмүүсийн тухай уянгалаг ясаар өгүүлсэн байдаг. Энэ төрөл аажмаар хөгжимд нэвтэрч дан хөгжмөөс гадна дуучдад зориулсан олон бүтээл төржээ.

Энэ төрлөөр монголын хөгжмийн зохиолч Ц.Эрдэнэбат “Ерэн баатрын дууль”, Т.Чимэддорж “Эргэж бидэнд ирээгүй эцэгтээ бичсэн захидал” бүтээлүүдээ туурвижээ.



Ая. Т.Чимэддорж

Үг. Д.Батсүрэн

ЭРГЭЖ БИДЭНДЭЭ ИРЭЭГҮЙ ЭЦЭГТЭЭ БИЧСЭН ЗАХИДАЛ

Moderato

4 5 3 4
 Хо - рин нэг Гу - чин е - сен онд Ту - жийн нарс Хал - хын го - лоос
 5
 3
 Дөчин та-ван онд Их Хян - га - наас төө-нөх нар, тэс-рэх сум, хур сал - хи, дай-ны хе - лөөс
 9
 3
 эр - гэж и - рээ - гүй э - цэг та ми - 3
 а__ мар сайн бай - нуу



- Хөгжмөө анхаарч сонсъё. Аялгууны хүүрнэн өгүүлсэн шинжийг зохиолын агуулгатай холбон ярилцаарай.
- Зохиолын турш айзам дах хувийн тоо өөрчлөгдсөнөөр хэм хэмжээ солигдох нь бий. Ноот бичлэгт айзам дах хувийн тоо хэрхэн өөрчлөгдсөнийг ажиглаарай.
- Хэмжээний өөрчлөлтийг хөгжимд юу гэж нэрлэх вэ?
- Дараах хэмнэлээр хөгжимдөөрэй. Хэмнэлийн зураглалын онцлог нь юу вэ?

3 3 3
 || - . - . - . - . - . - | - . - . - . - | - . - . - . - | - . - . - |



НАЙРАЛ ДУУНЫ ТӨРЛҮҮД

Найрал дууны томоохон төрөлд кантат, оратори, реквием багтдаг. Т.Чимэддорж “Залгамж үеийн тэмүүлэл” магтуу, Б.Шарав “Замбуу тивийн наран” магтуу, Д.Лувсаншарав “Эх орон бат оршиг” магтуу, Ц.Чинзориг “Илдэн уулын цуурай” оратори зэрэг олон арван бүтээлийг нэрлэж болно.



- Дараах чиглэлээр мэдээлэл цуглуулаарай. Найрал дуу буюу Choir гэж юу вэ?
- Найрал дуу гэдэг уран бүтээл үү? гүйцэтгэх бүрэлдэхүүн үү?
- Та нарын дуулдаг найрал дууны бүтээлд хөгжмийн хамсраагүй дуу олон тааралдана. Хөгжмийн хамсраагүй найрал дууг юу гэж нэрлэх вэ?
- Найрал дууны ямар ямар төрлүүд байдаг вэ?
- Бүдүүвч зургийг ажиглаад мэдээллийг боловсруулаарай.

Найрал дуу

Мэргэжлийн, сургалтын, сонирхогчдын, ардын, сүмийн, сонгодог,

Холимог, нэг төрлийн, хөгжмийн хамсраатай, хөгжмийн хамсраагүй

12-30, 40-70, 70-120 дуучин



Д

- Мэдсэнээ доорх хүснэгтээр илэрхийлээрэй.

Найрал дуу- Choir

Бүрэлдэхүүнээр нь	Арга барилаар нь	Үүрэг зориулалтаар нь
?	?	?



Ая. Т.Чимэддорж

Үг. О.Баасанжав

ЗАЛГАМЖ ҮЕИЙН ТЭМҮҮЛЭЛ (магтуу)

“Залгамж үеийн тэмүүлэл” магтуу нь Монголын жаргалант ирээдүй болсон хүүхэд багачуудын хүсэл тэмүүллийг илэрхийлсэн зохиол юм. Энэ магтуунд дайн дажингүй, энх амгалан амьдралыг хүссэн хүүхдийн хүсэл тэмүүлэл, олон үндэстний багачуудтай найрсаг нөхөрлөж, эх орондоо ихийг бүтээх эрмэлзлийг магтан дуулдаг юм. Залгамж үеийн тэмүүлэл магтуу нь:

- Залгамж үе
- Дурдатгал
- Мөрөөдөл
- Тэмүүлэл гэсэн дөрвөн ангитай.
- “Залгамж үеийн тэмүүлэл” магтууны хэсгээс сонсоод, аялгууны шинж төрхийг тодорхойлоорой.
- Магтууны I ангийн хэсгээс хоёр хоолойгоор дуулж сурцгаая.

**Allegretto**

Урган дээшлэх бүхний маань
Жолоо гэрэл нь болцгоосон
Угтах гэгээн эв хамтын
Жавхлант эзэн болцгоосон


Багачууд бидний баясгалан
Барагдашгүй баясгалан
Барагдашгүй баясгалан



ДУУРЬ

(опера)

Дэлхий дахинд “Опера” гэж нэршсэн, дуулаачийн урлагийн хамгийн том төрлийг монгол хэлэнд “Дуурь” гэж нэрлэдэг. Дуурь бол юуны өмнө тайзны урлаг юм. Өөрөөр хэлбэл зохиолын агуулга, үйл явдлыг тайzan дээр уг яриа, үйл хөдлөлөөр өгүүлдэг. Гэвч дуурьт голлох үүргийг хөгжим гүйцэтгэнэ. Дуурь нь урлагийн бусад төрлүүдийн нэгдлээс бүтдэг нийлмэл төрөл.



Дуурь нь бүлэг үзэгдлүүдээс бүтдэг. Дуурийн урлаг бол хөгжмийн зохиолчийн авьяас билэг, жүжигчний ур чадварыг ихээхэн шаардсан, тэдгээрээс гадна найруулагч, зураач, хөгжимчид, тайзны ажилтнууд зэрэг олон хүний хүч чармайлтаас амжилт нь шалтгаалах хамтын бүтээл юм.

Дуурийн урлагийн хөгжлийн явцад олон орны хөгжмийн зохиолчид хүүхдэд зориулсан дуурь бичжээ. Хүүхдийн дуурийн хөгжмийн илэрхийлэл, сэдэв дүрслэл нь хүүхдийн бодол сэтгэлгээ, сонирхолд нийцсэн, үлгэр домог, байгаль, ан амьтдын дүр дүрслэл зонхилсон, ойлгомжтой, энгийн хэлбэр бүтэцтэй байдал.

Хүүхдэд зориулсан алдартай дууриудаас Л.Яначек (чех) “Залт бяцхан Виксен”, Б.Бриттен (англи) “Ной-н хөлөг онгоц”, Р.Эйрз “Питер Пэн”, Ж.Доув “Пиноккиогийн адал явдал”, М.Равель (франц) “Хүүхэд ба ид шид”, Дж.Менотти (америк) “Амаль ба шөнийн гийчид”, Э.Хумпердинк (герман) “Гензель ба Гретель”, Ц.Кюи (орос) “Цасан баатар” зэргийг нэрлэж болно.

Монголын хөгжмийн зохиолчдын хүүхдэд зориулсан дуурь, хөгжимт жүжиг 1960-аад оноос эхлэлтэй. Үүний анхдагч нь хөгжмийн зохиолч Ц.Сүхбаатар, эх зохиогч Д.Содномдорж нарын “Аз жаргалын эрэлчин”, Г.Бирваа, Ч.Ойдов нарын “Аргат бяцхан баатар” хэмээх бүтээлүүд байлаа.



Цомнолыг Ж.Дашдондог

Хөгжмийг Г.Пүрэвдорж

ДЭЛХИЙ ЭЭЖИЙН ТӨРСӨН ӨДӨР (хүүхдийн дуурь)



Хоёр бүлэг, гурван үзэгдэлт энэхүү хүүхдийн дуурийг Соёлын гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Г.Пүрэвдорж, төрийн соёрхолт, хүүхдийн зохиолч Ж.Дашдондогийн цомнолоор 2002 онд түүрвижээ.

Зохиогчид дуурьтаа байгаль дэлхийгээ хайлрах, дайн дажингүй тайван амьдрахад эвийн хүч, нэгэн санаа нэгдмэл зорилго чухал гэсэн санааг илэрхийлжээ.

-  - “Дэлхий ээжийн төрсөн өдөр” дуурийн төгсгөлийн “Бүжигт дуу”-ны аялгууг ноотоор дуулцгаая.
- Дуу ямар хэмжээнд бичигдсэн байна вэ?
- Аялгууны хөдөлгөөн дэх холын үсрэлтүүдийг тодорхойлоорой.
- Тэмдэглэсэн хэсэгт байгаа бичилтийн учрыг тайлбарлаарай.

Ха -тан дэл - хийн ээ - жээ_ Хам -таар той - рон бү - жиг - лэе_

Хар шар ял - гаа - гүй_ Хам-таар той-рон бү-жиг - лэе_ А -чит дэл-хий-гээ той-

-роод_ Амь -тан бүг - дээ - рээ бү - жье_ Ал -тан на - раа_ у -

-риад_ Ая -лан дуу -лан бү - жиг - лэе_

Эх болсон дэлхийгээ
Эргэн эргэн бүжиглэе
Том бага ялгаагүй
Тойрон тойрон бүжиглэе

Ачит дэлхийгээ тойроод
Амьтан бүгдээрээ бүжье
Алтан нараа уриад
Аялан дуулан бүжиглэе




СОНСГОЛЫН СОРИЛ

1. Т.Чимэддорж “Залгамж үеийн тэмүүлэл”. Хөгжмөө анхааралтай сонсоорой. Сэдэв аялгууг ноотоор аялаад аль нь болохыг тодорхойлоорой.



Allegretto




2. С.В.Рахманинов “Вокализ”. Хөгжмөө анхааралтай сонсоорой. Зохиолын хурдыг тодорхойлоорой.

- a. Удаан, дуулалтай b. Хурдан c. Намуун, тайван

3. Т.Чимэддорж “Эргэж бидэндээ ирээгүй эцэгтээ бичсэн захидал”. Хөгжмөө анхааралтай сонсоод зохиолын агуулгыг илэрхийлэхэд аль нь тохиромжтойг сонгоорой.

- a. Уянгалаг b. Цоглог эрч хүчтэй c. Тайван

4. Т.Чимэддорж “Залгамж үеийн тэмүүлэл”. Сонсоод тохирох хэмнэлийн зураглалыг сонгоорой.



5. Хөгжмөө анхааралтай сонсоорой. Дараах зохиолууд дуулаачийн хөгжмийн ямар төрөлд хамаарах вэ? Ярилцаарай.

- a. Т.Чимэддорж “Залгамж үеийн тэмүүлэл”
b. Г.Пүрэвдорж “Дэлхий ээжийн төрсөн өдөр”
c. Т.Чимэддорж “Эргэж бидэнд ирээгүй эцэгтээ бичсэн захидал”



Д

1. Дуулаачийн хөгжмийн төрөлд аль нь хамаарах вэ?
 - a. Дуурь
 - b. Бүжгэн жүжиг
 - c. Симфони
2. Дуулаачийн хөгжмийн төрлийн хамгийн том хэлбэр аль нь вэ?
 - a. Баллада
 - b. Оратори
 - c. Дуурь
3. Дуулаачийн хөгжмийн төрлийн хамгийн энгийн, жижиг хэлбэр юу вэ?
 - a. Вокализ
 - b. Дуу
 - c. Романс
4. Хүүрнэл дуу аль нь вэ?
 - a. Баллада
 - b. Кантат
 - c. Романс
5. Магтан дуулах агуулгатай найрал дууны төрөл аль нь вэ?
 - a. Кантат
 - b. Оратори
 - c. Реквием
6. Аль нь дуулаачийн хөгжмийн төрөлд хамаарахгүй вэ? Сонгоод ялган тэмдэглэнэ үү?
 Үргүй дуу, хүүрнэл дуу, дуурь, эмгэнэлийн дуулал, ялгуусан дуулал, сюит, магтуу
7. Дуучны ур чадвар, дуулах арга барилыг хөгжүүлэхэд зориулагдсан дасгал буюу үргүй дуу хэмээн нэрлэгддэг төрөл аль нь вэ?
 - a. Вокализ
 - b. Романс
 - c. Кантат
8. Гурвуулаа зөв байх хувилбарыг олно уу.

1. Романс	a. Магтуу	A. 1b 2c 3a
2. Баллада	b. Хүүрнэл дуу	B. 1a 2b 3c
3. Кантат	c. Дууль	C. 1b 2a 3c
9. Ерөнхий нэрийг сонгоно уу?

1. Реквием, Оратори, Кантат	a. Гоцлол дуу	A. 1a 2b
2. Романс, Баллада, Вокализ	b. Найрал дуу	B. 1b 2a
10. Гурвуулаа зөв байх хувилбарыг олно уу.

1. Дуурь	a. Сэтгэл догдлом, баатарлаг үйл явдлын талаар уянгалаг өнгө аясаар өгүүлдэг	
2. Реквием	b. Урлагийн бүх төрлүүдийг нэгтгэсэн нийлмэл төрөл	
3. Баллада	c. Эмгэнэл харуулсын шинж төрхтэй	
	A. 1a 2b 3c	
	B. 1c 2a 3b	
	C. 1b 2c 3a	
11. Зөв хариултыг олж дугуйлаарай.


1. Вокализ	a. Опера	A. 1a 2b 3c
2. Оратори	b. Үргүй дуу	B. 1b 2c 3a
3. Дуурь	c. Ялгуусан дуулал	C. 1c 2a 3b



2.2. ДАН ХӨГЖИМ

Тайзны үйл хөдлөл, хөгжмийн хэлээр дүрслэн өгүүлэх дуурь, бүжгийн жүжгээс гадна зөвхөн сонсоход зориулан зохиосон хөгжим байдаг. Үүнийг дан хөгжмийн зохиол гэдэг. Дан хөгжмийн зохиол дотроо олон янз. Зарим нь ганц нэгээрээ тоглоход зориулагдсан байхад цөөн хэдэн хүн хамтран хөгжимдөх зохиол бас байдаг. Тийм хөгжмийг цөөхүүл хөгжим гэнэ. Жишээлбэл: хоршил, гурвал, дөрвөл, тавал гэх мэт.

Мөн олуулаа хамтран хөгжимдөхөд зориулан бичсэн найрал хөгжмийн зохиолууд байдаг. Тийм зохиолыг харин симфони зохиол гэдэг. Симфони буюу “Symphony” нь монголоор “нийцэн эгшиглэх” гэсэн утгатай грек үг. Тэгэхлээр симфони найрал хөгжмийн бүрэлдэхүүнд харилцан бие биенээ дэмжин, нэгэн утга санааг илэрхийлэхийн тулд нийцэн эгшиглэдэг олон төрлийн хөгжмийн зэмсэг багтана.



Д

- Дан хөгжмийн зохиолын зарим төрлүүдтэй танилцаад, шинэ нэр томьёо, ойлголтын тайлбарыг хийгээрэй.

№	Нэр томьёо	Үндсэн утга
1.		



Ф.Шопен

ЭТЮД № 3 (судалбар аяз)

Этюд гэдэг нь франц хэлнээс гаралтай “дасгал, сургуулилт” гэсэн утгатай уг бөгөөд урлагийн бүх төрөлд хэрэглэгдэг нэр томьёо юм.

Дуучны хоолой, дуулах арга техникийг хөгжүүлэх дасгалыг вокализ гэдэг. Харин хөгжимдөх арга барил, ур чадварыг хөгжүүлэх зорилготой дасгалыг этюд гэдэг.

Польшийн алдарт хөгжмийн зохиолч Ф.Шопен этюд тус бүрдээ хөгжимдөх техникийг харуулахын зэрэгцээ, хүний сэтгэл санааны олон янзын хувирал өөрчлөлтийг илэрхийлдэг.


-  - Хөгжмөө сонсоод зохиол хэдэн хэсэгтэй болохыг тодорхойлж, давталт ялгарамжид тулгуурлан үсгээр тэмдэглээрэй.
- Эхийг уншаад сонссон хөгжимдөө тулгуурлан өгөгдсөн үгсээс тохирохыг цэгийн оронд сонгож бичээрэй.
-  - Этюдийн аялгууг ноотоор дуулцгаа.

Ми мажорт гайхалтай тансаг уянгаар эгшиглэх энэхүү этюдээ хөгжмийн зохиолч өөрийн хамгийн сайхан нэг гэж тооцдог. Энэ аялгуу бодлогоширсон, чин сэтгэлийн дуу шиг сонсогддог. Энгийн дуурьсал болон хөгжмийн зэмсгийн дуугаралтыг санагдуулам хоолойн нэг хэвийн өнгө аяс нь энэхүү зохиолын өнгө төрхийг тодруулдаг.

Зөөлөн , үл мэдэгдэм агуулсан эхний хэсэгтэй тод ялгарамж үүсгэх дунд хэсэгт хөгжимчний жинхэнэ утгаар илэрнэ. Дуурьсал тогтвортгуй болж, нь өөрчлөгдөн, аялгуу өрнөн хөгжиж, сэтгэл хөдлөлийн оргилд хөтөлдөг. Харин товч агуулгаар эргэн давтах нь сэтгэл хөдлөлөө дарж, гунигтайгаа эвлэрэх мэт сэтгэгдэл төрүүлдэг.

Аялгууны, аргил, төгсгөл, хөөрөгт цуур, уянга, гуниг, ур чадвар, эхний хэсгийг, хурд, үндэсний

Lento ma non troppo



stretto riten.



Г.Свиридов

РОМАНС

Дуулаачид зориулсан үггүй дуу байхаас гадна дан хөгжимд ч үггүй дуу байдаг. Тэдгээр нь дууны төрлийн нэг адил аялгуу, ари, романс, серенада гэхчлэн нэрлэгддэг.

Г.Свиридовын “Романс” хэмээх энэ бүтээлд хөгжмийн зэмсгүүд хос хосоороо ээлжлэн гол үүрэг гүйцэтгэх бөгөөд аялгуу нь уянгын бодлогошронгуй шинж төрхтэй.

015

- Хөгжмөө сонсоод, зэмсгүүдийг нэрлээрэй. Зэмсгүүд эгшиглэх өнгө аясаараа хэрхэн ялгарч байна вэ?
- Зураглалыг ажиглаад, хөгжимд эгшиглэх дарааллаар нь дугаарлаарай.
- Хэсэг тус бүрт хамсрааг ямар хөгжмийн зэмсгээр гүйцэтгэж байна вэ?



?



?



?



?



?

БАРКАРОЛА

Италийн Венец хотын завьчдын дуунаас гаралтай энэ төрөл нь 6/8 хэмжээтэй, усан дээр дайвалзах завь түүнийг сэлүүрдэх хөдөлгөөнийг санагдуулам нэг жигд хэмнэлийн хамсраатай. Баркарола нь зөөлөн, уянгын, гэгэн мөрөөдлийн өнгө аястай тул минорын хөт бичигддэг. Итали, францын хөгжмийн зохиолчдын уран бүтээлд өргөн хэрэглэгдэж байжээ. Мөн Ф.Шуберт, Ф.Мендельсон Бартольди, М.Глинка нарын дуулаачийн хөгжмийн бүтээл, Ф.Шопен, П.И.Чайковский, С.В.Рахманинов, Г.Форе, Б.Барток болон бусад хөгжмийн зохиолчдын дан хөгжмийн бүтээлд элбэг тааралддаг.




Ж.Оффенбах
(1819-1880)

Жак Оффенбах францын хөгжмийн зохиолч, театрын удирдаач, виолончель хөгжимчин, францын опереттийн урлагийг үндэслэгч. Тэрбээр 6 дуурь, романс, цөөхүүл зохиолууд гээд дуулаачид зориулсан цөөнгүй бүтээл түүрвисан ч уран бүтээлийн гол төрөл нь оперетта буюу наргиант дуурь юм. Энэ төрлөөр хөгжмийн зохиолч 100 орчим бүтээл түүрвижээ.

Францын хөгжмийн зохиолч Жак Оффенбахын эхлэл, З үзэгдэл, төгсгөл бүхий “Хофманы үлгэрүүд” дуурийн хамгийн алдартай хэсгийн нэг нь гол дүр болох Джульеттагийн баркарола юм.



- Зохиолоо сонсоод, хэмнэлийн зураглалаар хамсран хөгжимдөөрэй.
- Ноотыг ажиглаад, сэдэв аялгууг сонсоод дагаад аялаарай.



Moderato



С.Гончигсумлаа

ПРЕЛЮДИ



С.Гончигсумлаа
(1915 - 1991)

Сэмбийн Гончигсумлаагийн уран бүтээлийн төрөлд төгөлдөр хуурт зориулсан туурвилууд нь онцгой байр суурьтай. Тэрээр хаан хуур хэмээдэг энэ зэмсэгт бэсрэг аяз, ардын дууны найруулгаас аваад прелюди, концерт гээд олон төрөл хэлбэрээр 200 гаруй бүтээл туурвижээ. Эдгээр бүтээлүүдээ монгол ардын дууны хөг аялгуу, дуурьслын онцлогийг сонгодог хэв маяг, бүтэц, дуурьсалтай чадварлагаар хослуулсан байдаг.

С.Гончигсумлаагийн 24 прелюди нь монгол ахуй, ард түмний амьдрал, баяр цэнгэлийг илэрхийлсэн олон талт дүрслэлтэй цогц бүтээл юм. Хөгжмийн зохиолч бүтээлүүддээ ардын дууг өргөн ашигладаг нь энэхүү бүтээлд тусгалаа олжээ. Энэхүү цувралаа тавцын зайгаар эрэмбэлэн, зэргэлдээ хөгийн зарчимд тулгуурлан 24 дэвсгэр хөгт бичсэн байна.



- Зүй тогтлыг ажиглаад хүснэгтийг нөхөж, прелюди тус бүр ямар дэвсгэр хөгт туурвигдсаныг олж, тогтоогоорой.

№	I	III		VII		XI	XIII		XVII	XIX		
Дэвсгэр хөг	C	G				H	Ges		As	Es		
№	II		VI			XII	XIV	XVI			XXII	
Дэвсгэр хөг	a		h			gis	es	b			g	

ПРЕЛЮДИ №18

24 прелюдийн оргил нь болох Adajio буюу тайван удаан хурдтай XVIII прелюдээ зохиолч буриад ардын “Тэнсэ л үгүй” дуунаас сэдэвлэн бүтээжээ. Энэ аяз гүнзгий утга, бодлогошронгуй өнгө аяс, баялаг дуурьсалтай. Зохиолч сэдэв аялгуугаа A - A1 – A2 гэх мэтээр хувилбарлан хөгжүүлж давтахдаа *p - ff* хүртэл янз бүрийн хүчдэлийг оноож, өргөн тэнүүн өрнөлөөр төгсгөжээ.



- Хөгжмөө сонсоод, аялгууны хувилбар бүрийн хүчдэлийг тодорхойлоорой.
- Хэмнэлийн зураглалыг ажиглан аялгуунд тохирохыг сонгоорой.

*p*

?

*ff*

?



?



?



?





В.А.Моцарт

СОНАТ №11

Сонат – зөрчилт хөгжим (итал. sonare — эгшиглэх). Гоцлол цөөхүүл хөгжмийн нэг төрөл. Сонгодог зөрчилт зохиол ихэвчлэн гурван ангитай байдаг.



В.А.Моцарт
(1756-1791)

Австрийн суут хөгжмийн зохиолч, хөгжимчин Вольфганг Амадей Моцарт сонгодог хөгжмийн соёлд томоохон хувь нэмрийг оруулжээ. Тэрбээр 20 гаруй дуурь, 41 симфони, жүжгийн хөгжим, месса, магтуу зэрэг найрал дууны бүтээлүүд, янз бүрийн бүрэлдэхүүнтэй цөөхүүл хөгжмийн бүтээл, 60 гаруй сонат, 40 гаруй концерт нийт 600 гаруй бүтээл туурвисан билээ.

Австрийн суут хөгжмийн зохиолч В.А.Моцартын XI сонат (ля мажор) нь “Түрк марштай сонат” хэмээн алдаршсан юм.

I анги нь гэгээлэг, тайван, энгийн дууг санагдуулам сэдэв ая.

II анги нь давталтат 3 хэсэгт хэлбэр бүхий менуэт (эртний Францын ардын бүжиг). Сонсогчдын сайн мэдэх түрк марш нь энэ сонатны III анги юм. Энэ ангия зохиолч “Түрк маягаар” хэмээн нэрлэсэн нь хожим “Түрк марш” гэгдэх болсон байна.



Энэ хөгжимдөө зохиолч тухайн үед хүмүүсийн сонирхлыг ихэд татдаг байсан туркийн янычар буюу осман цэргийн хөгжмийн онцлогийг дуурайхыг зорьсон ажээ. III анги нь уян налархай, бүжгийн өнгө аястай минорын гол аялгуу, хүндэвтэр, эрч хүчтэй мажорын дахилтын ялгарамж дээр тулгуурлан хөгжсөн байдаг.

Уян налархай минорын аялгуу




Эрч хүчтэй мажорын аялгуу



Д

- Өөр хоорондоо ялгаатай сэдэв аялгуунууд хэрхэн бие биеэ сэлгэн тойрог хэлбэр үүсгэснийг сонсож ажиглаарай.
- Зураглалыг ажиглаад, тэмдэглэл хийгээгүй хэсэгт ямар сэдэв аялгуу эгшиглэснийг сонсож тодорхойлоод үсгээр томьёолоорой.



- Хэмнэлийн зураглалын дагуу хөгжмөө сонсоод ABCD хэсгүүдийн ялгарамжийг ярилцаарай.

А хэмнэлийн зураглал



В хэмнэлийн зураглал



С хэмнэлийн зураглал



D хэмнэлийн зураглал





Г.В.Свиридов
(1915-1998)

Георгий Васильевич Свиридов нь Оросын хөгжмийн зохиолч, төгөлдөр хуурч, нийгмийн зүтгэлтэн, ардын жужигчин, хөдөлмөрийн баатар, төрийн шагналт.

Тэрээр дуулаачид зориулан дуу, романс, ялгуусан дуулал, магтуу, найраглал, дан хөгжмийн төрлөөр симфони, концерт, тайз дэлгээцийн бүтээлүүд түүрвиснаас “Шуурга”, “Цаг үе урагшаа” киноны хөгжмөөс сэдэвлэсэн чуулбар нь алдартай. Г.Свиридовын хөгжмийн хэл маш энгийн, хэн бүхэнд ойлгомжтой байдаг.

Г.В.Свиридов

ХАВАР БА НАМАР ("Шуурга" чуулбар)

018

- Хөгжимд аль улирлыг эхлээд дүрсэлсэн байна вэ?
- Хавар, намрын улирлын ялгааг чухам юунаас сонсож мэдэрсэн бэ?
- Сүүлийн хэсгийн эгшиглэгээний онцлог эхнийхээс ямар ялгаатай байна вэ?
- Доорх хүснэгтээс санаа авч баяжуулан хавар, намрын улирлыг хөгжмийн илэрхийлэл болоод хэлний арга хэрэглүүрээр хэрхэн зурагласныг тодорхойлон ярилцаарай.



Хөгжмийн хэлний арга хэрэглүүрүүд

№	Чиглэл	Агуулга
1.	Аялга ямар байна вэ?	Уриалах, асуух, ёлох, хүүрнэх
2.	Хэмнэлийг тодорхойлоорой.	Тасалдсан, жигд, маршийн, вальс бүжгийн
3.	Аялгууны хөдөлгөөн ямар байна вэ?	Давалгаа маягийн, үсэрсэн, жигд дараалсан, нэг ноотон дээр давтсан....
4.	Цомнолыг тодорхойлоорой.	Мажор, минор

Хөгжмийн илэрхийллийн арга хэрэглүүрүүд

№	Чиглэл	Агуулга
1.	Төрөл зүйлийг тодорхойлоорой.	Дуурь, балет, симфони, концерт, удиртгал, жижиг хэлбэрийн зохиол, дуу....
2.	Хөгжимдэх бүрэлдэхүүн ямар байна вэ?	Найрал хөгжим (симфони найрал, утсан, үлээвэр....), найрал дуу, цөөхүүл, гоцлол....
3.	Хурдыг тодорхойлоорой.	Хурдан, тайван, удаан.....
4.	Хүчдэлийн өөрчлөлтийг сонсож тодорхойлоорой.	Чанга, сул, аяар, аажим аяар болох, чангараах



Д

СОНСГОЛЫН СОРИЛ

1. Хөгжмөө анхааралтай сонсоорой. Хөгжмийн зохиол хэдэн хэсгээс бүтэж байна вэ? Зөв хувилбарыг сонгоорой. Үүнийг мэдэхийн тулд:

- Аялгуу давтагдаж байгаа эсэх
- Аялгууны хэсгүүд хоорондоо ялгарамжтай эсэхийг анхаарах хэрэгтэй.

Ж.Оффенбах. “Баркарола”.

A - A1 - A2

A - B - C

2. Хөгжмөө анхааралтай сонсоорой. Хөгжмийн зохиолын хурдыг тодорхойлоорой. Ц.Сүхбаатар. “Үүлэн бор”

Allegro

Andante

Adagio

3. Хөгжмөө анхааралтай сонсоод, зохиолын эгшиглэлтийн хүчийг тодорхойлоорой. Ф.Шопен. “Этюд №3”

Крешендо

Пиано *p*Форте *f*

4. Хөгжмөө анхааралтай сонсоод, доорх хэмнэлийн зураглалаас зөв хувилбарыг сонгоорой. В.А.Моцарт Сонат №11 “Турк марш”



5. Дээрх сонссон хөгжмийн зохиолуудын талаар дараах асуултад хариулж дэвтэртээ бичээрэй.

№	Хөгжмийн зохиол	Хөгжмийн зохиолын ямар төрөлд хамаарах	Ямар бүрэлдэхүүнд зориулагдсан	Хурд	Хүчдэлийн өөрчлөлт
1.					



6. С.Гончигсумлаа Прелюди №18. Хөгжмөө анхааралтай сонсоорой.

Ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсөн бэ? Сэдэв аялгууг ноотоор дагаад аялаарай. Хөгжмийн зохиолын ямар төрөлд хамаарах вэ? (дуулаач, дан хөгжим, киноны хөгжим)

Adagio

3

7. М.И.Глинка “Камаринская”. Сэдэв аялгуу ямар хөгжмийн зэмсгүүдийг дамжин хөгжиж байна вэ? Анхааралтай сонсоод, зураг дээрээс зөв хувилбарыг сонгоорой.



5



Д

1. Дан хөгжмийн төрөлд аль нь хамаарах вэ?
 - a. Дуурь
 - b. Бүжгэн жүжиг
 - c. Симфони
2. Дан хөгжмийн төрлийн хамгийн том хэлбэр аль нь вэ?
 - a. Симфони
 - b. Аяз
 - c. Концерт
3. Аль нь дан хөгжмийн төрөлд хамаарахгүй вэ?
 - a. Дуу
 - b. Сонат
 - c. Сюйт
4. Дан хөгжмийн төрлийн хамгийн жижиг хэлбэр юу вэ?
 - a. Аяз
 - b. Симфони
 - c. Удиртгал хөгжим
5. Аль нь цөөхүүл хөгжимд хамаарах вэ?
 - a. Гоцлол
 - b. Дөрвөл
 - c. Найрал
6. Удиртгал хөгжим аль нь вэ?
 - a. Ноктюрн
 - b. Серенада
 - c. Увертюр
7. Этюд гэж юу вэ?
 - a. Үдшийн хөгжим
 - b. Техник хөгжүүлэх дасгал
 - c. Оршил хөгжим
8. Квартет гэж юу вэ?
 - a. Цөөхүүл хөгжмийн бүтээл
 - b. Найрал хөгжмийн бүтээл
 - c. Гоцлолд зориулсан бүтээл
9. Хоёр хийл, эрдүү хийл, морин хийл гэсэн гэсэн бүрэлдэхүүнтэй хамтлаг юу вэ?
 - a. Чавхдаст хөгжмийн дөрвөл
 - b. Цөөхүүл хөгжмийн хамтлаг
 - c. Хийлийн чуулга
10. Гоцлбор хөгжим аль нь вэ?
 - a. Концерт
 - b. Сюйт
 - c. Увертюр
11. Нэг ерөнхий агуулгад зангиdsan, олон янзын шинж төрхтэй аязуудаас бүтсэн хөгжмийн бүтээл аль нь вэ?
 - a. Сюйт
 - b. Сонат
 - c. Концерт
12. Чуулбар хөгжим аль нь вэ?
 - a. Симфони
 - b. Концерт
 - c. Сюйт
13. Хурдан темптэй, жижиг хэлбэрийн хөгжмийн хошигнол аль нь вэ?
 - a. Баллада
 - b. Скерцо
 - c. Романс
14. Хөгжимчний ур чадварыг хөгжүүлэхэд зориулагдсан дасгал буюу хөгжмийн жижиг хэлбэрийн бүтээл аль нь вэ?
 - a. Ноктюрн
 - b. Сюйт
 - c. Этюд
15. Утга уянгын шинжтэй төгөлдөр хуурын жижиг аяз аль нь вэ?
 - a. Ноктюрн
 - b. Этюд
 - c. Сонат



Д

16. Гурвуулаа зөв байх хувилбарыг олно уу?

- | | | |
|------------|-------------|-------------|
| 1. Сюит | a. Гоцолбор | A. 1b 2c 3a |
| 2. Концерт | b. Чуулбар | B. 1a 2b 3c |
| 3. Увертюр | c. Удиртгал | C. 1b 2a 3c |

17. Ерөнхий нэрийг сонгоно уу?

- | | | |
|---------------------------|------------------|-------------|
| 1. Симфони, увертюр, сюит | a. Цөөхүүл | A. 1b 2c 3a |
| 2. Концерт, сонат | b. Найрал хөгжим | B. 1a 2c 3b |
| 3. Квартет, трио, дуэт | c. Гоцлол хөгжим | C. 1c 2a 3b |

18. Гурвуулаа зөв байх хувилбарыг олно уу?

- | | | |
|-------------|--|--|
| 1. Увертюр | a. Хөгжимчний ур чадварыг хөгжүүлэхэд зориулсан | |
| 2. Этюд | b. Дараалал гэсэн утгатай олон янзын шинж төрхтэй | |
| 3. Сюит | c. Зохиолын агуулгыг хураангуйлсан удиртгал хөгжим | |
| A. 1c 2a 3b | | |
| B. 1a 2c 3b | | |
| C. 1b 2a 3b | | |

19. Зөв хариултыг олж дугуулаарай.

- | | | |
|------------|--------------------|-------------|
| 1. Ноктюрн | a. Үдшийн хөгжим | A. 1b 2c 3a |
| 2. Концерт | b. Эхлэл хөгжим | B. 1a 2c 3b |
| 3. Прелюди | c. Гоцолбор хөгжим | C. 1c 2a 3c |

20. Бүгдээрээ зөв байх хувилбарыг сонгоорой.

- | | | |
|-----------------------------|--------------------------|--|
| 1. Кантат, Реквием, Оратори | a. Гоцлол төрөл | |
| 2. Сонат, Прелюди, Концерт | b. Найрал дууны төрөл | |
| 3. Сюит, Увертюр, Симфони | c. Найрал хөгжмийн төрөл | |
| A. 1b 2a 3c | | |
| B. 1a 2b 3c | | |
| C. 1b 2c 3a | | |

21. Аль нь дан хөгжмийн төрөлд хамаарахгүй вэ? Сонгоод ялган тэмдэглэнэ үү?

Удиртгал хөгжим, үдшийн хөгжим, гоцолбор, чуулбар, симфони, сонат, реквием



2.3. ДУУЛЬЯ



- Дасгалыг хоёр хоолойгоор ноотоор дуулаарай.
- Хоолойн дасгал, дууны 9-13-р айзмын ноот бичлэг хоёрыг харьцуулан ажиглаарай.
- Шүлгийн утгыг аялгууны шинж төрх, дуулах хурдтай холбон ярилцаарай.



Ая. Г.Эрдэнэчулун

Үг. Г.Ганболд

ИХ НААДМЫН ТЭНГЭР ДОР


Allegro

Хү - ний орч-лон бүг - дээ - рээ Хүүх-дийн дуу - гаар цал - гиж байна
 Эх ур - сийн сүүн сэт - гэл Энэ - хэн дэл - хийг баяс - гаж бай - наа
 Мон - гол түм - ний хүүх - дийн наа - дам ү - ер - хэл нө - хэр - лөл
 Эв нэгд - лийг би - лэг дэж байна. би - лэг дэж бай - наа.

Гэгээн бүхнийг урин залсан
 Их наадмын тэнгэр дор
 Хүүхдийн хүсэл энхийн нарыг
 Хүний орчлонд билэгдэж


Удамт монголын үрсүүд
 Уулзан золгоод наадаж байна
 Цээлхэн дууны уяхан эгшгээр
 Цэлмэг тэнгэрт өргөж

Монгол түмний хүүхдийн наадам
 Үерхэл нөхөрлөл эв нэгдлийг
 Билэгдэж байна билэгдэж байна



Энэ дууг ямар цараанд дуулж байна вэ?
 Царааг тодорхойлоорой.

- Үгийг тод, зөв дуудаарай.
- Сүүлийн хоёр айзамд “билэгдэж байна” гэдэг үгийг хоёр өөр хэмнэл, хоёр өөр хуваариар дуудахыг анхаараарай.



Эв нэгд - лийг би - лэг - дэж байна би - лэг - дэж бай - на



- Хоолойн дасгалыг хоёр хоолойгоор дуулаарай.
- Дууны утга санааг ярилцаарай.
- Дууны эхлэл хэсгийг бишгүүрээр хөгжимдөөрэй.
- Айзмын дунд байгаа амьсгааны тэмдгийг анхаараарай.



Англи дуу

WE WISH YOU A MERRY CHRISTMAS

Brightly, with spirit


6 C A D B We wish you a Mer-ry
Christ-mas We wish you a Mer-ry Christ-mas we wish you a Mer-ry Christ-mas and a
Hap-py New Year. Good tid-ings to you wher-ev-er you are; Good tid-ings for
18 Christ-mas and a Hap-py New Year. 2. Oh (repeat) wish you a Mer-ry Christ-mas We
23 A D B Em C D G wish you a Mer-ry Christ-mas we wish you a Mer-ry Christ-mas and a Hap-py New Year.

Oh bring us a figgy puding
Oh bring us a figgy puding
Oh bring us a figgy puding
And a cup of good cheer.

Good tidings to you
Wherever you are
Good tidings for Christmas
And a Happy New year




- Хэмнэлийн хамсрааг өөрийнхөө мэдрэмжээр баяжуулж илүү хөгжингүй болгоорой.





- Амьсгааг зөв авч дуулаарай.
- Хагас шатаар дээшилж, доошилж байгаа хэсгийг давтаарай.
- Дууны мөр бүрийн төгсгөлийн эгшгийг гарын тулгуур дохиогоор үзүүлж дуулцгаая.
- Дууны царааг тодорхойлоорой. Энэ дууг ямар цараанд дуулж байна вэ?



- Тохиолдлын тэмдэг бүхий өрөг дараалсан хөдөлгөөнийг дуулахдаа багшийг болон нөхдийгөө анхааралтай сонсож, нийцэлтэй дуулаарай.

DO, RE, MI


4 | Doe a deer a fe - male dear Ray a drop of gol - den sun
 5 | Me a name I call my self Far a lon - ger way to run
 9 | So a need - le put in threal La a note to far a so
 13 | Tea a drink with jam and bread that will bring us back to Do oh oh oh
 17 | So, Do, La, Fa, Mi, Do, Re So, Do, La, Ti, Do, Re, Do

Doe, a deer, a female deer
 Ray, a drop of golden sun
 Me, a name I call myself
 Far, a long, long way to run

Sew, a needle pulling thread
 La, a note to follow Sew
 Tea, a drink with jam and bread
 That will bring us back to Do



Do Re Mi Fa So La Ti Do





- Эгшгийн үсрэлтийг гарын дохио ашиглан мэдэрч дуулаарай.



- Ноот бичлэгийг ажиглаарай.
- Хэмнэлээр тогшоод, ноотоор аялаарай.
- Ямар ялгаатай вэ?
- Тусгайлан тэмдэглэсэн хэсэг дэх лига, легато буюу нуман холбоосын үүргийг ярилцаарай.



Ая. Г.Эрдэнэчулзуун

Үг. З.Түмэнжаргал

УЛААНБААТАРТАА БИ ХАЙРТАЙ

Аа - вын мөн-ген ер - геे - ний Ам - га - лан
 6 цэн-хэр хой - мор шиг У - хаан бо - долд ээ - нэг - хэн
 12 У - лаан баа-тар-таа бид хайр - тай Богд Дүн - жин
 17 га - рав-тай - гаа бид Бор-хон зүрх - ний хол-боо - той
 23 Ха - тан тунга - лаг Туул - тай - гаа бид Ха-луун амь - ны
 27 хэл - хээ - тэй хэл - хээ - тэй хэл - хээ - тэй


Ээжийн энэрэл шингэсэн
 Ээлийн дулаан өлгий шиг
 Саная сэтгэлд дотнохон
 Саруулхан хотдоо би хайртай

Дөрвөн уулын дундаа
 Түвшин жаргахын заяатай
 Дөрвөн улирлын эргэлтэндээ
 Түгшүүр амсахгүй өлзийтэй





- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийн ноотыг ажиглаад, ялгааг илэрхийлж дуулаарай.
- Хоолой салгаж дуулахдаа аялгууны чиглэлийг заасан тэмдэглэгээг ажиглаарай.



Ая. Т.Насанбуян

Үг. Ж.Бадраа

ГЭГЭЭН НАРАН

Дунд зэрэг

1
Э - хийн хай - раар и - вээ - сэн

3
Эрдэ - нийн на - ранд бид дур - тай

5
Гэр - лийн хур - даар и - вээ - сэн

7
Гэ - гээн на - ран гий - гүүлж байг

9
Ай хө гэ - гээн на - ран

13
Гэ - гээн на - ран

Эцгийн элгээр эрхлүүлсэн
Энхийн наранд бид дуртай
Тэнгэрийн энгээр энхрийлсэн
Тэнүүн наран тэтгэж байна.

Дээдийн жаргал эдлүүлсэн
Дэлхийн наран хүүхдийн хайр
Хотлын цэнгэл хөгжөөсөн
Хорвоон наран мандтугай





- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдэд хоолой тус бүр дуулах дасгал хийгээрэй.

Ая. Р.Энхбазар

Найралжуулгыг Г.Отгонбаяр
ДУУНЫ ЦЭНХЭР ЦЭЦЭГ

Сэргэлэн цовоо

C

Цэ - цэг цэц-гийн э - хэнд цэн-хэр яр - гуй урга - на Цэн-гэл цэнгэ - лийн ту - рүүнд Эр - хэм эрх-мийн дээ - дээр эзж авы - гаа хүн - дэлж Эр - дэм Эрд - мийн дээ - жээр

A

Цэ - цэг цэц-гийн э - хэнд цэн-хэр яр - гуй урга - на Цэн- гэл цэнгэ - лийн ту - рүүнд Эр - хэм эрх-мийн дээ - дээр эзж авы - гаа хүн - дэлж Эр - дэм Эрд - мийн дээ - жээр

T

7

Цээл-хэн дуу - гаа ёрге - нө ёрге - нө Дуу дуу - ны - хаа маг - найд дуулж ая - лья Эх оп - ноо хайрла - на хайрла - на.

Цээл-хэн дуу - гаа ёрге - нө ёрге - нө Дуу дуу - ны - хаа маг - найд дуулж ая - лья Эх оп - ноо хайрла - на хайрла - на.

8

13

Үү - ний - гээ Хү - сэл хүс-лийн ман - лайд хүн - дэлж ач - лья түү - ний - гээ.

Үү - ний - гээ Хү - сэл хүс-лийн ман - лайд хүн - дэлж ач - лья түү - ний - гээ.

8

Уянга уянгын эгшгээр
Ард түмнээ магтана
Ухаан ухааны эрдмээр
Ачит намаа баходана



2.4. ХӨГЖИМДЬЕ







Хөгжимдэх дүрэм



- Ноот бичлэгийг ажиглаж хэмнэлээр тогшино.
- Эшгүүдийн хөдөлгөөнийг ажиглаад ноотоор аялж үзнэ.
- Хөгжимдөхдөө хурууны дугаарыг баримтална.
- Тэмдэглэгээний дагуу амьсгааг зөв авч хуваарилна.



- Хөгжимдэх зохиолын үлээвэр даралтат хөгжмийн хэсгийн ноотыг ажиглавал зарим хэсэгт фа түлхүүрт хөгжимдэх байна. Тиймээс фа түлхүүрийн ноотыг хөгжимдэх дасгал хийгээрэй.





- Хүүхдүүд ээ! та нарын өмнөх ангиудад үзэж суралцсан болон шинээр сурч мэдэх бишгуурийн бүх даралтыг энэхүү хэсэгт багтаалаа. Хөгжимдөх дасгал хийгээрэй.

Та нар үүнийг мэднэ, бас хөгжимдөж чадна.

Харин энэ хэсэгт одоо суралцана.








- Бишгүүр хөгжмээр хамтран хөгжимдөөрэй. Хөгжимдөхийн өмнө ноот бичлэгийг анхаараарай.
- Хувиргалын тэмдгүүд хаана байна вэ?
- Та нарын сайн мэдэх хөгжмийн ямар тэмдэгтүүд байна вэ? Тэдгээрийг хэрхэн илэрхийлж хөгжимдөх вэ?

Жарардо Метос Родриго

АРГЕНТИН ТАНГО

Moderato


Дахилтын тэмдэг



Тухайн эгшгийг хагас тон дээшлүүлнэ.



Тухайн эгшгийг цэвэршүүлэн хөгжимдөнэ.



Дөрөвт ноотны зогсоц



Наймт ноотны зогсоц



Стаккато





- Хөгжимдөх дүрмээ санацаа. Хамтлаг хөгжимд дүрмийг баримтлан нөхдийгөө сонсож хамтрах нь хамгийн чухал.
- Хөгжимдөхийн өмнө ноотоо ажиглаад, хүндрэлтэй хэсэг дээр тогтох ажиллах хэрэгтэй.
- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийг анхаарч, хэд хэдэн удаа хөгжимдөх дасгал хийгээрэй.

Хэнри Клэй Ворк

ӨВӨӨГИЙН ЦАГ

Moderato

Moderato

5







10




15

20

24




Ми бемоль
эгшиг-EbСи бемоль
эгшиг- HbМи бемоль эгшиг
-Eb II октав

Монгол ардын дуу

БУЛИГААР ХҮРЭН ЦҮНХ



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийг зөв тоглохын тулд эхлээд хэмнэлзэр хөгжимдөөрэй.



Дунд зэрэг





- Хөгжимдэж эхлэхийн өмнө хувиргалын тэмдэгтэй эгшгүүдийг тэмдэглээрэй.
- Зохиолын утга агуулгыг бүрэн илэрхийлж гаргахад хүчдэлийн тэмдгүүд тусална. Тиймээс хүчдэлийн тэмдгийг зөв илэрхийлээрэй. Эдгээр тэмдгүүд ямар үүрэгтэй вэ?
- Тусгайлан тэмдэглэсэн хэсэгт хэмнэлийг анхаарч хөгжимдөөрэй.

Фүрүсато хэмээх дуу нь Японы хамгийн алдартай дуунуудын нэг. Голын ус хоржигнон дуугарч, шувууд эрх дураараа жиргэх тэр л сайхан нутгаа санагалзах сэтгэлийг илэрхийлжээ.

- Хөгжимдөхдөө утга агуулгыг нь тунгаан, тэрхүү сэтгэгдлийг илэрхийлэн хөгжимдөөрэй.
- Уг бүтээлийг бишгүүрээр хөгжимдөх үед тохиолдох хүндрэлийн талаар ярилцаж, нөхдөдөө туслаарай.

Япон ардын дуу

ФҮРҮСАТО
(Төрсөн нутгийн дуу)


Andante

8


12



ХУВИРГАЛЫН ТЭМДЭГ АШИГЛАН ХӨГЖИМДҮЕ



Фа диез эгшиг- F#



До диез эгшиг- C#



Үг. Л.Соронзонболд

ГОВИЙН ӨГЛӨӨ

Тайван

12

6

1.

2.

Эхний хоёр хувийн зогсцыг зөв мэдэрч тоглохын тулд хэмнэлээр тогшиж, тоолж, хэмжээгээ аваарай.





- Хөгжимдэхийн өмнө хэмнэлийн дасгалыг гүйцэтгээрэй. Хэмнэлийг ойлгож, хэмжээг мэдэрч нэгэн зэрэг хөгжимдөхөд туслах болно.
- Тусгайлан тэмдэглэсэн хэсэг дэх тэмдгүүдийн үүргийг ярилцаарай.
- Хоолойнуудын харилцан ярилцах, бие биеэ дагаж хөөцөлдөх хэлбэрийг ноотноос ажиглаж, сонсож хөгжимдөөрэй.



К.Т.Такамура

ХҮҮХЭД НАС

Vivace

1

24

3

35

45

54





- Гурвал эгшгүүдээ эргэн санацгаая.

I



IV



V



- Гурвал эгшгүүдээр аялгуу зохиоцгооё. Ингэхдээ өгөгдлийг (I, IV, V) анхаарна уу.
- Эхний айзмаас жишээ аваарай.
- Зохиосон аялгуугаа багштайгаа хамтран бишгүүрээр хөгжимдөөрэй.

5

5



- Аялгуу зохиоцгооё. Өгөгдсөн ноотыг үргэлжлүүлэн аялгуу зохиогоорой. Зохиосон аялгуугаа бишгүүрээр хөгжимдөж нөхдөдөө сонсгоорой.
- Чиний зохиосон аялгууны хурд, хүч нь ямар байх вэ?



5



ХӨГЖИМ VII

МОНГОЛ АРДЫН ДУУ ХӨГЖИМ



МОНГОЛ АРДЫН ДУУ ХӨГЖИМ

Найралжуулгыг У.Мөнхжаргал

ЗУУН ЛАНГИЙН ЖОРОО ЛУУС
(Богд хаант Монгол Улсын Сүлд дуулал)

Хүндэтгэлтэй

Cello (C) lyrics:

Зуун гаас лан гийн сан жо роо луу - сыг аа
 Зуу - гаас зал - сан - Богд Зон - хов ла - мы - гаа

Piano (A) lyrics:

Жуу зан дун даа хө лөг лөө дөө хө
 Залби ра - лын ши - рээнд зал - лаа даа хө.

Мөнгөн амсартай бүрээ бишгүүрээ
 Мөрөн дээрээ татлаа даа хө
 Мөнх настай Богд Зонхов ламыгаа
 Мөргөлийн ширээнд нь заллаа даа хө

Алтан амсартай бүрээ бишгүүрээ
 Асрын үүдэнд татлаа даа хө
 Аврал ихтэй Богд Зонхов ламыгаа
 Авралын ширээнд нь заллаа даа хө



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ АРДЫН ДУУ ХӨГЖМΙЙН ТӨРЛҮҮД

Ардын дуу хөгжим гэдэг бол ард олны хүсэл эрмэлзэл, ахуй амьдралыг тусган илэрхийлсэн, олон түмний сэтгэлийг татан таалалд нь нийцсэн, олон үе дамжин уламжилж ирсэн, монголын ард түмний амины өмч шиг болсон дуу хөгжим юм. Зохиогчийн хувьд бол ард түмний дундаас урлан бүтээх авьяас билиг бүхий хүмүүс зохион туурвидаг байна. Харин тэр дуу ард түмэнд дэлгэрэхэд сайн дуучид, хөгжимчид өөрсдийн хувь нэмрийг оруулж, ур чадлыг нь нэмэн, хийц зохиомжийг нь баяжуулан хөгжүүлдэг юм. Тэдгээр авьяас билигтний зохиосон дуу хөгжим үндэсний уламжлалт хэлбэр зохиомж, ард олны эрх ашигт нийцсэн, уран сайхны шилдэг чанараараа онцлог юм.

Монгол ардын дуу хөгжмийн арвин баялаг санг дараах байдлаар тоймлон үзэж болно.



Д

- Иsgэрээтэй холбоотой монголчуудын өвөрмөц зан заншлыг дараах байдлаар сонирхон судлаарай.

 1. Монголчууд хэзээ хэдийд хаана ямар зорилгоор исгэрдэг вэ?
 2. Ямар үед исгэрэхийг цээрлэдэг вэ? Яагаад?

1.1. ӨГҮҮЛЭХ ЭРХТЭНТЭЙ ШҮТЭЛЦЭХ УРЛАГ

Монгол ардын хөгжмийн өгүүлэх эрхтэнтэй шүтэлцэх урлагт исгэрээ, амаар таших дэлдэх, хөөмий, цуур, аман хуур зэргийг хамруулдаг. Хүний өгүүлэх эрхтэн хөгжмийн эгшигийг дуурьсгах, хөгжмийн зэмсгийн үүрэг гүйцэтгэдэг.

Хөгжмийн зэмсэг үүссэн нь хүн байгаль орчинтой ухамсартай харьцааж эхэлсний үр дүн бөгөөд тухайлбал хүн байгалийн гоо сайхныг ухаарсны илрэл юм. Ямар ч гэсэн хүн байгалийн элдэв дуу чимээг бишрэн гайхсаны улмаас даган дуурайсан нь хөгжим үүсэх нөхцөл шалтгаан болсон. Байгалийн сонин сайхан дуу авиааг үүсгэхдээ мод, чулуу, хулс, зэгс мэтийг хөгжмийн зэмсэг болгон ашиглаж чулуун хуудас, дуут бүрээ, яс, эврээр хийсэн цуур бишгүүр, аман хил зэргийг үйлдэж байжээ.



ИСГЭРЭЭ

Исгэрэх гэдэг бол ямар нэгэн аяыг шүдний завсраар үлээн, хоёр уруулаараа хааж, нээн, шовшрон эгшиглэх юмуу эсвэл уруулын завсраар үлээн эгшиглэхийн нэр. Үүнд хүний шүд, уруул, ая эгшиг үүсгэх хөгжмийн зэмсгийн үүрэг гүйцэтгэж, амны хөндий цуурайн хайрцаг буюу чавхдаст хөгжмийн зэмсээр бол царын үүрэг гүйцэтгэдэг байна. Монголчууд исгэрээг шүдний, уруулын, тагнайн исгэрээ гэж гурав ангилдаг.



Исгэрээч Б.Папизан



“Хөөмий бол өгүүлэх эрхтэнтэй шүтэлцэх урлаг”
Ж.Бадраа

ХӨӨМИЙ

Хүн төрөлхтний соёлын түүхэнд монголчуудын оруулсан томоохон хувь нэмэр бол хөөмий. Тиймээс ч 2010 онд хөөмийг ЮНЕСКО дэлхийн биет бус соёлын өвд бүртгэн авсан юм.

Хөөмий нь хөгжмийн зэмсэг үл хэрэглэн уруул, тагнай, хамар, багалзуур хоолой гэх өгүүлэх эрхтнүүдээр гайхамшигт авиа, дуугаралтыг бий болгож, олон эгшгийн давхцал бүхий аялгууг гаргах давтагдашгүй төрөл билээ. Хөөмийлөх гэдэг бол хэлнийхээ үзүүр, үүдэн шүдээр гоё нугалаа чимэгтэй ая исгэрэхийн сацуу үргэлжлэн хүнгэнэсэн дэвсгэр эгшиг давхар дуугаргахын нэр юм. Хүнгэнэсэн бүдүүн эгшиг нь нарийн эгшиглэх аятайгаа нийцэн зохирч байдаг. Хөөмийг дуугарч байгаа байдлаар нь исгэрээ, хархираа, шахаа гэж төрөлжүүлж болно.

Монголчуудын байгальтайгаа харьцах харилцаа, амьдрал ахуй, зан үйлтэй холбоотойгоор үүсч, уриа дуудлагын нэгэн авиа, ая аялгуу маягаар хэрэглэгдэж байгаад яваандаа цуур хөгжим, магтаал, туульд хослон хэрэглэгдсээр иржээ. Хөөмий нь ардын аман зохиол, домогт өгүүлэгдэж, туульс хайлах ая аялгуунд хамран оролцож, бөөгийн болон шарын шашны зан үйлтэй ч холбоотойгоор эдүгээ хүрч ирсэн нэн өвөрмөц урлаг юм.



Хөөмийг Монголын баруун хэсэгт үүссэн гэж үздэг. Эзвэн голын хүрхрээний сонин сайхан чимээг дуурайн хөөмий үүссэн гэдэг домог ч бий. Өндөр уулс, хадан хавцлын завсраар үлээх салхи, усны харгия, боргио, бугын урам, шувуудын жиргээ, моддын чимээ зэрэг байгалийн элдэв дуу чимээ бол байгаль дах хөөмий. Тийм ч учраас хөөмий бол хүн байгалийн шүтэлцээнд оршдог.



Монгол ардын дуу ДӨРВӨН УУЛ

Монголын авьяаслаг хөөмийчид дэлхийн олон улс оронд хөөмийн урлагийг сонгодог хэмээн үнэлэгдэх хэмжээнд хүртэл эгшиглүүлэн дуурьсгаж байна. Хөөмийчдийн урын санд уртын дуу, ардын дуу зонхилох байр суурийг эзэлдэг. Монгол ардын дуунуудын үг нь ижил боловч аялгууны хэд хэдэн хувилбартай байх нь элбэг. Ийм жишээг “Дөрвөн уул” монгол ардын дууг хөөмийлснөөс сонсож болно.





- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Хөөмийн ямар төрлүүдийг олж сонссоноо тодорхойлоорой.
- Хөөмийч С.Загд-Очир “Дөрвөн уул” дууг аялгууны хэдэн хувилбараар хөөмийлсөн байна вэ?
- Хувилбуудын ноотыг ажиглаад хөөмийн дараах төрлөөр аль хувилбарыг эгшиглүүлснийг тодорхойлоорой.
- Хувилбар 2-ыг ноотоор дуулаарай.

A
Иsgэрээ

+

B
Хархираа, шахаа

+

C
Иsgэрээ, хархираа

+

A1
Иsgэрээ

Хувилбар 1

Дунд зэрэг

Дэр - вөн _____
уу - лын _____
маань ээ _____

5
Дун - даас _____
бол _____
бол - доо _____
хө _____
най _____

Хувилбар 2

Удаан

Дэр - вөн
уу - лын
дун - даа -
саа

5
Ус - ны
тунга - лаг
урс - наа
хө

Хувилбар 3

Дунд зэрэг

Дэр - вөн
уу - лын
маань
дун - даас _____
бол - бол _____

5
Ус - ны
маань
тун - га - лаг
ур - саад
байна
даа
хө



Ц.Нацагдорж
ХӨӨМИЙ, МОРИН ХУУР, СИМФОНИ НАЙРАЛ
ХӨГЖМИЙН КОНЦЕРТ



Төрийн соёрхолт, хөгжмийн зохиолч Ц.Нацагдорж “Хөөмий, морин хуур, симфони найрал хөгжмийн концерт”-оо 2007 онд түүрвижээ. Энэ бүтээлд Монгол түүргатны өвөрмөц нэгэн урлаг болох хөөмийг морин хууртай хослуулан, хөгжимчин нь өөрөө хөөмийлөхөөр зохиосон нь сонирхолтой шийдэл болсон.

Хөөмий, морин хуурт зориулсан уг зохиол түүрльсүн хүүрнэн өгүүлсэн шинжтэй, удаан, хурдан, удаан гэсэн хоорондоо ялгарамж бүхий гурван хэсэгт хэлбэртэй ажээ.

Adagietto
Удаан
A

+

Andante espressivo
Хурдан
B

+

Удаан
A1

Зохиолын эхлэл, төгсгөл хэсгүүдийн аялгууны шинж байдал нь уртын дууны өнгө аястай, зөвлөн, ямар нэг зүйлийг дурсан санагалзах мэт сэтгэгдэл төрүүлнэ. Энэ хэсгийг морин хуур ба хөөмий ээлжлэн эгшиглүүлдэг.

Дунд хэсэг нь хурдан бөгөөд морин хуурын татлага, хөөмий ээлжлэн дуурьсана. Энэ хэсэгт морин хуурын хөгжимдэх чадал боломжийг чөлөөтэй илэрхийлнэ. Хөөмий ч өөрийн өнгө, техникийг харуулан хосолдог. Тухайн хэсэгт хөөмийн янз бүрийн төрлүүдийг оруулсан нь хөөмийч – хөгжимчнөөс өндөр ур чадвар шаарддаг байна.





- Зохиолоо сонсоорой.
- Зураглалыг ажиглан хөгжмөөс төрсөн сэтгэгдлээ дүрслэн бичээрэй.
- Зохиолын төгсгөл хэсгийг чи хэрхэн зураглах вэ?

A



B



A1

?

1.2. ХӨГЖИМТ АМАН ЗОХИОЛЫН ТӨРӨЛ

Хөгжмийн урлаг монголчуудын аж байдалтай нарийн уялдаатай, ахуй амьдралд гүнзгий нэвтэрсэн байдаг. Хөгжимт аман зохиолын төрөлд энгийн бүтэцтэй аялга дуудлагаас эхлээд нарийн бүтэц хэмнэлтэй цол дуудлага хүртэл олон зүйлийн ая аялгуу багтана. Жишээ нь: малын уриа ая, аялгут оньсого, дэмбээ, ерөөл, магтаал, тууль, хурдан морь, хүчит бөхийн цол гэх мэт.



- Малын уриа аяыг ноотоор сурч дуулаарай.

Хургатай хонь

7

Хур-га-тай хонь нь Хур - гаа да-гуулд-гийм хон-гор шар_

ур_ гаа хө-хүүлд-гийм тойг_____ тойг_____ тойг_____ тойг_____



ЕРӨӨЛ, МАГТААЛ

Ерөөл, магтаал, улгэр туульсын ая
монголчуудын ёс төр, аж байдлын бас
нэгэн салшгүй хэсэг бөгөөд тус бүрдээ
ялгарах онцлогтой.

Ерөөл гэдэг бол сайн учир тохиолын бэлэг зохиож, сайхан үг хэлэх ёс төрийн нэр юм.

Магтаал аяыг дан хоолойгоор аялах бөгөөд голдуу хуур, хуучир зэрэг хөгжмийн зэмсэгтэй хамсардаг онцлогтой. Магтаал нь ерөөлтэй төстэй ч, аялгууны шинж төрх хөгжмийн зэмсгийн хамсраатайгаараа ялгаатай, уран сайхны давуу чанартай.



Ерөөлч, магтаалч Ж.Мөнхбат

Туульс магтаал гэдэг домгийн сэдэвтэй, найраглал мэт урт, тухайлсан өгүүлэлмж дүртэй. Жишээлбэл: “Хөхөө Намжил” буюу морин хуурын домгийн сэдэвтэй “Жонон хар”, говь нутгийн алдар цуутай атан тэмээний сэдэвтэй “Уйлган шар”, “Яриг цагаан ингэний Сариг цагаан ботго” гэх мэт сайн морь, тэмээ, зоригт сайн эрийн түүх домгийг өгүүлсэн байdag.

Хүндэтгэл магтаал бол монгол орны үзэсгэлэнт уулсын тухай өвөрмөц дуулал юм. Утга агуулгаараа эх орны үзэсгэлэнт байгаль, ан гөрөөс, араатан жигүүртэн, ард олонд өмөг түшиг, өгөөж ханамж хайлрадгийг магтан дуулсан байдаг. Жишээ нь: “Алтай ханы магтаал”, “Хангай ханы магтаал”, “Авралтай баян хан хөхийн магтаал”, “Хөгнө ханы магтаал” гэх мэт.

Үг, ая. Ж.Мөнхбат

Цагаан сарын магтаал

Дунд зэрэг

6

Зам-буу тив-ийн на-ран дор заяа тэгш амга-лан ор-ших Жар - гал дэл-гэр сай-хан оронд миинь

9

13 Жа - ран жа - ран эр - гэ - сээр Хан хор-воо-гийн цээ-жин - дээ ха - маг оп-ноороо жар-ган бай-гаа

Эх дэлхийн амин судал
Эрдэнэт овоондоо тахил өргөж
Эрхэт төрийн алтан сүлдэнд
Идээнийхээ дээжийг өргөөд

Алаг мэлхий өрөн тоглож
Азын дөрвөн бэрх орхиж
Аялгуут сайхан хуураа татаж
Азай буурлуудаа хүндэлсэн ...





- Хөгжимт аман зохиолын төрлөөс аялгуулан хэлж сурцгаая.
- Ертөнцийн гурвыг аялгуулан хэлэхдээ асуух, хариулах маягаар харилцан дуулаарай.

Ертөнцийн гурав

Дунд зэрэг

6 Ээ - э - э Ээ - э - э ээ Ер-төн-ций-н гу-р-ва-н цэн-хэр-гэ-ж ю-у байд-гийг
хэл - ээд ёг - ёө - рэй Хо - лоос хараг - дах уул - с цэн - хэр

8 Хон-хорт тогт-сон ус нэг цэн-хэр Хор-воод бай-гаа тэн-гэр цэн-хэр - ээ

Хэл зүгшруулэх үг

Зургаан настай бурхи
Зурманд зүүсэн урхи
Зуун модны горхи
Зүүн чихний гархи

Сольж барьсан гэр
Сорьж тавьсан үр
Шилж олсон шүр
Ширж оёсон ширдэг

Бэлгэ дэмбэрлийн үг

Бууршгүй буянтай
Сааршгүй сантай
Санасан хамаг хэрэг чинь
Санаагаараа бүтэх болтугай

Өнтэй газар өвөлжиж
Өнгөлөг газар зусч
Навчит газар намаржиж
Насан буян хураагаарай

Зүйр үг

Ган болоход булгийн сайн мэдэгдэх
Гай болоход нөхрийн сайн мэдэгдэх

Найрны богино нь сайн
Насны урт нь сайн

Удмаараа алдаршдаггүй
Ухаанаараа алдаршдаг

Үг давтвал улиг
Ном давтвал билиг

Даахинь ерөөлөөс

Амь нас нь уул мэт бөх
Алсын бодол нь тэнгэр мэт уужим
Ахуй сэтгэл нь сүү мэт цагаан
Арвин мэдлэг нь далай мэт гүн
Аавдаа ачлалтай ээждээ энэрэлтэй
Ард олондоо нэр нь түгсэн
Ачтай сайн хүү болоорой




1.3. МОНГОЛ АРДЫН ДУУЛАХ УРЛАГ

Монгол ардын дууны урлаг бол нүүдэлч монголчуудын аж амьдралтай салшгүй холбоотой. Ардын дуу нь хүнээс хүнд ам дамжин дуулагдахаа улам хөгжин боловсорсоор хамтын бүтээл болдгоороо онцлогтой. Монгол ардын дууг аялгууны цараа багтаамжаар нь утга санаа, үүрэг зориулалтаар нь ангилдаг.



- Бүдүүвч зураглалыг ажиглаад, сэдвийн агуулгыг ярилцаарай.



МОНГОЛ УРТЫН ДУУ

2008 онд ЮНЕСКО-гоос Монгол үндэстний гайхамшигт урлаг “Монгол уртын дуу”-г хүн төрөлхтний биет бус соёлын өвд бүртгэж ирээдүй хойч үеийн тусын тулд хадгалж, хөгжүүлж, өвлүүлж байх шаардлагатайг тунхаглан зарласан билээ. Монголчууд ийнхүү хосгүй сайхан өв соёлоороо бахархан баходахын хамт түүнийг хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжилж байх эрхэм үүргийг дэлхий дахинь өмнө хүлээсэн юм.

Уртын дуу бол монгол ардын дууны сонгодог хэлбэр.

Монгол уртын дуу	Баялаг хэмнэлтэй	<p>Хэр-лэн - - ГЭ-НЭЭ -</p>
	Өргөн цараатай	<p>“Хэрлэнгийн барья” Бага октаавын фа-II октаавын си bemоль</p>
	Аялгууны үсрэлт ихтэй	<p>“Өвгөн шувуу” бага аравт буюу арван өрөг үсэрдэг</p> <p>aa - хийээ - хий аань</p>
	Хөг шилжилт элбэг	<p>“Цэвцгэр хурдан шарга”</p> <p>Adur - Fis dur</p>


Уртын дууг дуулахад дуучнаас хоолойн их цараа, дотоод их уран сэтгэмж, дуулах ур чадвар шаардагддаг. Алдарт дуучид уртын дууны аялгуунд өөр өөрсдийнхөө ур чадлыг шингээн дуулдаг. Тиймээс уртын дуу нутаг нутгийн олон хувилбар аятай байдаг. Ийнхүү уртын дууны тусгай дэг сургууль тогтоосноор зүүн аймгийн аялгуу, баруун аймгийн аялгуу, боржигон аялгуу, баян бараатын аялгуу гэж ангилдаг болжээ.



Н.Нороөбанзад
(1931-2002)

ХХ зууны манлай уртын дуучин, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн соёрхолт Намжилын Норовбанзад бол уртын дууны агуу мастер, байгалиас зяасан их авьяас билигт дуучин билээ. Тэрээр Монгол уртын дууны гайхамшигийг дэлхийд таниулж, хүн төрөлхтний биет бус соёлын өвд бүртгүүлэхэд их хувь нэмэр оруулсан юм. Н.Норовбанзад өөрийн дуулсан “Уяхан замбуу тивийн наран”, “Сэргүүн сайхан хангай”, “Өвгөн шувуу хоёр”, “Дуртмал сайхан”, “Цэвцгэр хурдан шарга” гээд олон дугаараа сонсогчдын зүрх сэтгэлд мөнхрөн үлдсэн. Тэрээр “Уяхан замбуу тивийн наран” дуугаар дуулахаар ер бусын гайхамшигт өртөнцөд нисэн хүрэх мэт болж, үлэмж жаргал өдэлдэг” хэмээн дурссан байдал.





Монгол уртын дуу бол:

- Сэтгэлгээний хувьд гүн гүнзгийн утга агуулгатай, ухаарал бодрол шингэсэн.
- Аялгууны хувьд төв эрхэмсэг намба төрхтэй, цараа өргөн, хаялга цацлага, нугалаа, шуранхай агуулсан, аялгууны чимэглэл ихтэй.
- Дуулах ур чадварын хувьд хоолойн өргөн цараа, амьсгааны уужим баатгаамж, дуулах нарийн техник мөн ур ухаан, мэдрэмж, сэтгэлгээ шаарддаг.

Д

- Монгол уртын дуу сэдвээр мэдээлэл цуглуулж, дараах асуултад хариулаарай. Ж.Бадраа “Монгол ардын хөгжим”, Д.Дашдорж С.Цоодол “Ардын дуу хөгжмийн суу билигтнүүд”, Б.Содном “Монгол дууны түүхээс” ном, мэдээллийн бусад хэрэгслийг ашиглаарай.
- Л.Оюунчимэг “Ардын сайхан дуунууд” номноос “Уяхан замбуу тивийн наран”, “Өвгөн шувуу хоёр”, “Эрдэнэ засгийн унага” зэрэг дууг сонгон ноот бичлэгийг ажиглаад хэмнэл, цараа, аялгууны үсрэлтийг тодорхойлж уртын дууны гайхамшигийг олж батлаарай.

К- мэднэ	W- мэдэхийг хүснэ	L- мэдлээ
<ul style="list-style-type: none"> - Ардын дуу - Уртаар дуулдаг - Морин хууртай хамсардаг. - ЮНЕСКО-д бүртгэгдсэн. - Алдарт уртын дуучин Н.Норовбанзад, Ш.Чимэдцээ 	<ul style="list-style-type: none"> - Яагаад уртаар дуулдаг вэ? - Өөр хөгжмийн зэмсэгтэй хамсарч болох уу? - Бусад улс үндэстний уртын дуунаас ямар ялгаатай вэ? - ЮНЕСКО-д юуны учир бүртгэгдсэн бэ? - Бусад дуунаас чухам юугаараа гайхалтай вэ? - Уртын дуу дуулахад ямар нэг дэг жаяг бий юу? - Үсэл гарал нь чухам юу вэ? 	





- Монгол ардын дуугаа өвлөн дуулцгаая.

ДӨРВӨН НАСТАЙ ХАЛИУН (Монгол ардын бэсрэг уртын дуу)

Удаан

Дөр - вен______ нас - тай______ ха - лиун______ нь
Дөр-вөлж-лөөд______ ха-раг - дах______ ба - раа______ нь

Де - рее______ жий - хэд______ ер - гее______ - тэй______ шүү
Де-төл - сен______ ам - ра - гийн______ ба - раа______ юу

Дөрвөн настай халиун нь
Дөрөөг жийхэд өргөөтэй шүү
Дөрвөлжлөөд харагдах бараа нь
Дөтөлсөн амрагийн бараа юу

Таваар тавьсан гэзэг нь
Таанын бутуул шиг саглайж байна
Тавалжаад харагдах бараа нь
Танилцсан амрагийн бараа юу



- Дээрх ноот бичлэгийг ажиглаад, хоёр хэсэг болж хэмнэлийн дасгал хийгээрэй. “Дөрвөн настай халиун” дуунд хэмнэлийн хамсраа хийж дуулъя.

- Дараах үгсийг монгол хэлний тайлбар толиос харж утгыг тайлна уу.

Ергөөтэй Дөтөлсөн амраг Таваар тавьсан гэзэг Тавалжаад харагдах Таанын бутуул	?
---	---

?





Ярилцлага

Монгол хүн бүр ардын дуугаараа бахархах учиртай. Монгол ардын дуу хөгжим нь давтагдашгүй уран тансаг аялгуу, утга төгөлдөр яруу хэллэгтэй. Тиймээс дараах чиглэлээр ярилцъя.



- Чи монгол ардын дуу хэдийг мэдэх вэ? Хэдийг дуулж чадах вэ?
- Танайд монгол ардын дуу хөгжмийн бүтээлийг сонсох урын сан бий юу? Хэр зэрэг үзэж, сонсож ашигладаг вэ?
- Монгол үндэснийхээ дуу хөгжмийг сурч судлах, түгээн дэлгэрүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж бодож байна вэ?
- Өөрийнхөө сайн мэддэг, дуулж чаддаг монгол ардын дууг хамт олондоо дуулж үзүүлээрэй.



Бөмбөр бөмбөр модондоо
Бүргэд шувуу нь бөөрнө дөө
Саглагар саглагар модондоо
Шаазгай шувуу шагшина даа

- Дээрх дууны шүлгийн утгыг тодруулна уу?
- Эхийн элбэрэл хайрыг хөгжмөөр дүрсэлбэл аялгууны шинж төрх, өнгө аяс, хурд, эгшиглэх хүчний сонголт нь ямар байхыг төсөөлж ярилцаарай. Хөгжмийн ямар зэмсгийг сонгон хөгжимдвэл тохиромжтой вэ?

Сэдэв	Аялгууны шинж төрх	Хурд	Хүч	Хөгжмийн зэмсэг
Эхийн хайр	?	?	?	?

- “Эхийн ач” дууг хурдан, чанга хүчдэлээр дуулбал дууны утга агуулгад хэрхэн нөлөөлөх вэ? Яагаад?
- Дууг дуулахад амьсгаа чухал гэдэг. Энэ нь дууны уран сайхны дүр дүрслэлд нөлөөлөх үү?
- Дууг дуулахад амьсгааны хувьд ямар алдаа гаргадаг гэж бодож байна вэ?
- Дууг илүү сайхан, сонголонтой болгохын тулд юу анхаарч дуулах хэрэгтэй вэ?



Хотгойдын бэсрэг уртын дуу

ТОСОНГИЙН ОРОЙ

*“Тосонгийн оройгоор тоосроод байна
Тогтож суухыг болилоо доо
Мандлын оройгоор манаадад байна
Манай нутаг санагдаад байна
Сэрвэнгийн оройгоор сэрвэлзээд байна
Сэтгэл санаа үймрээд байна”*

Энэхүү дуунд хүний сэтгэлийн хүүрнэлийг өгүүлжээ. Өсч төрсөн нутаг орон, аав ээж элгэн саднаа санан гэгэлзсэн хүний сэтгэлийн гунихрал, тэмүүллийг тоосорсон манан, сэнсэрсэн салхитай зүйрлэн харуулжээ.

Доктор Л.Хүрэлбаатар дууны утга санаа, түүхийн талаар “Анх Жалханз хутагтын шавь, албат болж ирсэн хэсэг айл, нутаг орноо санахын эрхэнд тэр нутгийн манарч, тоосорч, сэрвэлзсэн Мандал, Тосон, Сэрвэнгийн уулсыг харж, уг дууг зохиож дуулсан гэдэг” хэмээжээ.

Ардын урлаг судлаач Ж.Бадраа “Хотгойд дууны ая нь бэсрэг уртын дууны шинжтэй, уртавтар богино хэмнэлтэй, гэгэлгэндүү хөг аялгатай, уянгалаг төр нь уул хадыг цуурайтуулан дуулах гэсэн зорилготой болов уу?” хэмээн дүгнэсэн байдаг. Хотгойд дуу нь хүн байгалийн харилцан шүтэлцээг бэлгэдэх, зүйрлэх байдлаар харуулдаг. Ардын дууны аялгуу айзамд газар орон, уул усны тогтоц шууд нөлөөлдөг байна.



- “Тосонгийн орой” дууны сэдэв аялгууг дээрх зураглалтай харьцуулан сонсоорой.

Adagio



ТОСОНГИЙН ОРОЙ

“Тосонгийн орой” бэсрэг уртын дууг хөгжмийн зохиолчид уран бүтээлдээ авч ашигласан байдаг. Жишээ нь:

Олон улс үндэстний ардын дууг авч бүтээл хийдэг “Энигма” хамтлаг “Age of Loneliness” (Ганцаардлын нас) дуундаа “Тосонгийн орой” бэсрэг уртын дууг new age, world music хэв маягаар найруулж Монгол хөгжмийг дэлхийд таниулахад хувь нэмрээ оруулсан юм. Мөн хөгжмийн зохиолч Х.Алтангэрэлийн уран бүтээлд ч тусгалаа олсон байдаг.

Ad libitum

Музыкальная нотация в Г-диатонике, 3/4拍. Текст: То - сон гий нээ _____ о - рой-гоор _____ тоос - роод _____ Тог - то - жээ _____ суу - хaa _____ боли - лоо _____

Хөгжмийн зохиолч Х.Алтангэрэл энэхүү зохиолоо уран сэтгэмжийн төрлөөр 2008 онд “Хөсөгтөн” хамтлагийн морин хуурч, хөөмийч О.Чулуунбаатарт зориулж бичжээ. “Тосонгийн орой” нь ижил нэрт ардын дуунаас сэдэвлэн бичигдсэн бөгөөд энэ дууг хотгойд, дархад дууны нэрт мастер Д.Надмид дуулсан байдаг.



- Хөгжмөө сонсоорой.
- Зохиол ялгарамжит хэдэн хэсэгтэй байна вэ?
- Хөгжмийн зохиолч уран сэтгэмждээ ардын хөгжмийн ямар төрлүүдийг гоцлохоор бичсэн бэ?
- Чиний бодлоор энэ ноот бичлэг юу илэрхийлж байна вэ?



Д

- Доорх хүснэгтийг нөхөөрэй.

	Хэсэг 1	Хэсэг 2	Төгсгөл
Хурд			
Хүчдэл			
Хөгжмийн төрөл			

New age – нью эйдж - шинэ эрин. Хөнгөн дуугаралттай, цахилгаан хөгжим болон угсаатны хөгжмийн зэмсэг, арга барилыг хослуулсан, удаавтар, гэгээлэг, өөдрөг аялгууг голчилдог хөгжмийн төрөл.

World music – дэлхийн хөгжим. Уламжлалт ардын хөгжим, Европын бус уламжлалт сонгодог хөгжмийн хөг эгшиглэгээ, зэмсэг, хөгжимдэх, дуулах арга барилыг ашиглан бүтээн туурвидаг орчин цагийн “барууны” хөгжмийн хэв маяг.




1.4. МОНГОЛ АРДЫН ХӨГЖИМДӨХ УРЛАГ

Монголчуудын байгаль, эх дэлхийгээ шүтэн бишрэх, ан амьтан, таван хошуу мал сүргээрээ бахархах сэтгэлгээний илрэл нь дан хөгжмийн бүтээлийн үндэс болдог. Үүний тод жишээ нь янз бүрийн хөгжмийн зэмсэгт зориулсан төрөл бүрийн ая, татлага, мөн хөөмий, исгэрээ юм. Эдгээр нь байгалийн дуу чимээ таван хошуу малын явдал хөдөлгөөнийг зонхилон дүрслэлсэн байдаг. Ийм бүтээл нь голдуу ямар нэгэн домог, түүхтэй холбоотой байх ба хөгжмийн бүтээл үүсэн бий болох үндсэн шалтгаан болж, бүтээн туурвих сэтгэлгээг төрүүлдэг байна.

Монгол ардын дан хөгжмийн бүтээлийн бас нэгэн онцлог нь шууд зохиомжлох авьяасыг хөгжүүлдэгт оршдог. Дан хөгжмийн бүтээл нь хөгжмийн зэмсгийн үүсэл, хөгжил, үлгэрч, туульч, хөгжимчидтэй салшгүй холбоотой.

Дан хөгжмийн уран бүтээлд хуурын ая татлага чухал байр суурьтай. Жишээлбэл “Жороо морины явдал”, “Балчин хээрийн явдал”, “Жонон харын явдал”, “Ингэн тэшээ”, “Буйлган шарын явдал”, “Хур шувуу”, “Нуурын галуу”, елхэндэг, бий биелгээний татлагууд гэх мэт. Эдгээр нэр нь тухайн бүтээлийн агуулга дүрслэлийг илэрхийлдэг.

Зарим татлага аязууд илүү хөгжингүй, тодорхой үйл явдал, түүхийг өгүүлсэн байдаг. Тухайлбал “Дөрвөн ойрдын уриа”, “Ээвэн голын урсгал”, “Өрөөлтэй шарга морь” гэх мэт. Татлага аязууд газар нутаг, ястан үндэстний зан заншил, хэл ярианы онцлогоос хамааран нутаг нутагт өөр өөр хэлбэрээр хөгжсөн байдаг. Тухайлбал баруун монголчуудын дунд “бийт татлага” буюу голдуу бий биелгээтэй хамсран хөгжимддөг бол төв халхчуудын дунд бүжиггүйгээр дан хөгжмийн бүтээл болж хөгжсөн байдаг.



-  - Дараах бүтээлүүдийн нэрийг уншаарай. Ардын дан хөгжмийн бүтээлийн үндэс нь юу вэ? “Жороо морины явдал”, “Балчин хээрийн явдал”, “Ингэн тэшээ”, “Буйлган шарын явдал”, “Хур шувуу”, “Нуурын галуу”. Ардын дан хөгжмийн бүтээлийн сэдэв агуулга нь юу вэ?
-  - “Шууд зохиомжлох арга ухааныг хөгжүүлдэг” гэдгийг юу гэж ойлгож байна вэ? Энэ санааг тодотгох асуулт зохиогоорой.
- Дан хөгжмийн бүтээл нь байгаль орчин, ан амьтан, мал сүрэг, ахуй зан заншилаа хөгжмийн хэлээр дүрслэн илэрхийлэхээс өөр ямар үүрэгтэй вэ?



МОНГОЛ АРДЫН ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ

Монголчууд эрт үеэс олон янзын хөгжмийн зэмсэг хэрэглэж ирсэн. Монгол ардын хөгжмийн зэмсгийг дуу авиа эгшиглүүлэх арга барилаар нь дараах байдлаар ангилдаг.



ЧАВХДАСТ НУМТ ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ

Морин хуур: Морин хуур бол монголчуудын хүндэтгэж хайлрадаг хөгжмийн зэмсэг билээ. Тэгээд ч айл болгон морин хууртай байхыг чухалчилж, хуураа хоймортоо залдаг. Морин хуур гэдэг нь морины толгойтой хуур гэсэн утгатай. Морин хуурын цар гонзгой дөрвөлжин, ямааны юм уу, ботгоны арьсаар бүрж, ногоон будгаар буддаг байжээ. Ногоон өнгийг газар дэлхий, үржил шим, хайр сэтгэлийн бэлгэ тэмдэг гэж үздэг.

Морин хуур нь толгой, чих, иш, их бие, нум зэргээс бүтдэг. Чавхдастыг нь эр бяртай сайн морины сүүлний сод хэмээх урт хялгасыг сунган боловсруулж хийдэг.



Хөг

Морин хуур дөрөвц хөгтэй.

Цараа

Морин хуурт зориулсан олон сайхан аялгуу байдаг. Халх монголд голдуу “Жонон харын явдал”, “Жороо морин явдал”, “Могой хээр”, “Доголон цагаан”, “Харцага зээрд” гэх мэт сайн морин явдлын хэмнэлтэй татлага аялгуу, “Цацал”, “Мөргөл”, “Елхэндэг”, “Саальчин”, “Гэр бүл” зэрэг бий биелгээний татлагууд байдаг. Морин хуур нь уртын дуунд хамсраа хийх гол хөгжмийн зэмсэг мөн.





Хөгжимчин, удирдаач, багш. Тэрээр “Зүн цаг”, “Шувуухайн байшин”, “Жигмэд Тогмид хоёр” хүүхдийн дуу, “Аз жаргалын эрэлчин” хүүхдийн анхны дуурь, “Эх орны өглөө” симфони чуулбар, “Борхийн цуурай” симфони найраглал, “Цэцэг нуурын хөвөө” морин хуурын дөрвөл, “Үүлэн борын хурдаар” зэрэг цөөхүүл дан хөгжмийн олон бүтээл туурвисны дээр ардын хөгжмийн сургалтад үнэтэй хувь нэмэр оруулсан.

Цэндийн Сүхбаатар
(1930 - 1984)




- Хөгжмөө сонсоод, хурдны өөрчлөлтийг тодорхойлоорой.
- Зохиол хэдэн хэсгээс бүтэж байна вэ?
- Зохиолын хэсгүүд өөр хоорондоо ямар ялгаатай вэ? Адил хэсгүүд байна уу?
- Үсгээр, дүрсээр эсвэл тэмдэглэгээний ямар нэг аргаар зохиолын бүтцийг томьёолно уу?
- Зохиолын эхний хэсгийн хэмнэлээс ямар дүр дүрслэлийг мэдэрч байна вэ?
- Эхний хэсгийн хэмнэл ардын хөгжмийн хөгжимдөх арга барилтай ямар нэг байдааар холбоотой юу?
- Хоёр дахь хэсгийн аялгууны шинж төрхийг тодорхойлоорой. Эхний хэсгээс ямар ялгаатай байна вэ?

ҮҮЛЭН БОР

Ц.Сүхбаатар

Хөгжмийн зохиолч Ц.Сүхбаатар морин хуурт зориулан “Үүлэн бор”, “Боролдойн дуу”, “Адуучны дуу” зэрэг гоцлол бүтээлүүдийг туурвижээ. Ялангуяа “Үүлэн бор” бүтээл нь монгол түмний бахархал, омогшлыг төрүүлсээр дэлхийн тайзнаа цуурыйтсан төдийгүй морин хуураа дагалдан ЮНЕСКО-ийн соёлын өвд бүртгэгдсэн байна. Хөгжмийн зохиолч “Үүлэн бор” бүтээлээ өөрийн хатирч, бор зүсмийн хурдан мориныхоо дурсгалд зориулж 1962 онд туурвижээ. Энэ бүтээл монголын ард түмний дунд ардын дуу мэт түгэн морин хуураар хөгжимддөг хэн бүхний урын санд багтаж, морин хуурчдын ур чадварыг сорьсон шилдэг бүтээл болсон юм.



Тэгш хэмнэл,
тэмүүлэл,
татлага, хурдан
морины явдал



Тэгш хэмнэл,
тэмүүлэл,
татлага, хурдан
морины явдал



А хэсэг

Allegretto



3



В хэсэг

Moderato



5



Хуучир: Эрт дээр үеэс монголчуудын хэрэглэсээр ирсэн чавхдаст, нумт хөгжмийн зэмсгийн нэг нь хуучир юм. Хуучир олон янзын нэртэй. Төв халхад хуур хийл гэж байгаад хожуу үеэс хуучир гэх болсон. Хуучир 2 ба 4 чавхдастай, нарийн дээд өнгө, уянгалаг намуун дутай.



Монгол хуучир угалзтай, зургаан талтай, модон бортоготой, дөрвөн чихтэй, морин толгойтой, тавцын хөгтэй байлаа. Тийм хуучир одоо Архангай аймгийн орон нутгийн музейд байдаг. Хосоор хөглөсөн дөрвөн чавхдастай хуучир зөвлөн өнгөтэй, ардын дуу магтаал зэрэгт нийцтэй байдаг. Монголын нэрт хуурч Д.Түдэв, С.Түвдэн, н.Баяр, П.Буян, Б.Цэдэн, н.Дамбийжанцан нар хуучраар ч гаргуун сайн хөгжимддөг байлаа. Хуучрыг морин хуур, шударга, ёочин, лимбэтэй хамсарч хөгжимдөх нь элбэг.




ЧАВХДАСТ ЦОХИВОР ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ

Ёочин: Чавхдаст цохивор хөгжмийн зэмсэг бол ёочин юм. Цохиур нь хоёр хулсан савх байдаг. Ёочин бол уйгараар дамжуулан дундад азиас авсан хөгжмийн зэмсэг билээ. Монголоор янчир гэдэг. Манай ардын хөгжимд янчирыг гоцлол, чуулга, лимбэ, хөөмийн хамсраа, найрал хөгжмийн бүрэлдэхүүнд оруулж хэрэглэдэг. Ёочин бол тод, хүчтэй цангинасан, цуурайтсан дуутай.




Цараа



Шударга: Шударга нь чавхдаст товшвор хөгжмийн зэмсгийн нэг бөгөөд маш эртний уламжлалтай юм. Товшвор гэдэг нь товших буюу нум хэрэглэхгүй чавхдахын нэрээр үүссэн үг.

Монгол шударга тэг дугуй цартай, хээ угалзтай байдаг. Царыг нь ямааны арьс, ботгоны татаасаар ширлэдэг байлаа. Монголчууд шударга, их гарын шударга, бага гарын шударга гэж том жижгээр нь ялган урлаж хэрэглэдэг уламжлалтай. Монголын шударгачид шударгыг таван өөр хөгөөр хөглөж, таван зүйлийн цохилтоор цохиж хөгжимддэг. Шударга нь тунгалаг яруу дуутай, цэвэр тод эгшиглэнтэй.



Ятга: Эрт дээр үеэс монголчууд “Төрийн ятга”, “Ахуй их ятга”, “Босоо ятга”, “Ятга”, “Ятгалиг”, “Зэн”, “Дэлслэгт” гэх зэрэг олон зүйлийн ятга хэрэглэсээр иржээ. Төрийн ятга нь нэг, хоёр, гурав, тав, долоо, есөн чавхдастай байсан. Одоогийн бидний хэрэглэж буй жирийн ятга бол арван гурван чавхдастай, чавхдасыг нь тэвхээр тулж, тэвхий нь гүйлгэн хөгий нь тааруулдаг, хуруугаар чимхэх буюу этэн товшиж эгшиглүүлдэг хөгжмийн зэмсэг юм. Ятга нь уянгалаг зөвлөн өнгө эгшигтэй.



Цараа





Бямбасүрэнгийн Шарав

Төрийн соёрхолт, УГЗ, хөгжмийн зохиолч. “Чингис хаан” дуурь, 2 симфони, морин хуурын концерт, “Сэргүүн намар”, “Зуурдын орон”, “Ононд хатаагдсан илд”, “Алтан ураг” бүжгэн жүжиг, “Хэрлэнгийн домог”, “Улэмжийн өртөнц”, “Сэргсэн тал”, “Баярын уянга”, “Сэтгэлийн эгшиг” гэх мэт дан хөгжмийн бүтээлүүд, “Багш та”, “Сургууль минь баяртай”, “Аав ээж хоёр” зэрэг алдартай дуунууд туувижээ.

Б.Шарав

ЯТГАД ЗОРИУЛСАН ВАРИАЦ

Хөгжмийн зохиолч Б.Шарав дан хөгжмийн төрлөөр нилээд уран бүтээл тутурувсан. Түүний уран бүтээлд гоцлол хөгжимд зориулсан, тэр дундаа ардын хөгжмийн зэмсэгт зориулсан 7 концерт байдаг. Тэрээр ятга хөгжимд зориулан 1984 онд “Санхью гөлөм” ардын дууны сэдэвт хувилбар аяз, 1998 онд “Ятга, симфони найрал хөгжмийн вариац концертино” бичсэн байна. Тэрээр ятгад зориулсан вариацаа “Бүсгүй хүний заяа”, “Ганган борлог” хэмээх монгол ардын дууг авч ашиглан гол сэдэв аялгуугаа бичжээ.




Оршил хэсэг




A



A1



B



B1



A2



B2

- Зургийг ажиглаад, зохиолын агуулгыг таамаглан ярилцаарай.
- Хөгжмөө анхааралтай сонсоорой. A, A1, B, B1, A2, B2 сэдэв аялгуу хэрхэн хувьсаж, өөрчлөгдөж байгааг сонсож ажиглаарай.
- Вариац буюу хувилбар аяз гэдгийг юу гэж ойлгосноо өөрийн үгээр илэрхийлж тайлбарлаарай.

023



ҮЛЭЭВЭР ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ

Монгол ардын хөгжмийн зэмсгүүдээс хамгийн эртнийх нь цуур, хулсан хуур, төмөр хуур гэж болно. Эдгээрийг эгшиглүүлэхэд амны хөндий, хэл, шүд зэрэг өгүүлэх эрхтэн маш чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Жишээ нь цуур бол үлээхийн зэрэгцээгээр давхар хөөмийлдөг онцлогтой.



Лимбэ: Их, дунд, бага гарын лимбэ гэж янз бүрийн хэмжээ цараатай лимбэ байдаг.

Цараа

Их лимбэ Дунд лимбэ Бага лимбэ

Лимбийг голдуу гоцлол юмуу хамсраагаар хэрэглэдэг. Чуулга, наирал хөгжимд хөг удирдах, дээд нарийн аялгуу эгшиглүүлэх чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол лимбэчид битүү амьсгаагаар тасралтгүй үлээх өвөрмөц арга барилыг эзэмшсэн. Амьсгааны энэхүү гайхамшигт арга барилыг хүн төрөлхтний соёлын өвд бүртгэсэн билээ. Лимбэ нь тунгалаг, уянгалаг, нарийн дуутай.



Эвэр бүрээ: Эвэр бүрээ бол эртний бялар гэдэг хөгжмийн зэмсгийг шинэтгэсэн үлээвэр хөгжмийн зэмсэг. Эгшиглэх цараа нь бага октавын ре - III октавын ре хүрдэг. Эвэр бүрээ нь өтгөн, баргил, зөвлөн дуутай.



Цараа



Д

- “Хан хөхийн уянга” зохиолыг сонсоод, бүтэц хэсгийг тодорхойлоорой.
- Зохиолын эхний 2 хэсгийг ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсөнийг тодорхойлно уу?
- Зэмсгүүдийн эгшиглэлт хоорондоо ямар ялгаатай байна вэ?
- Төгсгөлийн хэсэгт хөгжмийн зэмсэг солигдсон уу?
- Юу дүрсэлснийг зэмсгийн тембр, тоглолтын арга барилтай холбон тодорхойлоорой.




Ж.Мэнд-Амар

ХАН ХӨХИЙН УЯНГА

Энэ зохиол нь хүн, байгалийн харилцан шүтэлцээг уран сайхны дүрээр илэрхийлсэн, уул усаа магтан дуулсан монгол хүний сэтгэлийн дуулал болсон юм. Хөгжмийн зохиол гэдэг нь байгаль, эх дэлхийгээ хайлралах, түүний гоо үзэсгэлэн, сайхныг мэдрэх мэдрэмж, түүгээр баахархах сэтгэлийн илэрхийлэл болон төрдөг.

Зохиол төрсөн түүхээс: Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Л.Мөрдорж 1963 онд Увс аймгийн Зүүн хангайн нутгаар явж байхдаа “Ээвэн голын урсгал” хэмээх домог болон бугын урамдах дууг олж сонсон, улмаар одоогийн “Хан хөхийн уянга” зохиолын эхлэл хэсгийн аялгууны санааг олжээ.

1968 онд МУГЖ Ж.Мэнд-Амар мөн нутгаар явж дээрх түүх, домгийг сонсож ирээд, хөгжмийн зохиолч Л.Мөрдоржтой уулзан түүний бичсэн дээрх аялгуун дээр үндэслэн МУГЖ алдарт лимбэчин М.Бадамтай хамтран “Хан хөхийн уянга” хэмээх зохиолоо бичжээ. Ийнхүү Хан хөхийн уянга зохиол уран бүтээлчдийн хамтын уран сэтгэмжээр бүтсэн түүхтэй.



Уул тал ан амьтдын дуу чимээ, бугын урамдах дууг дүрслэн доод регистрт их лимбээр янз бүрийн хөгжимдөх арга барил, чимэглэнг хэрэглэн хөгжимддөг.



Дунд хэсэгт жижиг буюу өчүүхэн лимбэний хэл, хурууны олон арга техникийг ашиглан шувуудын жиргээ, усны шаагин урсах чимээг уран сайхны аргаар дүрсэлжээ.



Байгалийн сайхныг дүрсэлсэн ба энд ёочин лимбэний харилцаар хүн байгалийн шүтэлцээг харуулсан.

Д

- Үндэсний хөгжмийн зэмсгүүдийн хөгжимдөх арга барил, хөгжмийн зэмсгийн төрөл зүйл, эгшиглэгээний онцлог, хөг багтаамжтай танилцъя.
- Доорх хүснэгтээс дутууг нөхөж, мэдлэгээ сориорой.
- Зэмсэгт зориулсан бүтээлийн жишээ нэрлээрэй.

Хөгжмийн зэмсэг	Хөгжимдөх арга барил	Хөгжмийн зэмсгийн төрөл зүйл	Эгшиглэгээний онцлог	Хөгжмийн зэмсгийн хөг багтаамж
Морин хуур			Уянгалаг, зөвлөн дуутай	?
Их хуур	Чавхдасыг нумаар хөрөөдөж, дуу авиа үүсгэдэг	?	?	Квинт хөгтэй, цараа нь контр октавын си bemol - их октавын фа
Хуучир			Уянгалаг, зөвлөн дуутай	?
Шанз	?	Чавхдаст товшвор хөгжмийн зэмсэг	Тунгалаг яруу дуутай, цэвэр тод эгшигтэй	Хөг нь соль – ре – соль, цараа нь бага октавын соль – III октавын соль
Ятга			?	Бага октавын соль- III октавын ре
Ёочин	Чавхдасыг тусгай цохиураар цохиж, дуу авиа үүсгэдэг	?	Тод, чанга, хүчтэй цангинасан, цууртайсан дуутай	?
Лимбэ		?	Хангинаам, цоглог, тунгалаг, уянгалаг яруу дуутай	Бага октавын фа - II октавын фа
Эвэр бүрээ	?	Үлээвэр хөгжмийн зэмсэг	?	Бага октавын ре – III октавын ре



УРАН БҮТЭЭЛЧИЙН ХӨРӨГ

Төрийн соёрхолт ардын жүжигчин Лувсанжамбын Мөрдоржийн уран бүтээлтэй танилцъя.

Дуу

- Монгол улсын Төрийн дуулал (1951)
- Эх орон (1944)
- Дөрвөн цагийн тал
- Түүхт хил (1938)
- Ган зам зэрэг 200 гаруй дуу



Симфони

- Миний эх орон (1955)
- Октябрь (1967)
- Ардын наадам (1973)
- Залуучуудын хэмээх симфони (1982)

Цөөхүүл хөгжим

- Хаврын шувуу ирлээ ёочингийн гоцлол (1975)
- Унаган жороо шударгын гоцлол (1958)
- Чавхдаст хөгжмийн гурвал (1987)
- Айраг нуур хийлийн чуулга (1967)

Төрийн хошой соёрхолт,
Ардын жүжигчин хөгжмийн зохиолч **Л.Мөрдөрж**
(1919-1996 он)

Дуурь

- Хөхөө намжил (1961)
- Жаргал (1974)

Киноны хөгжим

- Алтан өргөө (1962)
- Анхны алхам (1969)
- Морьтой ч болоосой (1959)
- Ардын элч (1959)
- Миний Монгол баримтат кино (1971)
- Орчин үеийн Монгол (1958)

Л.Мөрдөржийн “Миний эх орон” I симфонио туурвижээ. Энэ симфони нь Монголын анхны симфони бөгөөд ард түмний зовлонт үе, эрх чөлөөний төлөө хийсэн тэмцэл, ялалт, ирээдүйд тэмүүлсэн хүсэл эрмэлзлийн тухай хүүрнэл, зураглал юм. Л.Мөрдөрж энэ агуулгыг илэрхийлэхдээ монгол ардын дуу “Гоолингоо”, “Цомбон туурайтай хүрэн”, хувьсгалын сэдэвт “Магнаг үсэгтэй туг”, “Агаараар нисдэг Аэроплан” дуунуудыг авч хөгжүүлсэн.

Гоолингоо

Цомбон туурайтай хүрэн

Монголын радио өглөө бүр биднийг Л.Мөрдөржийн “Эх орон” дуугаар дуудан сэрээдэг.

Эх орон

Д

- Тодорхой хөгжмийн зохиолчийг сонгон түүний уран бүтээл, бүтээл төрсөн түүхээс мэдээлэл цуглувалж, зохиолын хэсгээс эш татах, дуулах, аялах, сонсох зэргээр бүтээлчээр ажиллаж уран бүтээлчийн хөрөг бүтээгдээрэй.





- Дүрслэх урлагийн бүтээлээс сэдэвлэсэн ямар ямар хөгжмийн зохиол мэдэх вэ?
- Уран бүтээлчид эх орон, газар нутаг, уул усаа хүндлэн дээдлэх сэтгэлээ илэрхийлэхдээ урлагийн ямар төрөл, арга хэлбэрийг сонгон авсан бэ?
- Хөгжмийн зохиолч симфони зураглалдаа баруун монгол ардын дууны аялгууг авч ашигласны учир юу вэ?
- Сэдэв аялгууг ноотоор аялаарай.
- Баруун монголын “Хартай сарлаг”, “Жуураа гэлдэнэ” дууг дуулж сурцгаая.



Т.Сэр-Од

АЛТАН ДУУЛГА
(Симфони зураглал)

Увс аймгийн нутагт орших Хан Хөхий уулын ноён оргил нь “Алтан дуулга” нэртэй. Монгол Улсын төрийн тахилгатай газруудын нэг бөгөөд өвөг дээдсийн үеэс “Диваажингийн орон” хэмээн дээдлэн биширч иржээ. Зураач Ц.Очирбал “Алтан дуулга” хайрхнаа дээдлэн урлагийн бүтээл туурвижээ. Энэхүү бүтээлээс сэдэвлэн УГЗ хөгжмийн зохиолч Т.Сэр-Од 2010 онд морин хуурын чуулга, яруу найрал хөгжимд зориулан “Алтан дуулга” хэмээх симфони зураглал бичсэн юм.

**А хэсэг**

Зохиолын эхний хэсэг нь байгаль дэлхий, уул хайрхныг зурагласан гол дуулал. Энд баруун нутгийн бэсрэг уртын дууны аялга сонсогдоно.

В хэсэг

Хоёрдугаар хэсэгт эгшиглэх эрчимтэй, хурдтай, өрнүүн сэдэв аялгууг баруун монголын “Жуураа гэлдэнэ” дуут бүжгээс сэдэвлэжээ. Энэ хэсэгт баруун монголчуудын “Бий” бүжгийн уламжлалт татлагын хэв шинж мэдрэгдэнэ.

**С хэсэг**

Зохиолын төгсгөл нь хүн байгалийн харилцаа, бахархал, нигүүслийн тухай дуулал. Энэ хэсгийг баруун монголын “Хартай сарлаг” дууны аялгуунаас сэдэвлэжээ.



Д

- Хөгжмийн толь ашиглаж хурдыг тодорхойлоорой.

“Алтан дуулга” симфони зураглал

A

Adagio commodo

B

Allegro molto

C

Grave maestoso

“Алтан дуулга” симфони зураглалын эхлэл хэсэг



- Шүлгийг уншаад, ялган тэмдэглэсэн үгс юу илэрхийлж байгааг эргэцүүлээрэй.

ЖУУРАА ГЭЛДЭНЭ

Атан тэмээний

Тором тэмээний

Ботгон тэмээний

Алхааг дуурайгаад

Алхааг дуурайгаад

Алхааг дуурайгаад

Аялгуут дуундаа

Товшуур хөгжимдөө**Балчин хээр** -тээ**Бий** - гээ биелнэ

Бийгээ биелнэ

Бийгээ биелнэ

Жуураа гэлдэнэ

Жуураа гэлдэнэ

Жуураа гэлдэнэ

Жуураа гэлдэнэ

Д

- **Бий, ихэл, хуур, товшуур, хөөмий, татлага-** эдгээр үгс баруун Монголын хөгжмийн соёлтой хэрхэн холбогдох вэ? Сонирхон судлаарай.



- Баруун Монголын “Жуураа гэлдэнэ” дууг хөгжимдэж сурцгаая.



Allegretto

Allegretto





Нацагийн Жанцанноров

Төрийн соёрхолт, Ардын жүжигчин, хөгжмийн зохиолч, хөгжим судлаач, нийгэм соёлын зүтгэлтэн. Тэрээр дуулаачийн болон зэмсэгт хөгжмийн бүтээл, киноны хөгжмийн төрлөөр олон арван бүтээл туурвижээ. Тэдгээрээс морин хуурын гоцпол, цөөхүүл чуулгын бүтээлүүд нь хөгжимчийн ур чадварын хөгжилд чухал нөлөө үзүүлж, морин хуурыг олон улсын түвшинд таниулсан юм. Морин хуурын гоцполд зориулсан “Сэтгэлд шингэсэн гөв”, “Сэтгэлийн тойрог”, чуулгад зориулсан “Монгол аялгуу”, “Нутаг минь хүлэг минь”, “Цагаан суварга”, “Найман шарга”, “Хүслийн төвөргөөн”, “Эгшиг хэмнэл”, “Их тэнгэрийн ивээл” зэрэг олон сайхан бүтээл бий.

ЦАГААН СУВАРГА

Н.Жанцанноров

Н.Жанцанноровын бүтээлүүдээс хамгийн энгийн мөртлөө хэн бүхний сэтгэлийг амирлуулан тайвшруулах агуу увдистай нэгэн бүтээл бол “Цагаан суварга” юм.

Энэхүү бүтээлтэй танилцъя.




- Зураглалын дагуу хөгжмөө сонсоорой.
- Аялгууны зураглалыг сайтар ажиглаад, хөгжмийн байгууламжийг тодорхойлохыг хичээгээрэй.
- Хүний дотоод сэтгэлийн ариусал, гэгээрэл, тайтгарлыг чухам юунаас олж мэдэрсэн бэ?
- Аялгууны шинж төрх, хурд, хүч ямар байна вэ? Агуулгатай холбон тайлбарлаарай.

Түлхүүр:

Зураглал дах нэг дөрвөлжин нэг дөрөвтийг төлөөлөх бөгөөд эдгээр дүрсүүдээр хэмнэлийг илэрхийлсэн болно.

Харин босоо багана дах үсгэн тэмдэглэгээгээр эгшгийн өндрийг тодорхойлсон. Аялгууны хөдөлгөөнийг зураасаар, зэмсэгжилтийг зургаар илэрхийлсэн.





- Д**
- Энэхүү зохиолыг бишгуүрээр хөгжимдөцгөө.
 - Амьсгааны эхний тэмдгийг ажиглаад, дараагийн тэмдгүүдийг амьсгаа авах хэсэгт байрлуулаарай.
 - II хоолойн барилттай хэсгүүдэд амьсгааг гүйцэд авч жигд үлээгээрэй.
 - Ижил эгшигийг холбосон нуман холбоосыг хэрхэн хөгжимдэх вэ?
 - Ноот бичлэгийг ажиглаад, хөгжимдөхөд хүндрэлтэй хэсгүүдийг тэмдэглээрэй.



Н.Жанцанноров

ЦАГААН СУВАРГА

Andante



1.5. МОНГОЛ АРДЫН БҮЖИГЛЭХ УРЛАГ

ЯЗГУУР БИЙ БИЕЛГЭЭ

Д

- Эх бичвэрийг уншаад, дараах чиглэлээр асуулт зохиогоорой.

№	Асуултын чиглэл	Асуулт боловсруулах жишиг
1	Гол санааг илрүүлэх асуулт	Уян налархай хөдөлгөөнөөр илэрхийлэгдэх урлагийн төрөл юу вэ?
2	Ангилан бүлэглэх асуулт	Баруун монголчуудын дунд өргөн дэлгэрсэн ардын бүжгийн төрөл юу вэ?
3	Задлан шинжлэх асуулт	Бий биелгээ тайзны бүжиг хоёрын ялгаа юу вэ?
4	Нэгтгэн дүгнэх асуулт	Хотон биелгээний агуулга дүрслэл юунд чиглэдэг вэ?
5	Бүтээлч эрэл хайгуул хийх асуулт	Үндэстэн ястан бүр өөрийн соёл, ахуй, зан заншлаа илэрхийлсэн бүжигтэй. Түүнийг батлах жишээ нэрлээрэй.



Чичирхийлсэн, сугсарсан, дугтарсан, нухалсан гэх мэт янз бүрийн хөдөлгөөн оролцдог. Хөдөлгөөн нь энгийн мөртлөө уран нарийн олон төрлийн хаялга, цацал, цацлага, цохилго, дугтрапт, дэвэлт, сугсралт, зогсолт, суудал зэрэгт түшиглэн хийгддэг.

Баруун монголчуудын угсаатан бүр олон төрлийн бий биелгээтэй бөгөөд онцлог нь тоглоом наадгай, шагай, няслах, тамхи нэрэх, үйл урлах, золгох, цайлах, тариа будаа тарьж боловсруулж буй зан үйл, мөн хүний зан араншин, үйл явдал, уг яриаг домоглон гаргасан байдаг. Тэд дуутай, хөгжимтэй гэсэн 2 янзаар биелдэг ба гол бийгээс дурдвал такмоо бий, аяс бий, сэдэн залуу, тогоруу бий зэргийг нэрлэж болно.

Бий биелгээ нь голдуу баруун монголчуудын дунд тархсан бүжгийн урлагийн томоохон хэлбэр бөгөөд хурим найр, баяр ёслолын үед ихэл, морин хуур хөгжмийн татлага аянд ганц нэгээрээ, эсвэл нийтээрээ биелдэг заншилтай.

Бий биелэхэд сарвуу, тохой, гар, мэр, цээж, хүзүү, толгой, биеийн бүх хэсгийн уян хатан, огцом хурц

ДӨРВӨН ЗОХИЦОЛТ ХӨДӨЛГӨӨН

Баруун монголчуудын бий биелгээ буюу уламжлалт бүжигт анхлан суралцагчдад зориулж МУГЖ Д.Нанжид “Дөрвөн зохицолт хөдөлгөөн”-ийг зохиосон юм. Үүнд:

- Хөл, гарын байрлалын дасгал
- Суудлын дасгал
- Мөрний дасгал
- Цээжний дасгал ордог. Энэ 4 дасгалыг сайн сурснаар бий биелгээний суурь хөдөлгөөнийг эзэмшлээ гэж үздэг. Мөрний хөдөлгөөн нь урагшаа, хойшоо мөрөө ээлжлэн хаялж хөдлөх боловч цохилох, сугсрах, дугтрах гэдгээрээ ялгаатай.
- Цохилго- мөрөөрөө цохих маягаар хөдлөхийг хэлнэ.
- Сугсрах- мөрөө хоёр тийш нь сул хөдөлгөнө.
- Дугтрах- мөрөө аажмаар удаан өргөж байгаад огцом хаялж хөдөлнө.

Баруун монголын олон угсаатны (баяд, дөрвөд, захчин, торгууд, урианхай, хотон) бий биелгээ нь домог, зан заншил, байгаль өртөнцийн үзэгдэл юмтай холбоотой юм. Дээрх угсаатнуудын бий биелгээний нэр нь зарим талаар адил боловч бийг биелэх дэг намба нь ялгаатай байдаг.

Язгуур бий биелгээний гарын байрлал

Д

- Зургийн дагуу дасгал хөдөлгөөнийг гүйцэтгээрэй.



Язгуур бий биелгээний үндсэн суудал



Хагас тахимцаа суудал



Бүтэн тахимцаа суудал



Хаан суудал



Цомцойх суудал

Язгуур бий биелгээний үндсэн зогсолт



Түших



Зэллэх



Дэлгэх



Боох



Өрөх



Солбих

ДӨРВӨД БИЙ БИЕЛГЭЭ

“Жороо морь” бийгийн домог

Зүүнгарын хаант улсын үед юм гэнэ. Балхаа нуур гэж тунгалаг устай нуур байж. (Одоогийн Казакстан улсын нутагт байх Балхаш нуур) Монголчууд эртнээс жороо морийг сургахдаа тунгалаг нуур усандaa дүрсийг нь харж жороолуулан сургадаг байж. Тиймээс морины хондлой дээр аягатай цэгээг (айраг) тавьж Балхаа нуурын усанд дүрийг нь харж жороо сургадаг байсан гэнэ. Аягатай цэгээг асгалгүй жороолж байвал, усан тэлмэн жороо гэх бөгөөд сургасан байдлаар нь хонин жороо, тэмээн жороо гэхчлэн нэрлэдэг байжээ. Энэхүү

домгоос үүдэн морины явдлыг харуулсан “Жалам хар”, “Жороо морь” гэх мэт олон бий биелгээ үүсчээ. Энэхүү домог Ойрадын олон угсаатанд нийтлэг уламжлагдан иржээ.



Дөрвөд бийд мөргөл, аягатай бий, цацал, жороо морь, дөрвөн ойрад, елкэндэг, хөдөлмөр зэрэг 7 бий байдаг.

Дөрвөд бийг биелэх онцлог:

1. Мөр солбиж цохих, толгой гар хоёр зөрж биелэх;
2. Гарыг хумъж хаях, задгай хаялж биелэх;
3. Эрүүгээр жижиг хаялж биелэх;
4. Тахимцаа суудлаар сууж биелэх;
5. Алхалт, гишгэлтээр хөл зөөж эргэх, суух зэргээр хөлөөр хамтатган биелдэг байна.

Д

- Зураглалын дагуу дасгал хөдөлгөөнийг дуурайн хийж сураарай.



ЗАХЧИН БИЙ БИЕЛГЭЭ

“Өрөөлт халтар” бийгийн домог

Эрт цагт нэгэн хүү эхийн хамт амьдардаг байжээ. Тэр хүү хайртай халтар морьтой юмсанж. Гэтэл хятад худалдаачны өр нэхэгдэж хайртай морио уйлан, хайлан байж алс холын нутагт өгч явуулжээ. Хэдэн жилийн дараа гэрийн гадна морь янцгаах чимээнээр гараад хартал, хайртай халтар морь нь уянан дээрээ өрөөлтэй (морины 4 хөлний хоёр хөлийг чөдөрлөхийг хэлнэ) гүйж ирсэн байв. Хүүгийн сэтгэл нь уярч баярлан, холын Бээжингээс эх нутгаа, эзнээ зорин хүнд бэрхийг туулан гүйж ирсэн мориндоо зориулан “Өрөөлт халтар” бийг зохиосон домогтой. Энэ бийг биелэхдээ өрөөлтэй морины гишгэгдлийг дуурайлган 3/4 хэмжээнд биелдгээрээ онцлог юм.

- Жишээ болгон “Тооройн цагаан элс” дууг сонсож, ноотоор дуулж сураарай.

Сэргэлэн

Too - ройн ца - гаан тоо - ройн ца - гаан элс _____ нь

4

To - ройж цай - гаад то - ройж цай - гаад байна _____ л

Захчин бийг биелэх онцлог:

1. Тахимцах суултаар сууж биелэх;
2. Мөрийг солбиж, гарын алгыг дээш харуулан ширвэн хаялж савлан биелэх;
3. Мөрийг ээлжлэн газар цохилон биелэх;
4. Далыг ээлжлэн газар цохилон биелэх;
5. Толгойг хөдөлгөхгүй биелэх;
6. Гарын хаялга толгойноос дээш гарахгүй байх;
7. Алхалт, гишгэлтээр хөл зөөж эргэх, суух зэргээр хөлөөр хамтатган биелдэг.

АРВАН ХУРУУНЫ БИЕЛГЭЭ

Захчин бийд арван хурууны биелгээ гэж байдаг. Энэ нь хуруугаа ширхэгчлэн тоолж биелдэг байна. Өөрийн уян тансаг хөдөлгөөн, хурууны уян налархайг харуулахаас гадна, ухаан уралдуулах, нүдний хараа сайжруулах, эвсэл суух, мэдрэмжтэй болох зэрэг сайн талтай.



- Зураглалын дагуу хөдөлгөөнөө хийж сураарай.
- Арван хурууны бийгээ дээрх дуутай хослон биелээрэй.



Чигчий хуруунаас эхлэн ядам, дунд, долоовор, эрхий гэсэн дарааллаар хоёр гарын хурууны өндгийг нийлүүлэн солбиж, мөр тохойгоороо дагаж биелнэ.



ТОРГУУД БИЙ БИЕЛГЭЭ

“Эрээн хавирга” бийгийн домог

Торгуудууд одоогийн Шинжаан-Уйгарын өөртөө засах орны Ховог сайр аймгийн “Хар сайр”, “Эрээн хавирга” гэдэг газраар нутагладаг байжээ. Тиймээс нутгаа дурсан санаж “Эрээн хавирга” бийг зохиосон домогтой. Ингэж газар нутгийнхаа тухай тусгасан бий биелгээ үүсч буй болсон байна. Торгууд бийд агсал, хэлхээ агсал, цацал, жудар, ховог, эрээн хавирга зэрэг 6 бий байдаг.



ЖУДАР

Жудар бий нь охид, эмэгтэйчүүд өөрийнхөө бүхий л гоё ганганыг гайхуулах, тодотгон харуулах, зорилгоор бие, нүүрний орчимд голдуу гарын зэрсөн, огцом хөдөлгөөнөөр илэрхийлэгддэг.

Ингэхдээ гарыг атгаж тавих, бугалгаар эргүүлэх, эргүүлж буулгах, бугалганы үеэр хөдлөн гарын сарвууны тусламжтай мөр, тохой хөдөлгөх зэргээр биелнэ. Хөлийн байрлал голдуу тахимцаан дээр байрлана. Гэхдээ үсэрч, эргэлдэж, бүтэн, хагас суудал хийх, дээшээ өлмий дээрээ гарч болдог. Жудар бийг гол төлөв гарын бугалгаар хөлийн тахимцаа суудлын байрлалд гүйцэтгэнэ.



Гарын сарвууг атгах, тэнйилгэх, солбих хөдөлгөөнийг хийгээрэй.

Гарын сарвууг зэрэг атган, огцом цацах хөдөлгөөнийг хийгээрэй.

УРИАНХАЙ БИЙ БИЕЛГЭЭ

“Цацал” бийгийн домог

Эрт урьдын цагт нэг эмгэн Алтай таван бодын оргилд суух шувуу руу хоол шиджээ. Гэтэл тэр шувуу оргилоос нисэн ирж хоолыг шүүрч аваад явж гэнэ. Үүнийг эмгэн ажиглаад орчлонгийн хүн, амьтан ялгаагүй нэгэндээ тусалж дэм болох ёстой юм байна. Мөнх цаст оргилд байх тэр амьтанд ч бидний тус хэрэгтэй. Идээ цагааны дээжээ цацаж өгөх нь зөв хэмээн боджээ. Энэ явдлаас хойш хангай дэлхий, араатан жигүүртэнд идээ цагааны дээж өргөх “Цацал” бий үүссэн домогтой.

Урианхайд мөргөл, алдлах, цацал, хатираа, жороо морь, шудрах зэрэг бий биелгээ байдаг. Урианхай бийгийн намба төрх нь товшуурын савардан татах хэмнэлд гоц тохирсон байдаг. Үүгээрээ ихэлийн татлагаар биелдэг бийгээс өөр дэгтэй.



Баруун монголд ихэд дэлгэрсэн чавхдаст хөгжмийн нэг төрөл нь товшуур юм. Товшуурыг хус, дуут мод, улаан modoor хийдэг.

Бүтцийн хувьд цар, иш, толгойн хэсгээс бүрдэнэ. Хоёр чавхдастай бөгөөд малын шөрмөс, нарийн тортон утас, хялгасаар ч хийдэг. Дөрөвц, тавцын хөгөөр хөглөдөг. Долоовор, эрхий хуруугаар товшин тоглодог. Баруун монголын олон ястны дунд ааган, хилдүүр, бөөрөнхий, дөрвөлжин, хун, чандмань, янгир гэх мэтээр нэрлэгддэг.

Д

- Зураглалын дагуу хөдөлгөөнийг товшууртай хамсран биелж сураарай.



ХОТОН БИЙ БИЕЛГЭЭ

“Ац” бийгийн домог

Урьд цагт ах дүү хоёр тариа тарьж амьдардаг байж гэнэ. Нэг өдөр тариагаа тарихаар явж байгаад нэгэн модны сүүдэрт амраад сууж байтал салхи гарч, модны нэг салаа мөчир нь газарт шүргээд, буцаад дээшшээ цацагдаад байхыг дүү нь хараад ахдаа хэлж гэнэ. Нэг модноос ургасан хоёр салаа мөчир газар шүргэн найгаж байгаа шиг хоёулаа биелэх үү гэжээ. Тэрээр:

“Ацтай мод шиг савлан биелье

Навчтай мод шиг найган биелье” хэмээн дуулан бийлжээ. Хотонгийн “Ац бий” ингэж үүссэн домогтой.

Хотон бий биелгээний намба төрх нь жавхаалаг, сэтгэлийн дотоод илэрхийллийг гарын хурц, тод таталт шидэлтээр гаргаж, хотон хүний зан аалийг харуулдгаараа онцлогтой.

Хотон бийд аяс, такмоо, цацал, сэдэн залуу, жороо морь, их татлага, ац зэрэг 6 бий биелгээ байдаг.

Д

- Зураглалын дагуу хөдөлгөөнөө хийж сураарай.
- Суудал ямар ялгаатайг ярилцан, зөв биелээрэй.



БАЯД БИЙ БИЕЛГЭЭ

“Баяд” бийгийн домог

“Эрт дээр үед бүхий л биеэрээ уран тортон гайхалтай биелдэг нэгэн бийч байсныг чөтгөр ирээд чамайг биелдэггүй болгоно гээд бусэлхийнээс нь доош чулуу болгочижжээ. Гэтэл цээжин биеэрээ найган биелж гэнэ” хэмээн домог баяд түмний дунд уламжлагдан яригдааар иржээ. Тиймээс баядын бий биелгээ нь дээлийн хормой хөдөлгөхгүй биелдэг хатуу дэгтэй болсон гэдэг. Баядад мөргөл, элхэндэг, цацал, аягатай бий, жороо морь, дөрвөн ойрад, елкэндэг зэрэг 8 бий байдаг.

Баяд бийг биелэх онцлог:

- Хоёр хөлийг бүтэн улаар бат зогсох;
- Гүн суултаар суух;
- Хоёр өвдөг, гар, толгой дээрээ аягатай сүү тавьж биелэх;
- Зөвхөн цээжин биеэр найган биелэх;
- Гар нь толгойгоо дагах;
- Хавирган хаялагатай биелэх;
- Далны цохилго хийх;
- Гарын алгыг дээш хандуулах;
- Бийг дараагийн хүнд шилжүүлэхдээ хоёр гарсаа дээш харуулан мэхийн ёслоч зэрэг дэгийг биелүүлэх шаардлагатай.



Аягатай бий

Д

- Үндэстэн ястан бүр өөр өөрийн соёл ахуй, зан заншлаа илэрхийлсэн бүжгүүдтэй гэдэг. Түүнийг батлах жишээнүүдийг нэрлээрэй.
- Бий биелгээ сэдвээр ном болон цахим өртөнцөөс, уран бүтээлчид, ахмад хүмүүсээс мэдээлэл цуглуулж сонирхолтой эх сурвалж олоорой.



Монголчуудын уламжлалт бүжиг – бий биелгээ нь Монгол улсын соёлын ховор хосгүй өвийн зэрэглэлд багтдаг бөгөөд 2009 онд ЮНЕСКО-гоос яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн дэлхийн жагсаалтад бүртгэн тунхагласан.

Д.Лувсаншарав

НАРНЫ ДОМОГ

Монголын анхны ардын бүжгэн жүжиг “Нарны домог”-ийг төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Д.Лувсаншарав, ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн цомнолоор туурвижээ. Энэ бүтээлийг XIII зууны монголчуудын бичиг зохиолын дурсгал болох Монголын нууц товчоон дахь Алун гоо эхийн домгоос сэдэвлэн зохиожээ.

Алун гоо эхээс эрэлхэг таван хөвгүүн мэндлэв. Муу санаат чөтгөрүүд цэцэг болон хувирч, тэднийг ховсдон муудалцуулна. Үүнийг мэдсэн Алун гоо эх хөвгүүддээ нэг, нэг сум өгч хугалахыг хүсэв. Тэд төвөггүй хугална. Таван сумыг нийлүүлэн багцалж өгөхөд харин чадсангүй. Эх хөвгүүддээ багцалсан таван сум мэт эвтэй байхын чухлыг сургана.

Уг бүжгэн жүжиг нь халх, буриад, торгууд, дөрвөд, цаатан зэрэг угсаатны дуу хуур, бий биелгээний уламжлалд тулгуурласан.

Бөөгийн бүжигт цохивор хөгжмүүд, хэнгэрэг голлох үүрэг гүйцэтгэх бөгөөд хархираа хөөмий, төмөр хуурыг ч ашигласан нь өвөрмөц сонсодгоно. Залуус гарaa барилцан галаа тойрч бүжиглэх нь буриадын “Ёохор” бүжгийн хөгжмийн хэмнэл, хөдөлгөөнийг санагдуулах бөгөөд голомтоо бадраан, эв найртай амьдрах санааг илэрхийлжээ.



Ардын баярын хэсэгт залуу насын эрч хүч, хайр сэтгэлийг илэрхийлсэн “Булдруут” хэмээх бүжиг бүждэг. Цаатнуудын хэрэглэдэг “Булдруу” гэх зэмсгийг хоёр гартаа барьж хэмнэл цохиж бүжиглэнэ.

Бүжгэн жүжгийн төгсгөлд “Уяхан замбуу тивийн наран” уртын дууг дуулах нь ивээлт нарны дор эрх жаргалтай амьдрах болтугай хэмээн ерөөл өргөх мэт санагдана. Бүжгэн жүжигт нараар эрх чөлөө, аз жаргалыг бэлгэдэж “Эвтэй бол хүчтэй” гэсэн санааг гаргасан юм.



- Булдруут бүжгийн хөгжмийг сонсоод, хэсгүүдийн ээлжлэлтийг тодорхойлоорой.
- Эхлэл болон төгсгөлийн хэсгийн хурдыг тодорхойлоорой.
- Хурдан, удаан хэсгийн илэрхийлэмж, төлөв байдлыг өөрийн сэтгэгдлээр бичээрэй.

Д

A
Хурд ?



B
?



?
?





- Эхийг уншаад, сюитийн тухай ойлголтоо бататгаарай.
- Хөгжмөө анхааралтай сонсоод халх, буриад, хотон, үзэмчин, казах, мончоого бүжгийн аялгууны шинж төрх, хурдны ялгааг олж ярилцаарай.
- Хөгжмийн зохиолч, бүжиг дэглээч хоёр “Монгол бүжгийн чуулбар” зохиолоороо юу хэлэхийг зорьсон гэж бодож байна вэ?
- Монгол бүжгийн чуулбар зохиолоос үзэгч сонсогчид өөртөө чухам юуг олж авах хэрэгтэй вэ?



МОНГОЛ БҮЖГИЙН ЧУУЛБАР

Сюйт буюу чуулбар аяз- дараалал гэсэн утгатай франц үг. Бие даасан бүжгийн аязуудын дарааллаас бүрдсэн цуврал зохиол.

Г.Цэрэндоржийн хөгжим, Ц.Сэвжидийн дэглэлт “Монгол бүжгийн чуулбар” нь Монголын олон үндэстэн, ястны эв зэтэй, аз жаргалант, эрх чөлөөт амьдралыг магтан дуулсан томоохон хэлбэрийн бүтээл юм.

Уг бүжгийн зохиомж нь бүжигчид үзэгч олонтойгоо мэндлэн золгож буйгаар эхлэх бөгөөд үндэстэн, ястан бүр өөр өөрсдийн өвөрмөц хөг аялгуунд ээлж дараалан бүжиглэдэг. Тэд улмаар нэгдэн нийлж монгол үндэстний соёлын олон өнгө аясыг илтгэн бүжиглэдэг.

Энэхүү алдарт бүтээл нь халх, буриад, хотон, үзэмчин, тува, казах зэрэг монголын олон ястны ардын бүжгийн намба төрх, донж маяг, өвөрмөц хөдөлгөөнийг харуулдаг. Бүжгийн нэг онцлог нь дуут бүжгийн уламжлалыг хадгалан тухайн үндэстэн, ястны ардын дуунуудыг оруулж өгсөн монгол үндэсний урлагийн цогцолбор бүтээл болж чадсан.

1975 онд “Монгол бүжгийн чуулбар”, “Хөдөө нутгийн залуус”, “Ээрүүлт” уран бүтээлүүдээрээ хөгжмийн зохиолч Г.Цэрэндорж бүжиг дэглээч Ц.Сэвжид нар “Төрийн соёрхол” хүртжээ.





- Г.Цэрэндорж “Монгол бүжгийн чуулбар” зохиолыг сонсоцгооё.
- Хөгжим сонсож байх үедээ сонссон хэсгийнхээ талаар тэмдэглэл хөтлөөрэй. Тэмдэглэл хийхдээ дараах алхмуудыг дагаж мөрдөөрэй.

1. Сонссон хөгжмийн зохиолын нэр, зохиогчийг бичнэ.
2. Хөгжмийн зохиол дуулаач, дан хөгжим, эсвэл дуу, сонат, оратори, магтуу, концерт, гоцлооч, найрал дуучид гэх мэт ямар төрөл зүйлд хамаарах.
3. Ардын хөгжим, симфони найрал хөгжим, төгөлдөр хуур, нарийн бүрээ, морин хуур гэх мэт ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсөн.
4. Эрчилсэн, намуун, тайван, тасралтгүй, нэгэн хэвийн, огцом, эрс тэс, эмзэг, тогтвортгуй гэх мэтээр аялгууны шинж төрх, онцлогийг үгээр болон графикаар тэмдэглэх.
5. Аялгууны хурд болон хүчдэлийн өөрчлөлт, бүтэц хэсгийг тэмдэглэх.
6. Хөгжмийн зохиолын агуулга, дүрийн талаар өөрийн төсөөллөө бичих.
7. Зохиолын агуулга, утга санааг өөрийн амьдралын туршлагатай холбож тэмдэглэх.
8. Зохиолын үйл явдал, өрнөл хөгжилтэй холбогдуулан асуулт гаргах.

Ийнхүү сонсголын ажиглалт хийж, мэдэрч, ойлгож сонсох нь үр дүнтэй гэдгийг зөвлөж байна. Хөгжмийг зөвхөн уярч биш ухаарч сонсьё.

№	Асуулт	Тэмдэглэл
1	Зохиолын нэр	Монгол бүжгийн чуулбар
2	Хөгжмийн зохиолч	Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Г.Цэрэндорж Төрийн соёрхолт бүжиг дэглээч Ц.Сэвжид
3	Хөгжмийн зохиолын төрөл	?
4	Хөгжмийн зэмсэг	?
5	Аялгууны шинж төрх, онцлог	Үндэстэн, ястан бурийн онцлогийг харуулсан хүндэтгэлтэй, хөгжилтэй, дуулалт шинж төрхтэй.
6	Аялгууны хурд	?
7	Хүчдэлийн өөрчлөлт	Үндэстэн, ястан бурийн онцлогоос шалтгаалж хүчдэл нь аажим өөрчлөгднө.
8	Бүтэц хэсэг	?
9	Агуулга, дурслэл	?



- Бүжгийн хөгжмөөс ноотоор дуулцгаая.
- Ямар ястны бүжгийн аялгуу байна вэ?



ХОЁРДУГААР БҮЛЭГ.

2.1. МОНГОЛ АРДЫН ДУУ ХӨГЖМИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Монголын орчин цагийн хөгжмийн урлаг бол эртнээс уламжлагдан ирсэн ардын хөгжмийн үндэс суурин дээр дэлхийн хөгжмийн ололт, амжилтаас суралцсан урлаг билээ. Өөрөөр хэлбэл ардын дуунаас дуурь хүртэл, ардын хөгжмийн аялгуунаас симфони хүртэл, бий биелгээнээс бүжгэн жүжиг хүртэл хөгжин дэвшиш юм. Тухайлбал: Үндэсний урлагийн түүхийн шинэ хуудсыг хувьсгалын дуунууд нээсэн билээ. Энэ нь монголын уламжлалт дууны уран бүтээлийг агуулга, хэлбэр, аялгын хувьд баяжуулж өгсөн юм. Анхны хувьсгалын дуунуудыг ардын дууны хөг аялгуунд тулгуурлан зохиосон байдаг. Жишээ нь:

- Улаан туг (МАД Дүнжингараевын ар) 1921 (М.Дугаржав)
- Магнаг үсэгтэй туг (МАД Арван өнгийн цэцэг) 1921 (М.Дугаржав)
- Шивээ Хиагт (МАД Хүрэл сүм) 1921 (зохиогчид – Ч.Дамдинсүрэн даргатай буучийн сумангийн байлдагчид, хуурч н.Гавар, н.Гомбожав, н.Лувсанцэрэн, н.Чимэддорж, н.Бямбаа).



- Ноотоор дуулаад, харьцуулаарай.

Хүрэл сүм

Уянгатай

Ху - рэл сү - мийн үү - дэн - дээ Ху - жээ(н) ба - риад мэр - гене дээ

Шивээ хиагт

♩ = 16

Ши - вээ хиаг - тыг ав -(a)-хад - (aa) Ши - лэн дэн - лүү хэ - рэг - гүй

Монголд үндэсний дуурь үүсч хөгжих суурь нь мэн л ардын харилцаа дуу, дуулалт жүжгүүд билээ. Манай анхны дуурь “Учиртай гурван толгой” нь “Да вангийн Юндэн гөөгөө” гэдэг ардын харилцаа дуунаас эх авч дуулалт жүжгийн үе шатыг дамжин шинэчлэгдсээр үндэсний алдарт дуурь болсон юм.

Симфони найрал хөгжмийн анхны том бүтээл Ц.Намсрайжавын “Хувьсгалт баатарлаг марш” (1950 он) удиртгалд ч ард түмний дунд өргөн тархсан “Олон жил”, “Агаараар нисдэг аэроплан”, “Шивээ Хиагт” зэрэг хувьсгалын дуунуудыг гол сэдэл болгон ашиглажээ.

Монголын анхны ардын бүжгэн жүжиг “Нарны домог”-ийг халх, буриад, торгууд, дөрвөд, цаатан зэрэг угсаатны бүлгийн дуу хуур, бий биелгээний уламжлалд тулгуурлан тавьсан юм. Ийнхүү аливаа улс түмэн ардын уран бүтээлийн уламжлал дээрээ тулгуурлан хөгжмийн шинэ сан хөмрөгийг бүрдүүлдэг онцлогтой.



ЖОНОН ХАМТЛАГИЙН “МОНГОЛZ”



Үндэсний хөгжмийн урлагийг орчин цагийн хөгжмийн хэв маяг, хэмнэлтэй хослуулан уран бүтээлээ туурвидаг “Жонон” хамтлаг 2006 онд байгуулагдсан.

Тус хамтлаг “Хаадын хишиг”, “Зөн” цомогтоо багтсан “Өвөл”, “Тань руу нүүж явна”, “Ариун дагшин”, “Монголz” бүтээлээрээ сонсогчдын танил болсон юм. Тэдний бүтээлд эх орон, газар нутаг, монгол ахуй, зан заншлаа хадгалж хамгаалъя гэсэн санаа шингэсэн байдаг. Үүний нэг илрэл нь “Монголz” хэмээх бүтээл билээ.

Жонон хамтлаг “Монголz” бүтээлдээ монгол хөгжмийн уламжлалт төрлүүдийг орчин үеийн хөгжмийн хэл найруулга, арга барилтай чадварлаг хослуулсан байдаг. Энэхүү бүтээлээ Ардын жүжигчин уртын дуучин Ш.Чимэдцэээтэй хамтран бүтээжээ.



- Жонон хамтлагийн “Монголz” бүтээлийг сонсоцгооё.
- Энэ бүтээлд буриад ардын “Баавай Чингис” дууг ашигласан байдаг. Ноот бичлэгийг ажиглаад ноотоор дуулаарай.

Удаан



- Буриад ардын “Баавай Чингис” дуунаас гадна та нарын сайн мэдэх хотгойдын бэсрэг уртын дууг мөн ашигласан байгаа. Энэ ямар дуу болохыг сонсож, ноотоор дуулж тодорхойлоорой.

Д



- Ардын дуу хөгжмийн төрлүүд болон зэмсгүүдийг сонсож тодорхойлоорой. Дараах үсгүүдээр үг бүтээж уншаад, тайлбарлаарай. Эдгээр үгсээс тус хамтлаг ардын хөгжмийн уламжлалт ямар төрлүүдийг энэхүү бүтээлдээ ашигласныг олж мэдээрэй.

мгөхжи, өйхимө, ртыну уду, билмэ, тагя, умонруихр, өбрөмб, тигра,

Жишээ нь: өйхимө – хөөмий. Хөгжмийн зэмсэг үл хэрэглэн уруул, тагнай, хамар, багалзуур хоолой зэрэг өгүүлэх эрхтнүүдээр олон эгшгийн давхцал бүхий аялгууг гаргах төрөл гэх мэт.





- Хөгжимдөх арга маяг, зэмсгүүдийн өнгө дуурьсал хэрхэн нийцэж байгааг анхаарч сонсоорой.
- Хөсөгтөн хамтлагийн дуулсан Монгол ардын “Самгалдай”, “Алтаргана” дуунуудыг ноотоор дуулцгаая.
- Шүлгийн утгыг ярилцаарай.

ХӨСӨГТӨН ХАМТЛАГИЙН “САМГАЛДАЙ”, “АЛТАРГАНА” ДУУНУУД

Анирлангуй хөгжим буюу этник, баллад чиглэлээр уран бүтээлээ голчлон туурвидаг “Хөсөгтөн” хамтлаг ардын дуу хөгжмийн язгуур ая данг хадгалан уран бүтээлдээ өргөн ашигладаг. Үүний нэгэн тод жишээ бол “Самгалдай”, “Алтаргана” хэмээх дуунууд билээ. Тэдний дуулсан, “амьдралыг чухам аль талаас нь харахаас шалтгаалж утга учир нь өөр байдаг” гэх гүн ухааны агуулгатай цаатан ардын дуу “Самгалдай”, урт удаан оршихуйн бэлгэдэл болсон Алтарганы нэрээр нэрлэгддэг буриад зоны ардын дуунууд нь гитарын хамсраатай, сургаал хүүрнэлийн балладын өнгө төрхийг өөрийн эрхгүй санагдуулна. Энэхүү бүтээлдээ ардын дууг дуулах сэтгэлгээний донж маягийг цохиур хөгжмийн өргөлтөт хэмнэл, хөөмийн өнгө дуурьсал, гитар болон үндэсний хөгжмийн зэмсгүүдийн тембр, хөгжимдөх арга барилтай нягт уялдуулсан юм. Энэ утгаараа хамтлагийн арга барил, туурвисан уран бүтээл нь өнгөрсөн одоо ирээдүйг холбох амьд сэжим болдог.



Этник - Этник гэдэг үгээр ихэвчлэн дуу хөгжмийн язгуур ая данг хадгалсан соёлыг томьёолон тодорхойлдог.

Баллада - Үлгэр домог ахуй амьдрал, түүхэн үйл явдлаас сэдэвлэн уянгалаг өнгө аясаар өгүүлнэ.



Цаатан ардын дуу

Самгалдай

Тайван

Буриад ардын дуу

Алтаргана

Дунд зэрэг



- Дээрх дуунуудын шүлгийн утга санааг ярилцаарай.


Самгалдай

Дэргэдээс нь хараад үзвэл
Дэгжин хээтэй самгалдай
Дэргэдээс нь хараагүй хүнд
Дэрс чулуутай гэх л байх даа

Алтаргана

Эбэри газара ургагшэ
Ишэ бүхэтэй Алтаргана
Элигэн дээрээ тэнжээсэн
Эжий аба хоёрни

- Эхлэн сонгосон бүтээл бол монголчуудын ардын дуу хөгжмийн уламжлалт ямар нэг бүтээл. Харин түүнийг судлан, өөрийн мэдрэмж, авьяас, ур ухаанаар боловсруулж шинэчилсэн уран бүтээлийн энэ аргыг юу гэж нэрлэвэл тохиромжтой вэ?
- Уламжлал шинэчлэл гэж чинийхээр юу вэ?
- Аливаа хөгжил дэвшил ямар арга замаар хийгддэг гэж бодож байна вэ?
- Энэхүү график зураглал чинийхээр юу илэрхийлж байна вэ?
- Энэхүү хөгжмийн бүтээлээс та нар уламжлал, шинэчлэл гэсэн санааг чухам юугаар нь мэдэрч байна вэ?



АЛТАН УРАГ ХАМТЛАГИЙН “ДАВАЛГАА”

Олон зууны тэртээгээс уламжлагдан ирсэн язгуур соёлоороо дэлхий дахинд танигдахыг бэлэгшээж хэсэг залуус “Алтан ураг” хэмээн хамтлагаа нэрлэн, 2004 онд нэгджээ. Тэд Монгол үндэсний хөгжмийн зэмсгүүдийн уламжлалт болон орчин үеийн дуугаралтыг хослуулан уран бүтээлээ туурвидаг.



Хамтлаг фолк рок чиглэлээр дагнан уран бүтээлээ туурвидаг ч тэдний зохиомжуудад этник, фолк метал, альтернатив, контемпорари болон бусад олон арга чиглэлүүд тусгалаа олсон байдаг.

Уран бүтээлд нь ёочин, морин хуур хөгжмийн зэмсгүүд голлох үүрэг гүйцэтгэх бөгөөд уртын дуу, хөөмийн элементээр баяжуулан эгшиглүүлдэг. Ардын өнгө аялгатай хөгжмийнхээ найруулгад рок хөгжим дэх хэмнэлийн арга барил, цахилгаан хөгжмийн дуугаралтыг хэрэглэж, өөрсдийн өвөрмөц стилийг тодорхойлсон. Ийнхүү шинэ үеийн залуусын хэрэгцээ, сонирхолд нийцэх язгуур хөгжмийн шинэ өнгө төрхийг бий болгохыг зорьсон. Энэ нь “Давалгаа” хэмээх бүтээлд нь биеллээ олжээ. Энэхүү бүтээл үндэсний өнгө аялгатай, нэлээд хурц тод өгүүлэхмжтэй.

“Давалгаа” гэх нэрийн утгыг гаргах мэт зэмсгүүд тодорхой дарааллаар хүч нэмэн, түрэн орж ирэх нь үнэхээр л агуу хүчит мөрөн тасралтгүй үргэлжлэн хуйларч, замдаа таарах бүхнийг бүрхэн хамах мэт сэтгэгдлийг төрүүлэх ажээ.

Фолк рок – ардын дуу хөгжмийн аялгуу, дуурьслыг боловсруулан баяжуулж, рок хэв маягаар найруулах үндсэн дээр бий болсон рок хөгжмийн чиглэл.

Фолк рок этник-?
Фолк метал-?
Альтернатив-?
Контемпорари-?

029

- Хөгжмийн зэмсэг бүрийн өгүүлэлмжийн шугамыг нарийн анхааралтай сонсоорой.
- Зураглалууд аялгууны шинж төрхийг хэрхэн илэрхийлж байна вэ?
- Хоорондоо эрс ялгаатай аялгууны зураглалууд хөгжмийн зохиолын агуулгатай хэрхэн холбогдох вэ?



Чөлөөт уран сэтгэмж



Сэтгэл зүйн тэсрэлт



Уянгын чиг шугам



Хүчтэй, тэнцвэртэй эрч хүч



- Алтан ураг хамтлагийн зэмсгийн бүрэлдэхүүнийг ажиглаарай. Хөсөгтөн хамтлагаас ямар ялгаатай байна вэ?
- Хөгжмөө анхаарч сонсоод, эгшиглэгээний онцлогийг тодорхойлон ярилцаарай.
- Өмнөх хичээл дээр үзэж танилцсан Алтан ураг хамтлагийн “Давалгаа” хэмээх этно рок чиглэлийн бүтээлтэй харьцуулаарай.

	Харьцуулах үзүүлэлт	Хөсөгтөн “Самгалдай”	Алтан ураг “Давалгаа”
1	Хамтлагийн хөгжмийн зэмсгийн бүрэлдэхүүн		
2	Эгшиглэгээний онцлог, ялгаа, өнгө дуурьсал		
3	Этно-фолк, этно-рок чиглэлийн онцлог ялгаа		
4	Илэрхийллийн арга хэлбэр		

БЁРТЭ ХАМТЛАГИЙН “ГОВЬ” ЗОХИОМЖ

“Бөртэ” хамтлагийн “Говь” зохиомжид амьд байгалийн өнгө дуугаралт (салхин исгэрээн, зэрэглээн мяралзаа, тэмээн буйлаа гэх мэт), үндэсний хөгжмийн зэмсгүүдийн эртний өвөрмөц хэв хийц, дуурьсал тусгалаа олжээ. Энэ бүтээл нь хүрээлэн буй орчин, монголчуудын амьдрал оршихуйн мөн чанар, хувь хүн болоод ертөнцийн зохицлыг мэдрүүлж, өв соёл, ёс заншлаараа баходан бахархах мэдрэмжийг төрүүлдэг. Үүгээрээ уламжлал болоод шинэчлэл, ардын болоод мэргэжлийн хөгжмийн илэрхийллийг гайхалтай хослуулсан зохиомж болсон юм.

Хөгжмөө сонсоцгооё.



- Зохиомжоо ардын хөгжмийн ямар төрлүүдээр илэрхийлсэн байна вэ?
- Хөгжмийн зэмсгүүдийг нэрлээрэй. Эдгээр зэмсгүүдийн тухай мэдээлэл цуглууларай.





- Энэ зохиомжийн дүрслэл илэрхийллийг тодруулахын тулд хэний, ямар дууг ашигласан бэ?

Moderato

6 Зах - гүй го - вийн ү - зэсгэ - лэн За ³ гийн шу - гүй нь
 12 ду - лаан хе Ду- лаан го - вийн ха-вар - жаан - даа Дуу - чин
 18 эзж минь *mp* суу - гаа даа Энэр-лийн дээ - дийг *f* ө - вөрлө - сен
 Эл - бэ - рэлт эзж минь тэ - мээ - чин *mp* Эзж минь тэ - мээ - чин

Саран зууртаа хоноглодог
Саруул.govийн цайдам хө

Цайдам.govийн зусландаа
Цайлган эзж минь суугаа даа



Бөртэ хамтлаг уран бүтээлээ этник чиглэлээр түүрвидгийн хувьд олон үндэстний ардын хөгжмийн зэмсгүүдийг бүтээл түүрвилдаа өргөн ашигладаг байна. Жишээ нь:

Диджериду (didjeridoo) - Хойд Австралийн уугуул иргэдийн зан үйлдээ хэрэглэдэг эртний үлээвэр хөгжмийн зэмсэг. Дэлхийн хамгийн эртний зэмсгийн нэг. Хулсаар хийдэг, 1-3 метр урттай, өвөрмөц хүнгэнэсэн дуутай, онцлог нь нэг л авиа эгшгийг дуугаргадаг. Харин үлээх арга техникээ өөрчлөх замаар янз бүрийн өнгө дуурьсал (тембр), хэмнэлийн зураглалыг гаргадаг ажээ.

Джэмбэ (djembe) - XII зуунд Африкт үүсч дэлхий даяар тархсан бөмбөр. Малигаас гаралтай. Их биеийг modoор хийж, ямааны арьсаар ихэвчлэн бүрдэг. Ойролцоогоор 60 см өндөртэй, тойргийн голч нь 30 см. Энэхүү зэмсгийг алгаар дэлдэн хөгжимддөг.



Т.Пүрэвсүх

АРГА БИЛЭГ ХАМТЛАГИЙН “СЭТГЭМЖ”

“Арга билэг” хамтлаг уран бүтээлдээ этник хөгжим хийгээд фьюожн хэв маягийг хослуулан джазын онцлог дуугаралтыг бий болгожээ.

Энэхүү хамтлагийн толилуулсан бүтээлүүд дотор “Сэтгэмж” нэртэй нэгэн зохиол бий. Гялалзсан, цоглог, тэгснээ гэгээлэг мөрөөдөнгүй аялгуутай энэхүү бүтээл үндэсний хөгжмийн зэмсгээр уламжлалт болон шинэлэг арга барил, джазын хэмнэл, элементүүдийг чадварлаг хослуулсан өвөрмөц шийдэлтэй. Энэхүү зохиолын даралтат хөгжмийн хувь, ялангуяа импровизацийн (шууд зохиомжлон тоглох) хэсэг нь хамтлагийн этно джаз стилийг тодорхойлох гол хэсэг болдог.



Уг сэтгэмж З хэсгээс бүрдэх бөгөөд дунд хэсэг нь захын хэсгүүдтэй ялгарамж үүсгэдэг.



Хөгжмийн зэмсгүүдийн дуугаралтын боломж, джаз хэв маягаар хөгжимдөх арга хэлбэрийг тус бурд нь ээлжлэн сэлгэн таниулсан.

О31

- Уламжлалт болон джаз хэв маягаар хөгжимдөх арга барилыг хэрхэн хослуулсныг сонсоорой.
- Захын хэсгүүдэд ямар хөгжмийн зэмсэг голлох үүрэгтэй байна вэ?
- Хэмнэлээр хөгжимдөөрэй.



АГУУ ИХ ӨВ СОЁЛ МОНГОЛЧУУДЫН БАХАРХАЛ

Уран тансаг аялгуу, давтагдашгүй ур ухаан, арга барилаараа гайхамшигтай монгол ардын дуу хөгжмийн уламжлалт урлаг бол Монгол үндэстний авьяас чадвар, нүүдэлчдийн өвөрмөц соёл уламжлал, зан заншлын тусгал билээ. Дэлхийн хэмжээнд бид уртын дуу, морин хуур, цуур, тууль, бий биелгээ, хөөмий, лимбэний битүү амьсгаа гэсэн энэ олон төрлөөрөө гайхагдаж, хүн төрөлхтний биет бус соёлын ховор хосгүй өвийн санд бүртгэгдсэн. Энэ их өв соёлыг эзэмших, хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх хариуцлагатай үүрэг хүүхдүүд та нарт ноогдоно. Агуу их өв соёлоороо монголчууд бахархаж байна.



МЭДЛЭГЭЭ СОРЫЦГООЁ

1. Аль нь үндэстэн угсаатны бий биелгээнд хамаарахгүй вэ?
 - а. Хотон бий
 - б. Баяд бий
 - в. Захчин бий
 - г. Жалам хар
2. Ерөөл магтаал аль төрөлд хамаарах вэ?
 - а. Монгол ардын дуулах урлаг
 - б. Хөгжимт аман зохиол
 - в. Өгүүлэх эрхтний шүтэлцээт урлаг
3. Монгол ардын дан хөгжмийн бүтээлийг олоорой.
 - а. Жороо морины явдал
 - б. Хөөмий
 - в. Алтайн магтаал
4. Өгүүлэх эрхтний шүтэлцээт урлагт ямар төрлүүд багтдаг вэ?
 - а. Монгол уртын дуу, ардын богино дуу
 - б. Ерөөл, магтаал, туульс
 - в. Хөөмий, цуур, исгэрээ
5. Бүжигтэй хамт хөгжсөн дан хөгжмийн бүтээлийг олоорой.
 - а. Татлага аяз
 - б. Монгол уртын дуу
 - в. Бий биелгээ
6. Монголчуудын аливаа ёслол хүндлэлд сайн сайхныг бэлгэдэн аялгуулан шүлэглэж хэлдэг төрөл юу вэ?
 - а. Магтаал
 - б. Ерөөл
 - в. Тууль
7. Гурвуулаа зөв байх хувилбарыг олоорой.
 1. Их уулсын эзэн сахиус, ихэс дээдсийг хүндлэн тахих заншлаас үүссэн уламжлалт төрөл
 2. Домгийн сэдэвтэй, тухайлсан өгүүлээмж дүртэй, найраглал мэт урт, товшуур болон хуураар хамсран хөгжимдөх төрөл
 3. Монголчууд аливаа ёслол хүндлэлд сайн сайхныг бэлгэдэн аялгуулан шүлэглэж хэлдэг төрөл
 - а. Магтаал
 - а. 1в 2б 3а
 - б. Ерөөл
 - б. 1а 2в 3б
 - в. Тууль
 - в. 1б 2а 3в
8. Ерөөл, сургаал үг хоёрын адил тал нь юу вэ?
 - а. Хөгжмийн зэмсэгтэй хамсардаг
 - б. Аялгуулан хэлдэг, хөгжимт аман зохиолын төрөлд багтдаг
 - в. Бэлгэ дэмбэрлийн үгтэй
9. Хөөмий, цуур хоёрын адил тал нь юу вэ?
 - а. Аль аль нь хөөмийлдөг
 - б. Хөгжмийн зэмсэг хэрэглэдэг
 - в. Үг, шүлэгтэй
10. нь ихэл болон морин хуур хөгжмийн хоёр чавхдасыг зүүн гараар нэгэн зэрэг давхар эгшиг үүсгэж хөгжимддөгөөрөө онцлогтой.
 - а. Жудар
 - б. Татлага
 - в. Монгол уртын дуу
 - г. Бий биелгээ
11. Гурвуулаа зөв байх хувилбарыг сонгоно уу?
 1. Монгол ардын дуу
 - а. Алтайн магтаал
 - а. 1а 2б 3в
 2. Бий биелгээ
 - б. Боодготой сэвгэр
 - б. 1б 2в 3а
 3. Хөгжимт аман зохиол
 - в. Торгуудын “Жудар”
 - в. 1в 2б 3а



2.2. ДУУЛЪЯ

Найралжуулгыг У.Мөнхжаргал

ЁОХОР

(Буриад ардын дуу)

Хөгжилтэй

Сопран

Той - рон байж ха - тар - ъя (aa)

Альт

То - хойн чи - нээ га - зар - таа той - рон байж ха - тар - ъя
Тол- гой дээ-рээ го - ёл - той хан-чир ян-чир ха - тар - ъя

C

Эр - гэл - дэн наад - ъя элд - вээ - рээ зу - гаац - ъя

A

Эр - гэл - дээд наад - ъя /aa/ зу - гаацъя

C

Муш - ги - рал - дан наад - ъя /aa/ мэд - дэ - гээ - рээ зу - гаацъя

A

аа хэй мэд - дэ - гээ - рээ зу - гаацъя

Гэрийн чинээ газартаа
Гишгэн байж хатаръя
Гэзгэн дээрх гоёлоо
Ханчир янчир наадъя

Шилтэй мөнгөн эмээлээ
Сэлгүүл цааш нь мориндоо
Шилдэг сайхан насандаа
Сурья цааш нь сургуульдаа





- Хоолойн дасгалыг дуулахдаа богино тасалдангуй тод хэлж дуулна. Зогсцыг анхаараарай.
- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийг ажиглаад ярилцаарай.
- Хүчдэлийн тэмдгийг зөв илэрхийлэн дуулаарай.



Найралжуулгыг У.Мөнхжаргал

ТООХУУ НЭГЭН ГОС

Vivo

Сопрано

Альт

Too - хуу нэ - гэн тоо - хуу нэ - гэн тов тов тов тов Too-huu нэ - гэн гос нь *mp*

C

A

Тов хий - гээд байна даа хө Тор-гууд нэ - гэн сэв - гэр тол-гой до - хиод байна даа хө

Тов тов тов Тор-гууд нэ - гэн сэв - гэр до - хиод бай - наа.

Их л дэлтэй цэнхэр нь
Ижлээ гээд л байна даа хө¹
Их л жасын нярав гуай
Намайг гээд л байна даа хө

Жижиг цэнхэр морь нь
Жиргэж хатриад байна даа хө
Жил л нэгтэй тэр минь хө
Намайг гээд л байна даа хө

Өл халzan тайлаг нь
Өвдөг сөгдөөд байна даа хө
Өөлдөөл оёсон гос нь
Өсгий холгоод байна даа хө



- Төгсгөлийн айзамд дээд хоолой аялгуу дуулахад II, III хоолой сайтар сонсож, хэмнэл болон үгийг нийцүүлж хэмжээг зэрэг гүйцэтгээрэй.



“Tooxyu gos” - Монгол хэлний тайлбар толь ашиглан утгыг тайлбарлаарай.





- Хоолойн дасгалыг ноотоор зөв, цэвэр, намуухан дуулаарай.

3/4 time signature, treble clef. The notation consists of two measures of eighth notes and sixteenth notes.

- Альт хоолойн наймт ноотуудыг ямар үг, үе ашиглан дуулбал тохиромжтой вэ? Ярилцаарай.
- Дууны ноот бичлэгт тусгайлан тэмдэглэсэн хэсэгт хоёр хоолой хоорондоо ямар зайд дуулж байна вэ?
- Хоёр хоолой ямар чиглэлд хөгжиж байна вэ?

Найралжуулгыг Я.Алтансувд

БУЛИГААР ХҮРЭН ЦҮНХ
(Захчин ардын дуу)

Сэргэлэн

C: Buruu - daa dэл - тэй у - лаанд нь ___ Мөс нь ___
A: (Red box highlights the first measure of the A part.)

C: шар - гиад байна даа хө ___ Були - гаар хү - рэн
A:

C: (Red box highlights the second measure of the C part.) цүн - хэнд нь ___ чи - хэр ___ шар - гиад байна даа хө ___
A: (Red box highlights the second measure of the A part.)

Сайвар улаан моринд нь
Мөс нь шаргиад байна даа хө
Савхин хүрэн цүнхэнд нь
Чихэр шаргиад байна даа хө

Шингэн дэлтэй улаан нь
Ширгэн дээр ч байлгүй яах вэ хө
Шинэхэн найзын өвөрт нь
Чихэр ч байлгүй яах вэ хө



- Ноот бичлэгт тусгайлан тэмдэглэсэн хэсгийг гэсэн богино үеэр хөнгөн, тасалдангуй, цэвэр дуулаарай.
- Эхлэл болон төгсгөл хэсгийн 2 хоолойн хөдөлгөөнийг ойлгож дуулаарай.





Найралжуулгыг Ц.Түмэнбаяр

НАРСАН МОД
(Үзэмчин ардын дуу)

Andante cantabile

C Нар-сан мо-дыг та-рих - даа на-ма-гий нь ава - хаар тарь-сий - маа

A

C хө Нялх Шан-ши-рыг ес- гөх- дөө Нaa - даж хөөр-хөө

A

C бод - сий - маа 1, 2. Coda хө хө.

A

Үзмийн модыг тарихдаа

Үрийг нь авахаар тарьсан юмаа хө

Үр Шанширыг өсгөхдөө

Үнсэж таалахаа бодсон юмаа хө

Алимын модыг тарихдаа

Алимыг нь авахаар тарьсан юмаа хө

Алиа Шанширыг өсгөхдөө

Ачийг нь авахаа бодсон юм аа хө

Чавгын модыг тарихдаа

Чавгыг нь авахаар тарьсан юмаа хө

Цэвэрхэн Шанширыг өсгөхдөө

Хүчийг нь авахаа бодсон юм аа хө



- Дууны ноот бичлэгийг ажиглаад, айзмын өөрчлөлтийг анхаарч ноотоор аялаарай.
- Нуман холбоостой хэсгийн угийн хуваарилалтыг анхаарч дуулаарай.

Andante cantabile – Тайван дуулалтай*Coda* – төгсгөл

Хоолой салгаж дуулахад юуны өмнө хоолой тус бүр өөрсдийн хувийг (парт) маш сайн сурсан байх, хоёрдугаарт бусад хоолойг сайтар сонсож түүнтэй нэгэн хэмжээнд тэнцвэртэй хүчээр нийцэж дуулахыг анхаар!





- Хоолойн дасгалыг ноотоор дуулаарай.
- Цэгтэй ноотны хэмжээг ярилцаад гүйцэд, зөв дуулж илэрхийлээрэй.

Найралжуулгыг Я.Алтансувд

БООДОГТОЙ СЭВГЭР

(Торгууд ардын дуу)

C
Ца - гаан - тай тэ - мээ нь а - чаа - н чи - мэг

A
Цав - чиг - тай сэв - гэ - рүүд гэ - рийн чи - мэг

Ингэтэй тэмээ нь ачаан чимэг

Ижилхэн сэвгэрүүд гэрийн чимэг

Торомтой тэмээ нь ачаан чимэг

Тоорцогтой сэвгэрүүд гэрийн чимэг

Ботготой тэмээ нь ачаан чимэг

Боодогтой сэвгэрүүд гэрийн чимэг

Цавчиг – Үсний чимэг
Сэвгэрүүд – Охид
Боодогтой – Үсээ боосон



- Эхлэл хэсгийн наймцын (октав) үсрэлт дээр анхааралтай, сонсож дуулаарай.
- III хоолой дээд хоолойнуудын дуулалт аялгуунд “дү-дү” гэсэн богино үеэр ялгарамжтай хамраа хийж дуулна. Иймд бусад хоолойг анхааралтай сонсож, нийцэлтэй дуулаарай.





- Дасгалыг дуулахдаа нуман холбоосуудын ялгааг ярилцан, үүргийг тодорхойлоорой.
- Зогсцыг мэдэрч зөв дуулаарай.

Ая. Г.Эрдэнэчулун

Үг. С.Буджав

НАРНЫ ХҮҮХДҮҮД ДУУЛЖ БАЙНА

Allegro

Хур - га иши - гэнд дэг - дэж ес - сөн Хуйв - тай
шил - бүүр у - нах ес - сөн Хүл - гийн зоон дээр дэр - вэж ес - сөн
Хө - мүүл таа - нанд хөл - бөрч ес - сөн на - ранд оир - хон
нут - гийн - хая Нам - хан тол - го - дыг дуул - наа Тэн - гэрт оир - хон
тер - сөн тэ - нүүн за - я - гаа дуул - наа Го - вийн хүүх - дүүд
дуулж байна ээ 1. Говь тал - даа дуулж байна
2. Говь тал - даа дуулж байна

Хууртай найранд дуулж өгсөн
Хултай айраганд дэмбээдэж өссөн
Дэлгэр наадамд магнайлик өссөн
Дээлтэй өвгөдөө хүндэлж өссөн

Монгол ёсоо дээдэлж өссөн
Морин хуураа татаж өссөн
Өв соёлоо эрхэмлэж өссөн
Өлзий билгийг шүтэж өссөн



- Тусгайлан тэмдэглэсэн төгсгөлийн хэсгийг хэрхэн дуулах вэ?
1. _____ 2. _____ тэмдгийн үүргийг ярилцаарай.





- Ноот бичлэгийг ажиглаад угтвар айзмыг 6/8 схем ашиглан эхлэлийг зөв гүйцэтгээрэй.
- *mp, mf* тэмдгүүдийн үргийг ярилцаад, зөв илэрхийлж дуулаарай.
- Амьсгааны эхний тэмдгийг ажиглаад дараагийн амьсгаа авах хэсгүүдийг тодорхойлж тэмдэглээрэй.

Ая. С.Батболд

Үг. Θ.Баасанжав

ӨГЛӨӨ
(Хүүхдийн дан найрал дуу)

Тэмүүлэлтэй

6

mp *Yy - рийн* *гэ - гээ* *Yy- рийн гэ - гээ* *цай - хад* *тэнгэ-*

mf *- рийн* *ха - яя* *тэн - гэ* *рийн ха - яя* *шуу - лаа* *Өг -*

10

- лөө *бол - лоо* *я - мар* *таа - тай* *вэ?* *Өг -*

- лөө *ег - лөө* *бол - лоо* *ег - лөө я - мар* *таа - тай* *таа - тай* *тая - тай* *Өг -*

14

- лөө *е - лөө* *бон - лоо* *Yy - рийн* *гэ -*

- лөө *ег - лөө* *ег - лөө* *бон - лоо* *Yy - рийн* *гэ -*



18

1.
2.

- гээ цай - лаа _____ тэнгэ - /лаа _____
- гээ цай - лаа _____ /лаа _____

Тэнгэрийн хаяа тэнгэрийн хаяа наашлахад
Өглөөн наран өглөөн наран мандлаа
Өглөө боллоо ямар таатай вэ?
Тэнгэрт наран мандлаа



2.3. ХӨГЖИМДЬЕ

Буриад ардын дуу

ЁОХОР

Moderato

Moderato

8





- Нoot бичлэгийг ажиглаарай. Ижил хэсэг байна уу?
- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийн хэмнэлийг анхаараарай.
- Хоёр хоолойгоор хөгжимдэж байгаа хэсэгт анхаарч, талд найгах цагаан уул цэцгийг дүрслэн илэрхийлж хөгжимдөөрэй.

Роджерс Ричард

ЦАГААН УУЛ ЦЭЦЭГ

Andante



- Цагаан уул цэцэг зохиолын өнгө аясад хүчдэлийн тэмдгүүдийн аль нь тохиромжтой вэ? Ярилцаарай.

f, mf, p, pp, mp, ff



- Хөгжимдөхийн өмнө доорх хэмнэлүүдийг давтаарай.

a. b. c. d.

- Амьсгааны тэмдгийг анхаарч хөгжимдөөрэй. Наймцын (октав) үсрэлттэй эгшгүүд хаана байна вэ?
- Тэмдэглэсэн хэсгийн ноотыг ажиглаад, давталт болон ялгарамжийг олж ярилцаарай.

С.Фостер

Moderato


СУВАННИ ГОЛ





b


З ТЭМДЭГТЭЙ ДЭВСГЭР ХӨГД ХӨГЖИМДЬЕ



Ля бемоль эгшиг-*Ab*



До минорын эгшгийн цуваа




- Дасгалыг хөгжимдөхийн өмнө эхний айзмыг анхааралтай ажиглаарай. Хэд дэх хувиас эхэлж байна вэ?
- Ямар ямар эгшгүүдийг *b*-ийн тэмдэгтэй тоглох вэ?





F # G# A H C# D E



Соль диез эгшиг-G#



- Аялгууг хөгжимдөхдөө тэмдэглэсэн хэсгийг анхаараарай.

Moderato



Баяд ардын бүүвэйн дуу

ЭХИЙН ДУУ

.....?



Ая. Ц.Намсрайжав

ХАЛУУН ЭЛГЭН НУТАГ



Largo

Musical score for three instruments: two flutes and a keyboard instrument. The score consists of four staves. The first two staves are for flutes in treble clef, 3/4 time, and G major. The third staff is for a keyboard instrument in bass clef, 3/4 time, and G major. The fourth staff continues the keyboard part. Measure numbers 1 through 5 are indicated above the staves.

